

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-7

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 8-64

-
- 1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ 8-55
- 2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ 55-64

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны
12 дугаар сарын 10-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Ч.Ундрам ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 68.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 19 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Г.Дамдинням, О.Саранчулуун;
Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар.

Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа оролцов.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Соноор, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Эдийн засаг, хөгжлийн яамны Технологи, инновацын шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтсийн дарга Б.Урьболд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга А.Даваажаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Залуучуудын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Батдорж, ахлах шинжээч Н.Болормаа, Төсвийн нэгтгэл, төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан ахлах шинжээч Т.Ууганбаяр, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга О.Баттулга, мөн хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Цэрэнболд, Кино урлагийг дэмжих зөвлөлийн дарга Ч.Ундрал, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн, Б.Найдалаа, Д.Рэгдэл, Ц.Мөнхтуяа, С.Эрдэнэбат, Ж.Галбадрах, Д.Бум-Очир, О.Батнайрамдал, Г.Хосбаяр нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр, Сангийн сайд Б.Жавхлан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Эдийн засаг, хөгжлийн яамны Технологи, инновацын шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтсийн дарга Б.Урьболд, Кино урлагийг дэмжих зөвлөлийн дарга Ч.Ундрал нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ч.Ундрэм: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Улаанбаатар хотын төвлөрлийг задлах зорилгоор Улаанбаатар хотод байрлаж байгаа хувийн сургуулиудын хувьсах зардлыг 38.5 тэрбум төгрөгөөр бууруулж, хөдөө орон нутгийн дотуур байрны хангамжийг сайжруулах, нийслэл дэх сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Боловсролын сайд П.Наранбаяр үг хэлэв.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 11
Бүгд: 12
8.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Ч.Ундрэм: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Боловсролын сайдын төсвийн багцын Төсвийн нийт зардал хэсэг дэх бараа үйлчилгээний бусад зардал 21.09.01-ийг бууруулж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 21.08.01 рүү шилжүүлэх замаар боловсролын салбарын багш, ажилтны 8-10 хувьд нь ажлын байрны эрсдэлд суурилсан хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх, 4 тэрбум төгрөг гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа, Боловсролын сайд П.Наранбаяр нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно. /12:06/

Ч.Ундрэм: Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Х.Болормаа, М.Сарнай, А.Ундраа, М.Нарантуяа-Нара, С.Эрдэнэбат, Ч.Лодойсамбуу, М.Энхцэцэг, Т.Мөнхсайхан, П.Батчимэг нарын гаргасан, Үндэсний аудитын газрын дүгнэлтээр зураг, төсөвгүй, төслийн шаардлага хангаагүй 4 арга хэмжээний нийт 99.2 тэрбум төгрөгөөс 2 арга хэмжээ буюу “Төрийн албан хаагчдын орон сууцжуулах цогц хөтөлбөр 1 дүгээр үе шат, бүсүүдэд” гэсэн зардлын 30 тэрбум төгрөг, мөн “Гадаргын ус хуримтлуулах, хөв, цөөрөм байгуулах, Баруун бүс” гэсний дүнгээс 1.4 тэрбум төгрөг, нийт 31.4 тэрбум төгрөгөөр бууруулж, цэцэрлэг, сургууль, дотуур байрны

хүүхдийн хоолны материал худалдан авах зардалд нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Ч.Ундрэм: Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнгийн гаргасан, Төслийн хавсралт 16.Гадаадад суралцагсдын зардлаас 19 тэрбум 595 сая 800 мянган төгрөгийг хасаж, Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтыг дэмжих санд 11 тэрбум төгрөг, Боловсролын зээлийн санд 8 тэрбум 595 сая 800 мянган төгрөгийг тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн, Боловсролын сайд П.Наранбаяр нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно./12:19/

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат Боловсролын салбарын гүйцэтгэлийн үнэлгээний санхүүжилтээс 88 тэрбум төгрөг хассаныг хэвээр нь үлдээж, өндөр төлбөртэй хувийн сургуульд олгож байгаа хувьсах зардлыг эсвэл зураг төсөвгүй хөрөнгө оруулалтаас хасах гэсэн санал гаргав.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Байнгын хорооны дарга Ч.Ундрэм нар үг хэлэв.

Байнгын хорооны дарга Ч.Ундрэм дээрх саналыг хасуулах зүйл, заалт тодорхойгүй санал хураалт явуулах боломжгүй талаар хэлж, санал хураалтыг явуулаагүй болно.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Эдийн засаг, хөгжлийн яамны Технологи, инновацын шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтсийн дарга Б.Урьболд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга А.Даваажаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Залуучуудын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Батдорж, ахлах шинжээч Н.Болормаа, Төсвийн нэгтгэл, төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан ахлах шинжээч Т.Ууганбаяр, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга О.Баттулга, мөн хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Цэрэнболд, Кино урлагийг дэмжих зөвлөлийн дарга Ч.Ундрал, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, саналт гараагүй болно.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ч.Ундрал: Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очирын гаргасан, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат үг хэлэв.

Төслийн 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа үг хэлэв.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ч.Ундрам: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Тогтоолын төсөлд шинээр 4 дүгээр зүйлийг нэмэх:

4.Боловсролын салбарт зарцуулах төсвийг нэмэгдүүлэх, Нэгдсэн үндэсний байгууллагаас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилго 2030, Боловсрол 2030, Инчоны тунхаглалын зорилтыг хэрэгжүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ хамгамжийг сайжруулах, багш, ажилтны хөдөлмөрийн нөхцөлийг шинэчлэн тогтоох, цалин хөлсийг тооцох шинэ аргачлал нэвтрүүлэх, нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

4.1.2026 оны төсвийн жилээс эхлэн боловсролын салбарын төсвийн нийт зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 6 хувиас багагүй эсвэл улсын төсвийн нийт зардлын 18 хувиас багагүй байхаар тооцон боловсруулж, өргөн барих;

4.2.Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл ахуйн зардлыг холбогдох хуулийн дагуу дараа жилийн төсөвт суулгаж өгөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрахын санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 13 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 77.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ч.Ундрам: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Тогтоолын 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “а” заалтаас “Боловсролын салбарын нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар санхүүжих арга хэмжээ, сургууль, цэцэрлэг дотуур байрны хоолны материал худалдаж авах” гэснийг хасаж, “Гадаад, дотоодын их, дээд сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургуулийн суралцагчид тэтгэлэг олгох, төрийн өмчийн их, дээд сургуулиудын тогтмол зардлыг төлөх, боловсролын салбарын ажилтнуудыг чадавхжуулах, сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж олгох, олимпиад зохион байгуулах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Ч.Ундрам: Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтад Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн 2024 оны зарцуулаагүй үлдэгдлийг 2025 оны төсвийн эх үүсвэрт зарцуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрахын санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 13 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Ч.Ундрaм: Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очирын гаргасан, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хүрээнд Кино урлагийг дэмжих сангийн 2024 оны зарцуулаагүй үлдэгдлийг 2025 оны төсвийн эх үүсвэрт зарцуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Ч.Ундрaм: Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр бүлэг, 3 дахь заалтаас сургууль, цэцэрлэг, дотуур байрны хоолны материал худалдаж авах гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 38 минут үргэлжилж, 16 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 76.2 хувийн ирцтэйгээр 12 цаг 57 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Ч.УНДРАМ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
09 цаг 19 минут.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ч.Ундрам: Чөлөө авсан байна. Дамдинням гишүүн өвчтэй, чөлөө авсан, Саранчулуун гишүүн өвчтэй, чөлөө авсан. Алтаншагай гишүүн байхгүй байна. Батнайрамдал гишүүн байхгүй байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2024 оны 12 сарын 10-ны хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1-д, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд. Засгийн газар 2024 оны 12 сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

2-т, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд гэсэн ийм 2 асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Батнайрамдал гишүүн ирсэн байна. Нэмж ирцэд бүртгэе.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга. Энэ Сангийн яамныхан ирсэн юм уу? Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Золбоо

Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Сонор Сангийн яамны Санхүү бодлогын газрын дарга, хаана байна? Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Энхболд нь ирээгүй байна. Золбоо нь байгаа юм уу? Түрүүн Санжаадорж дарга байсан, тийм ээ. Тэлмүүн байсан уу? Тэлмүүн байхгүй. Золбоо байхгүй. Ганбат байхгүй. Сангийн яамны дарга нарыг хүлээе.

Бусдыг нь танилцуулж байя. Тэгээд танилцуулаад дуусахад ирээгүй байх юм бол хүлээхээс өөр арга алга.

Дэлгэржаргал дарга байна уу? Сангийн яамны. Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын дарга, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Батмөнх ирээгүй байна. Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Ичинноров ирсэн байна. Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ ирсэн байна. Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг ирсэн байна. Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Отгонцэцэг. Энэ нэг адилхан албан тушаал байна шүү дээ. Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох ирсэн байна.

Монгол Улсын Үндэсний аудитын газар Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Самбууням, Самбууням дарга ирсэн. Тийм. Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Наранчимэг ирсэн байна. Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал тэргүүлэх, аудитор Энхболд ирсэн байна. Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер Энхтуяа. Ирээгүй байна.

Боловсролын сайд Наранбаяр ирсэн байгаа. Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал дарга ирсэн байгаа. Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Батцэцэг ирсэн байгаа. Боловсролын ерөнхий газрын дарга Ням-Очир ирсэн байгаа.

Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засаг, шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлогын газар Баттогтох ирээгүй байна. Дуудаарай. Эдийн засаг, хөгжлийн яамны Технологи, инновацын шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтсийн дарга Урьболд ирсэн байна. Даргаа дууд. Баттогтох даргаа дуудаарай.

Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Номин ирсэн байгаа. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Даваажаргал хаана байна. Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Баттулга дарга ирчихсэн байсан. Биеийн тамир, спортын улсын хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Цэрэнболд ирчихсэн байна. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Отгонбат ирсэн байна. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Залуучуудын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Батдорж ирсэн байна. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төсвийн нэгтгэл, төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан ахлах шинжээч Ууганбаяр ирсэн байна. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Болормаа ирсэн байна. Кино урлагийг дэмжих зөвлөлийн дарга Ундрал ирсэн байна.

Сангийн сайд юм уу, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2.-ын 1-ийг ирэхээр эхэлмээр байна. Яагаад гэвэл гишүүд заавал яг энэ Байнгын хороотой холбоотой биш. Сангийн яамтай, татвартай холбоотой асуудлууд

асуугаад байгаа байхгүй юу. Байнгын хороод дээр. Тийм учраас төрийн нарийн аа юм уу, сайдаа дуудаж ирүүлмээр байна. Тэгэх үү, гишүүд ээ.

Сангийн сайд Жавхлан ирсэн байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан: Гишүүдээс уучлалт хүсье. Жоохон хоцорчихлоо, уучлаарай.

Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр хэлэлцэн баталсан бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэл дээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр төсөвт бүхэлд нь хориг тавьсан.

Үүнээс хойш Улсын Их Хурал нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээн авч, алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсний дагуу Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг шинэчлэн боловсруулж, дахин өргөн барьсан.

Төсвийн төсөлд зардлыг бууруулахад дараах зарчмуудыг баримталлаа.

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, нийгмийн халамжийн сангаас олгох хүүхдийн мөнгөн тэтгэмж, халамжийн тэтгэвэр, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, асаргааны тэтгэмж, түүнчлэн төрийн албан хаагчийн цалин хөлс болон тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, мөн гадаад зээлийн үйлчилгээний төлбөр, мөн хуульд заасны дагуу Улсын Их Хурлын ХЗБХ-ноос төсвийг нь хянаж, жилийн төсөвт тусгуулахаар ирүүлсэн байгууллагууд болон ХЭҮК зэрэг байгууллагуудын урсгал зардлыг өмнөх үлдэгдлээр хэвээр нь орууллаа.

Төсөвт байгууллагын үйл ажиллагааны зарим зардлыг дараах байдлаар 10-100 хувь бууруулна.

А. Салбар харгалзахгүйгээр бүх төсөвт байгууллагуудын тавилга, эд хогшил, худалдан авалт, сургалт семинар, хурал зөвлөгөөн хийх, биеийн тамирын уралдаан, тэмцээн зохион байгуулах, гэрээт ажилтан ажиллуулах, дуудлагын автомашин, үзлэг, зөвлөл, хороо, комиссын гишүүний урамшууллын зардлыг 100 хувь бууруулах,

Б.Соёлын эрхийн бичиг, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, Кино үйлдвэрлэлийг дэмжих сан, Засаг захиргааны нэгж, төрийн захиргааны байгууллагыг үр дүнгээр шагнах, урамшуулах, идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих болон эрүүл идэвхтэй амьдрал хөтөлбөрийн зардлыг 100 хувь бууруулна,

В.Эрүүл мэнд болон тусгай чиг үүргийн байгууллагаас бусад бүх байгууллагын тээвэр, шатахууны зардал, төрийн өндөр дээд айлчлал болон гаднын өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албан томилолтын болон зочин төлөөлөгч хүлээн авах зардал, эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль зүй, дотоод хэргийн салбараас бусад салбарын дадлага, бэлтгэл, сургуулилт хийх зардал, бүх шатын төсвийн байгууллагын дотоод албан томилолт, бичиг хэргийн зардал, багаж, техник хэрэгсэл худалдан авах зардлыг тус бүр 50 хувиар бууруулна.

Дээр дурдсан 5-100 хувь бууруулах зардлуудаас гадна байр ашиглалтын зардал, хангамж, бараа материал, нормативт эм бэлдмэл, нормын хувцас, хоол, урсгал засвар, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас, шилжүүлэг, эргэж төлөгдөх зээл, бараа, үйлчилгээний бусад зардал, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэмжээ, боловсролын тэтгэлэг, авто зам, гүүрэн байгууламжийн засвар, ашиглалтын зардлыг 10 хувиар тус тус бууруулъя.

3.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан төсөл, арга хэмжээнээс гэрээ байгуулсан ажлыг эхлүүлсэн төслүүдийг дуусгана.

Харин гэрээ байгуулаагүй ажил эхлээгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрэмбэлж хойшлуулна

5.Зарим эх үүсвэр, ТЭЗҮ, зураг төсөв, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг бууруулж, хэлэлцээрийн шатад байгаа төслийг хойшлуулна.

6. Гадаад зээлийн ашиглалтыг бууруулж, хэлэлцээрийн шатад байгаа үндэсний хиймэл дагуулын төсөл болон бусад төслийн зээлийн ашиглалтыг хойшлуулъя.

7. ХСҮТ-2 хөрөнгө оруулалтыг нэмж тусгалаа.

Нэгдсэн төсвийн нийт орлогыг төсвийн хөрөнгө оруулалт, зарлагын бууралттай холбогдуулан 394,8 тэрбум төгрөгийн буурахаар тооцлоо. Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого тусламжийн дүн 33,5 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 35 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 33,5 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 35 хувьд хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй төсөвлөлөө.

Суурь тэнцлийн дотоод нийт бүтээгдэхүүний 3,3 хувийн эерэг байхаар төлөвлөлөө.

Эрхэм Байнгын хорооны дарга, гишүүд ээ, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 11 хуулийн төсөл, 4 Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа. Эдгээр хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ч.Ундрам: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна.

Д.Загджав: Та бүхэндээ энэ өглөөний мэндийг өргөн дэвшүүлье. Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Төрийн аудитын байгууллага төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг гүйцэтгэн, аудитын тайлан, дүгнэлтийг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр бүхэлд нь хориг тавьсан. Энэ нь цаг үеэ олсон чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон. Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээн авч, алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсний дагуу Монгол Улсын Засгийн газраас 2025 оны төсвийн төслийг шинэчлэн боловсруулж, дахин өргөн барьжээ.

Төрийн аудитын байгууллагын хийсэн аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангасан эсэх, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд оролцож нийцсэн эсэхийг хянаж, дүгнэхэд чиглэсэн.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 33 их наяд 470 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 35,2 хувь, нэгдсэн төсвийн суурь тэнцлийг 3 их наяд 173,4 тэрбум төгрөгийн ашигтай буюу тооцооны өртгийг 3,5 хувь, тэнцвэржүүлсэн тэнцлийг алдагдалгүй байхаар тус тус төлөвлөжээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах 2 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн орлогыг 5,8, зарлагыг 4 их наяд 945,4 тэрбум төгрөг тус тус байхаар төлөвлөжээ. Үүнд: Боловсролын сайд, Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын төсөл багтаж байгаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын үзэл баримтлал, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн боловч дараах асуудлыг анхаарах нь зүйтэй.

Гадаад хүчин зүйлийн нөлөөлөл уул уурхайн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүний эрэлтээс шалтгаалж, нүүрсний экспорт төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй тохиолдолд зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах, орлого тасрах эрсдэлтэйд тооцох шаардлагатай.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг төсөлд өөрчлөлт оруулах бүрд нэмж, өөрчилж байгаа нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг алдагдуулж, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн асуудлуудыг бууруулж байна.

Цахим систем болон ТЭЗҮ боловсруулах, ажлын өртөг зардлыг тооцох, төлөвлөх, хянах, хэрэгжүүлэх, хүлээн авахтай холбоотой зохицуулалт, жишиг үнэ, заавар журам хангалтгүй байгаа нь төсөвт өртгийг үндэслэлтэй тооцож, үр ашгаа төлөвлөхөд сөргөөр нөлөөлж байна.

Төсвийн урсгал зарлагыг хумьж, зарим хэсгийг хэрэгжиж эхлээгүй хөтөлбөр үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөсөн нь төсвийн зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх харьцааг бууруулсан сайн талтай боловч зардлыг хэт механикаар хассан нь 2025 онд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулах, тоо хэмжээг нь хумих эрсдэл үүсэх магадлалтай байна.

Төрийн үйлчилгээг илүү цомхон бүтэц, ухаалаг байдлаар үзүүлэхийн тулд төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх тогтолцооны өөрчлөлтийг хууль, эрх зүйн орчинд бүрдүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 12-т, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэж болно. Тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтоона гэж тусгасан нь Улсын Их Хурлын Засгийн газарт тавих хяналтын зарчмыг алдагдуулахаас гадна Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн гарсан хууль тогтоомжтой нийцэхгүй байгааг анхаарах шаардлагатай байна. Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Ч.Ундрам: Хэлэлцэж байгаа хуулийн төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Хууль санаачлагчаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүн байвал нэрсээ өгнө үү. Галбадрах гишүүнээр тасаллаа.

Хэрлэн гишүүн асуулт асууя.

Б.Хэрлэн: Бүгдээрэнд нь энэ өглөөний мэндийг хүргэе. Тэгээд надад нэг 5, 6 асуулт байна. Их төлөв дандаа яг энэ боловсрол, ерөнхийдөө энэ боловсрол, соёлын энэ 2 сайдтай холбоотой л асуултууд байх шиг байна.

1 дүгээр асуулт нь, болоод ирэхээр энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн тухай хүснэгт номер 5-д, ерөнхий эрдмийн шалгалт зохион байгуулах, сурах бичиг, МСҮТ-ийн хувьсах зардлыг 5,4 тэрбумаар хассан байна л даа. Тэгэхээр энэ дээр Боловсролын сайдаас миний асуух гээд

байгаа зүйл нь болоод ирэхээр тэр 5,4. Аль зардлаас нь хэдийг хасах гээд байгаа юм бол оо гэдгийг би нэг мэдэх гэсэн юм, 1 дүгээрт.

2 дугаарт нь, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтыг дэмжих сангийн зардлаас 11 тэрбумыг хассан байгаад байна л даа. Тэгэхээр энэ, тэгтэл өөрөө яг энэ хойд талдаа нөгөө зорилтод болоод ирэхээр яг мэргэжлийн боловсролын сургалтад хамрагдаж байгаа хүмүүсийн тоог 1,6 хувиар нэмэгдүүлнэ. Өмнөхөөсөө өсгөнө өө гээд ингээд ороод ирчихсэн байна. Тэгэхээр ингээд 11 тэрбум, тэгээд дээд тал нь тэр 5,4 тэрбумаас чинь хэд нь яг МСҮТ-д ноогдож байгаа юм, тийм ээ. Тэгэхээр энэ төсөв мөнгө нь багасаад ирж байгаа үед мэргэжлийн боловсролын сургалтууд чинь тэртээ тэргүй хүн цөөхөнтэй хэцүүхэн байгаа шүү дээ. Тэгэхээр та энэ мөнгөө яаж хуваарилах гэж байгаа юм бол оо гэж би 1 дүгээрт асуумаар байна. Яг нөгөө төрийн өмчийн МСҮТ-үүдээ санхүүжүүлээд явах юм уу- эсвэл нөгөө хувийн хэвшлийн МСҮТ-үүдийнхээ санхүүжилтийг зогсоох гээд байгаа юм уу? Та яах гэж байгаа бол? Тэр нөгөө хүмүүс МСҮТ-д сурч байгаа хүмүүсийн мөнгө төгрөгийг нь өгөх үү, өгөхгүй юү? Яаж мөнгөө хэмнэх гэж байгаа юм бол оо гэж би асуумаар байна.

2 дугаарт нь, Боловсролын зээлийн сангаас 17,5 тэрбумыг багасгасан байна л даа. 17,5 тэрбумыг багасгахдаа яг дотоодын их, дээд сургуульд сурч байгаа 4033 хүний тэр зээлд тэтгэлэг тусламж энээ тэрээ юмыг нь багасгаад, гадаадад сурч байгаа хүмүүсийнхээс дөнгөж 714 байна уу, хүнийхийг хассан байна. Тэгэхээр дотоодод сурч байгаа хүмүүс энэ хэмнэлтэд нэлээн их өртөх юм байна л гэж хараад байна. Та тэгээд яг ямар хөтөлбөрөөр энэ хөнгөлөлт зээл авах гэж байгаа хүмүүст нь түлхүү санхүүжилтийг нь өгөөд, ямрыг нь татъя гэсэн бодолтой байгаа вэ? Тэгээд уг нь та нар чинь нөгөө дээд боловсрол эзэмшихэд адил тэгш боломжийг бүрдүүлнэ ээ гээд та нар их том зорилго тавьчихсан байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр дотоодын их, дээд сургуульд сурч байгаа хүмүүс нэлээн жаахан энэ боломж хүртэх юм нь жаахан хумигдах талдаа болоод байна. Тэгэхээр гадаадынханд арай жаахан та түлхүү ээлтэй хандаад байгаа юм уу гэсэн нэг ийм бодол надад энэ тоон дээрээс харагдаад байна л даа.

Дараа ... /минут дуусав/

Ч.Ундрам: 1 минут нэмж өгье. Хэрлэн гишүүнд. Энэ сая 2 минутаар явсан байна шүү. Манайхан 4 минут өгнө шүү дээ. Хэрлэн гишүүн.

Б.Хэрлэн: Тэгвэл 3 минут нэмэгдэнэ гэсэн үг шүү дээ. Надад.

Ч.Ундрам: Юу ч гэсэн 2 минутаа нэмж аваад та дахиж тодруулах юм уу эсвэл нэмж авах уу гэдгээ дараа нь шийдчих. Одоо 2 минутыг эхнээс нь өгчих.

Б.Хэрлэн: Тэгээд нөгөөд дээд боловсролын энэ хэсэг дотор 28.3.2.1, 28.3.2.3 гэдэг чинь тэр нөгөө зорилтын хувьд шалгуур үзүүлэлтүүд дээр чинь яг адилхан нэг утга санаатай юмнууд ороод ирчихсэн байна уу. Тэрийгээ нэг харах уу гэсэн нэг ийм зүйл байна.

Тэгээд ерөнхийдөө Жавхлан сайдаас, бас Боловсролын сайдаас хандаад асуухад ерөнхийдөө энэ хүснэгт 5-д чинь болоод ирэхээр төрийн зарим чиг үүргийг бусдаар гүйцэтгүүлэх зардал чинь өмнөх нөгөө буцаагдсан төсөв дотор чинь 42,2 тэрбум байснаа ингээд сүүлийнх дээр нь болоод ирэхээр 189,1 тэрбум болоод

ороод ирж байгаа юм байна шүү дээ, тэгэхээр чинь. Энэ төсвийн ерөнхий захирагч нарын нийт төсөв дотор ер нь бусдаар гүйцэтгүүлэх зардлын төсөв чинь нэмэгдээд л ороод ирчхэж байгаа юм. Ерөнхий дүнгээрээ. Энэ дотор нэг тийм юм байгаад байна.

Тэгэхээр хэрвээ Боловсролын сайдын бусдаар гүйцэтгүүлэх ийм төсөв чинь ингээд жаахан нэмэгдээд ороод ирж байгаа юм бол тэр нөгөө нэг хөөрхий минь МСҮТ-ээс аваад байгаа танаад байгаа мөнгөө тэндээсээ ингээд нэг шилжүүлэх арга тал байх уу? Одоо яг тэд нар чинь нэг ядарсан хүмүүс л тэнд сурч байгаа шүү дээ. Тэд нарыгаа дэмжих тэр талын юм бодох уу, та? ийм асуултууд байна.

Ч.Ундрам: Наранбаяр сайд хариулъя. 2 номер.

П.Наранбаяр: Гишүүний асуултад хариулъя. Энэ үнэхээрийн манай салбараас нийтдээ 152 тэрбум хасагдаж байгаа. Тэгээд энэ дээр чухам алианаас нь яаж, хэрхэн хасах вэ гэдгийг нь уян хатан зохицуулалт хэрэгтэй болно. Өнөөдрийн байдлаар яг таны яг хэлсэнчлэн ийм хасалт байгаа. Жишээлбэл, мэргэжлийн боловсролыг дэмжих сан дээр 11 тэрбум хасагдсан байдалтай харагдаж байгаа. Энэ дотор нэг 8 орчим үйлчилгээ байдаг тийм ээ. Тэгээд төгсөж байгаа хүүхдүүдэд олгодог тэтгэлэг эд нар гээд байдаг. Бид нар ингээд өнөөдрийн байдлаар нэг 8 тэрбум төгрөг энэ сан дээрээ хэмнэгдсэн байдалтай байгаа. Тэгэхээр энийгээ ирэх жил дээр хэрэглэнэ.

Дээр нь нэмээд энэ яг энэ гүйцэтгэл энэ 2-ын зөрөө дээр нэг жоохон хэмнэлт гарах учраас өнөөдрийн байж байгаа энэ үйлчилгээг ямар нэгэн байдлаар дордуулахгүй, ямар ч хүүхдийг гадна гаргахгүйгээр үйлчилгээгээ бол үзүүлээд явна гэсэн ийм бодолтой байгаа.

Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ дээр 5,4 тэрбумаар ингээд хасчхаад байж байгаа. Энэ дээр ч гэсэндээ таны хэлсэнчлэн бид энэ өнгөрсөн 24 оны төсөвтэй харьцуулахад нэлээн 25 онд нэмэгдүүлж чадсан байсан. Эндээс хасагдаж байгаа хасалт л гэж ойлгох хэрэгтэй. Тэгэхээрээ 24 оны энэ түвшин юунаас бол буулгахгүй ээ, ийм байгаа.

Боловсролын зээлийн сангийн 17,5 тэрбумаар хасаж байгаа энэ хасалт дээр бид ер нь эргэн төлөлтийг сайжруулах замаар, ямар нэгэн байдлаар энэ зээлийн сан дээр ачаалал үүсгэхгүйгээр, шийдвэрлэхийг зорино. Ер нь авлага нь нэлээн их байдаг, энэ дээр. Ялангуяа гадаадад төгссөн улсуудынх, тийм ээ. Энэ дээр авлагыг жил болгон нэг 34 төгрөг эргүүлэн төвлөрүүл гэсэн ийм үүргийг хүлээдэг. Гэхдээ энэ дээрээ хүрч чаддаггүй. Энэ эргэн төлөвлөлт дээр бид нар анхаарч явна. Ер нь дотоодод сурч байгаа энэ чинь багшаар бэлтгэгдэж байгаа оюутны хөгжлийг дэмжих сан гээд багш нарын хүүхдүүдийг тийм ээ, сургах эд нар. Энэ дээр бид ямар нэгэн юу хийхгүй. Хасалтыг бол. Харин гадаадад сурч байгаа, ялангуяа Ерөнхийлөгчийн тэтгэлгээр сурч байгаа хүүхдүүд дээр зарим нэгэн бага зэргийн хэмнэлт хийх шаардлага гарч магадгүй. Энийг бол танд хэлье. Гэхдээ хамрах хүрээ нь тэнд чинь сум бүрээс гэж байгаа шүү дээ. Тэгээд хороо бүрээс гэж байгаа. Энэ бодлогыг алдагдуулахгүй. Зарим нэг нэлээн өндөр үнэтэй сургуулиудын зардлаас танах ийм шаардлага гарч байгаа гэж харж байгаа.

Тэгэхээр бид дотооддоо сурч байгаа энэ оюутнууд дээр ямар нэгэн тийм хасалтыг хийлгэхгүйгээр дунд нь уян хатан зохицуулалт хийнэ. Өнөөдрийн ... /минут дуусав/

Ч.Ундрам: Нэмж минут өгье. 2 номер Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Өнөөдрийн энэ төсөв бид нар ямар ч байсан энэ салбараа нийт хасалтын дүн нь нэг 3,6 орчим хувь л байгаа. Ямар ч байсан энэ дүндээ хийчхээд, тэгэхдээ та бүхэн энийг анхаараарай. 25 онд сая батлагдсан төсвүүд дээрээ л хасагдаж байгаа хасалтууд шүү. Тэгэхээр энэ дээр уян хатан зохицуулалт хийх замаар Сангийн яамтайгаа ярилцаад ингээд явах болно оо.

Өөр хамгийн сүүлийнх нь асуулт юу байлаа.

Ч.Ундрам: Тайлбар хангалтгүй бол 1 минут нэмээд Хэрлэн гишүүнд өгчихье.

Б.Хэрлэн: Тэр нөгөө хамгийн сүүлийнх нь болоод ирэхээр тэр бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарын хувьд болоод ирэхээр 147 тэрбумаар нэмэгдчихсэн байгаагийн яг хэд нь танай яам дээр ноогдож байгаа бол? Тэрнээсээ та тэр нөгөө МСҮТ-ийн зардлыг нөхөх тийм боломж тал байх уу гэж би танаас асуусан юм.

Ч.Ундрам: Жавхлан сайд хариулах юм уу? 4 номерын микрофон.

Б.Жавхлан: Эрхэм гишүүний асуултад хариулъя. Ингээд Байнгын хороодоор явахаар байнгын хороод маань өөр өөрсдийнхөө салбарын төсвийн ерөнхий захирагч нарын зардлыг хасагдсан байна, багассан байна гэж их гайхаад байгаа юм. Өмнөх хэлэлцүүлгийн үеэр гишүүд маань урдаа пайз тавьж байгаад, бүр 3,6 их наядаар урсгал зардал, хөрөнгө оруулалтыг хасъя гэж уриалж байсан. Тэр хэмжээнд хэрвээ төсөв танагдах юм бол Засгийн газрын үйл ажиллагаа доголдох өндөр эрсдэлтэй. Ямар ч байсан алдагдалгүй төсөв батлах хүрээнд 2,4 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт урсгал зардлыг ямар ч байсан бид зорилгоосоо ухрахгүй хүрэх, хөгжлийн түвшин зорилтод энэ төлөвлөгөөнөөсөө ухрахгүйгээр бууруулж, ингэж орж ирсэн байгаа. Энэ хүрээнд ч гэсэн боловсролын салбар тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч нарын ... /минут дуусав/

Ч.Ундрам: Жавхлан сайд дахиад 1 минут.

Б.Жавхлан: 3 минут асуухад 1 минут хариулахаар амжихгүй байна шүү. Ингээд хасагдаж орж ирсэн байгаа. Боловсролын салбарын хувьд манай яг том 3 суурь зардалтай салбарын нэг нь. Тэгэхээр тэр хэмжээгээрээ том хасагдаж байгаа. Бусад салбарууд дээр 10 хувь хасагдаж байгаа. Сая Наранбаяр сайдын хэлснээр 3,6 хувь Боловсролын яаманд салбар дээр хасагдаж байгаа гэсэн үг. Арай бага өртөж байна гэсэн үг.

Саяын таны асуусан тэр бусдаар гүйцэтгүүлэх ажил дээр тийм өсөлт байхгүй. Тийм, 10 хувь жигд буурсан байгаа. Тэр талаар яг тооных нь асуудлаар манай хэлтсийн дарга ярина.

Бусдаар гүйцэтгүүлэх ажил гэхээр манай гишүүд нэг жоохон буруу ойлголт аваад байх шиг байгаа юм. Энэ хувийн хэвшлээр гүйцэтгүүлж байгаа ажил шүү. Хэрвээ цаашаага төрийн албад данхайхгүй, орон тоо нэмэхгүй гэвэл заавал тангараг өргөсөн төрийн албан хаагчаар гүйцэтгүүлээд байх шаардлага ... /минут дуусав/

Ч.Ундрам: Сангийн яамнаас нэмэлт тайлбар өгөх юм байна тийм ээ. 2 номерын микрофон Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ танд тоо хэлэхэд яг ноднин жилийн төсвөөс нэг 80 тэрбумаар нэмэгдсэн. 80 тэрбумаар ноднин жилийнхээр. Энэ чинь нөгөө дотуур байрны хүүхдүүдийн хоол нэмэгдэж байгаа учраас тэгж байгаа. 24 оны тэр сая 11 сард батлагдсан байсан төсвөөсөө 11 тэрбумаар ингээд буураад ороод ирж байгаа юм. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн тэр ингээд дотор нь ингээд гүйлгээд, тэгээд энд нөгөө тийш нь явуулах эд нар юм үнэхээр юм байхгүй. Ингээд харахаар дотуур байрны үйлчилгээ, тэгээд л сургуулийн цэвэрлэгээ, харуул хамгаалалтын зардал, гэрээгээр гүйцэтгүүлдэг ажил үйлчилгээнүүд нь гээд, тэгээд сурах бичгийн түрээс, тусгай хэрэгцээт боловсрол эд нар гээд юмнууд байж байгаа. Тэгэхээр энэ дээр мөн төрийн бус өмчийн МСҮТ-ийн суралцагсдын хувьсах зардал эд нар гээд бүх юм байж байгаа.

Тэгэхээр энэ дээр ямар нэгэн байдлаар бид хэмнэлт хийж, 11 тэрбум дотор ямар ч байсан энэ ... /минут дуусав/

Ч.Ундрам: Найдалаа гишүүн асуулт асууя.

Дэгийн дагуу 3 минут өгөх юм байна шүү.

Б.Найдалаа: Тэгээд Боловсролын сайдаас 1 асуулт байна л даа. Түрүүн Хэрлэн гишүүний асуулт нь давхацсан болохоор товчлоод юунаас хассаныг нь ойлгочихсон. Зүгээр энэ чинь жишээлбэл сая төсвийн таналт хийгээд жишээлбэл Зам, тээврийн сайдаасаа л 500 орчим тэрбум төгрөг хөрөнгө оруулалтаас нь хассан харагдаж байна лээ. Зүгээр яг засаг дээр ярьсан л байх л даа. Боловсролын салбар чинь сургууль, соёл үнэхээр дутагдалтай байгаа. Сургуульгүй хүүхэд олон байгаа. Энэ дээрээ бодлогын зарчмын өөрчлөлт хийгээд энэ мөнгөнөөсөө тодорхой хэмжээгээр сургуулийн хөрөнгө оруулалтад зарцуулж болоогүй юм уу, ийм юм яригдаагүй юу? Хэрвээ тэгсэн бол өнөөгийн Засгийн газрын бодлого нь их гоё тод гараад, ер нь чиглэл нь зөв харагдах юм байна гэж бодоод байгаа юм. Үнэхээр хасаж чадсан юм бол зөв газраа нэмчхэж болоогүй юм уу гээд 1 асуулт байна.

2 дахь нь, Соёл, спорт, аялал жуулчлалын сайдаас асуумаар байна. 75,5 тэрбум төгрөг хасжээ. 12,7 хувь юм байна, төсвийн. Яг энэ хассанаараа ямар ажлын хийж чадахгүй болоод, ажлын үр дүнд яаж нөлөөлөх юм. 2-т нь, хөрөнгө оруулалт нь бас бууруулсан, 30 орчим тэрбум бууруулсан байна. Энэ жил нь 18,4 тэрбумын санхүүжих дүн юм байна л даа. Энэ яг юунаас буурсан байна, задаргаа нь байхгүй байгаад байна. Яг юу юу буурсан юм бол оо, ийм асуулт байна.

Ч.Ундрам: Эхлээд Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Тэгэхээр энэ удаад энэ хөрөнгө оруулалтын, өөрөөр хэлбэл сургууль, цэцэрлэгийг барих энэ зардал өмнөх, өмнө нь өргөн барьсан нь 500 орчим тэрбум байсан, 580 орчим. Эндээс энэ удаад хасагдаж орж ирсэн нь 12 сарын 02-ны байдлаар гэрээ байгуулаад амжаагүй байсан ийм 14 төсөл, арга хэмжээг бид энэ дээр хасагдсан байгаа. Тэр нь ойролцоогоор нэг 26 тэрбум. Бусад зардлууд хасагдахгүй ингээд явж байгаа.

Зүгээр яах вэ, ингээд хэмнэсэн юман дээрээ хэрвээ нэмээд өгсөн бол энэнээс илүү сайн юм байхгүй. Үнэхээрийн энэ сургууль, цэцэрлэгийн хүртээмж муу байгаа. Гэхдээ бүхий л зүйл чинь ингээд нэг дороо аль нэг салбарыг онцлох эд нар дээрээ биш, бид энэ Засгийн газрыг сайн ойлгож байгаа. Өөрөөр хэлбэл 3,6 хувиар л энэ салбарын юуг хассан гэдэг нь 25 онд өргөн барьснаасаа энэ нэг тийм ч чамлалттай дүн биш. Энэ жил төсвийн хөрөнгө оруулалт дээр нийтдээ бид 96 төсөл, арга хэмжээ ашиглалтад орох юм. Энэ дээрээ сургуулийн барилга нь нийтдээ 40 сургууль, 35 цэцэрлэг, дотуур байр 7 эд нар гээд энэ 25 онд ашиглалтад оруулахаар нийтдээ 96 төсөл, арга хэмжээ байгаа. Ингэснээрээ нэг 29880 хүүхдийг сургах ийм боломжтой болж байгаа. Ийм байна. Баярлалаа.

Ч.Ундрам: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Найдалаа гишүүний асуултад нэмж хариулъя. Найдалаа гишүүн өмнөх хэлэлцүүлгийн үеэр арай өөрөөр л яриад байсан даа. Зам, тээврийн салбараас 500 тэрбумыг хасаад буцаагаад өөр салбар дээр 500 тэрбумыг нэмчих юм бол бид нар чинь яаж нөгөө алдагдалгүй балансаа барих вэ. Өмнөх хэлэлцүүлгээс хойш алдагдалгүй төсөв рүү зорьж байгаа үед бид нар хассан л бол хасна. Тэгээд буцааж бид нар нэмж тавих ямар ч боломж байхгүй. Ер нь 25 оны төсвийг анх боловсруулахдаа бид ер нь хөгжлийн төлөө гээд дэд бүтцүүдээ л тавьсан байгаа. Өөрөөр хэлбэл сургууль, цэцэрлэг барилаа гэхэд очих зам нь байхгүй, өгөх эрчим хүч нь байхгүй болчихоод байгаа. Тийм учраас Зам, тээвэр, эрчим хүчний салбар дээр 25 оны бүх боломж, хөрөнгө оруулалтуудаа тавьсан байдаг. Өмнөх ер нь нэг сүүлийн 10 жилд бид нар нийгмийн энэ яг гол зөөлөн дэд бүтцийн суурь дэд бүтцүүд дээрээ сургууль, цэцэрлэг, ялангуяа боловсролын салбарын бүхий л барилга байгууламж, хөрөнгө оруулалтууд дээр хамгийн их зарцуулалт хийсэн байгаа, хамгийн их хөрөнгө оруулалт тавигдсан байгаа ... /минут дуусав/

Ч.Ундрам: Жавхлан сайдад нэмээд 1 минут.

Б.Жавхлан: Тийм ч учраас хэдэн жилийн өмнө байсан энэ хамран сурагдалт энэ хүүхдийн сургуулиудын энэ ээлжийн коэффициент үлэмж бүр 2-3 дахин буурч чадсан байгаа. Орон нутгуудад 2-оос доош орсон. Улаанбаатар хотод 2 луу нэлээн дөхсөн. Зарим газруудад тодорхой хэдэн цэгүүд дээр 3 хувийн коэффициент дээрээ байгаа. Ирэх жилүүдэд ашиглалтад орсон боловсролын салбарын хөрөнгө оруулалтын хэмжээний тэр орон зайн дээр хөрөнгө оруулалтууд үргэлжлээд явна, тийм. Ийм бодлоготой байгаа.

Ч.Ундрам: Тэгье. Номин сайд соёлын салбартай холбоотой асуултад хариулт өгье.

Ч.Номин: Найдалаа гишүүний асуултад хариулъя. Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Манай салбар дан ганцаараа 2024 оны батлагдсан төсөвтэй

харьцуулахад, 2025 оны батлагдсан төсөвтэй харьцуулахад аль алинаас нь буурч орж ирж байгаа салбар байгаа. Ингэхээр соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбар тэр чигээрээ төсвийн хувьд бууралттай буюу орж ирж байгаа салбар байгаа. Түрүүний хэлсэн 12,7 хувийн бууралттай байгаа. Саяын энэ төсвүүдийг ингээд буурсан тохиолдолд манай хамгийн гол зүйл бол урсгал дээр хамгийн өндөр нөлөөлөлтэй байгаа буюу 75 тэрбум төгрөгөөр буурч байгаа. Ингээд үзэхэд манай соёл урлагийг хөгжүүлэх зардал тэр чигээрээ хасагдаж байгаа. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх зардал тэр чигээрээ, бүх нийтийн соёлын боловсролыг дэмжих зардал тэр чигээрээ хасагдаж байгаа. Үүнээс гадна түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах гээд ингэхээр ер нь бид нар соён гэгээрүүлэх ажил, дээрээс нь урлаг уран бүтээлийг хөгжүүлэх, үүнээс гадна соёлын өвийг хадгалж хамгаалах ийм хөтөлбөр арга ... /минут дуусав/

Ч.Ундрэм: Номин сайдад нэмээд 1 минут.

Ч.Номин: Хөтөлбөр арга хэмжээний зардлууд байхгүй болж байгаа гэсэн үг. Нөгөө талдаа мөн хамгийн том асуудалтай байгаа зүйлүүдийн нэг юу байгаа вэ гэхээр Үндэсний шигшээ багийг дэмжих ажлын зардал 66 хувиар буурч байгаа. Энэ ажлыг ингэснээр энэ шигшээ багийн тамирчид маань 4 жилийн туршид оноо цуглуулах олон улсын хэмжээний томоохон тэмцээн наадамд оролцдог. Тэгэхээр оноогоо цуглуулж чадаагүй тохиолдолд дараагийн 2028 оны Лигийн олимпод оролцох нөхцөл буюу оролцох тамирчдын тоо эрс буурна. Бид нар тавьж өгсөн санхүүжилтээр бол 1-2 томоохон хэмжээний тэмцээнд оролцоно гэсэн үг. Нэг ёсондоо Гуамд болж байгаа сагсан бөмбөгийн ДАШТ-д манай баг, тамирчид оролцох боломж буурч байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ утгаараа соёл, спортын салбарын хөтөлбөр арга хэмжээ буюу иргэдэд чиглэсэн нийт үйл ажиллагаанууд бүрэн хэмжээнд буурч байгаа ийм нөхцөл үүсэж байгаа. Гэхдээ бид бүхэн ямар бодлого барьж байгаа вэ гэхээр нэгэнт Засгийн газраас барьж ирж байгаа бодлого учраас одоо тавигдсан байгаа дүнгээс ... /минут дуусав/

Ч.Ундрэм: Нэмээд 1 минут өгчих.

Ч.Номин: Одоо яг өнөөдрийн байдлаар тавигдсан байгаа дүнгээс маань нэмэлтээр энэ 520 тэрбум төгрөгөөс, нэмэлтээр санхүүжилт буураагүй тохиолдолд бид нар чамлахаар чанга атга, байгаа төсөвтөө тохироод ажиллахаар зүтгээд үзнэ. Нөгөө талдаа таны түрүүний асуусан хөрөнгө оруулалт дээр тендер зарлагдаад, ажил үйлчилгээнийх нь гэрээ гэрээлэгч нь шалгараагүй байгаа 7 орон нутгийн соёлын төвүүд болон спортын зал, талбайн арга хэмжээнүүд хасагдаж байгаа, 15 тэрбум төгрөгөөр. Хөрөнгө оруулалт дээр.

Ч.Ундрэм: Найдалаа гишүүн тодруулъя.

Б.Найдалаа: Баярлалаа. Энэ соёлын бодлого, соёлын яамыг ер нь дэмждэг. Зүгээр энэ дээр ингээд төсвийг нь харахаар юу бодогдож байна гэхээр төсөв чинь өөрөө ингээд бүтцээ дагаад чирээд явчихдаг нэг ийм айхтар зүйл. Тэгэхээр жишээ нь сая хасагдаж байгаа зардлуудаас зарим нь хасмааргүй зардал байгаа байхгүй юу. Гэхдээ цаана нь яг соёлын салбартаа арга барилын, бүтцийн өөрчлөлт хийхгүй бол яг социализмын үеэр явж байсан нөгөө нийтээр нь бүтээн байгуулах маягийн энэ маягаар явах юм бол удахгүй соёлын салбарын төсөв дийлдэхээ болино. Тэгэхээр яг жинхэнэ нөгөө нэг кино урлагийг дэмжих сан ч юм уу, бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сан ч юм уу, түүх, соёлын дурсгалт, сэргээн

засвар тэр зардлуудад зардал олдохгүй дандаа гоочлуулах болно, дандаа хасуулна. Тэгэхээр би санал болгож байгаа юм. Өмнө нь энэ соёлын салбар дээр яг тэр бодлогын бүтцийн шинэчлэлийг хийх хэрэгтэй гэж бодоод байгаа юм. Энэ зардлыг харахаар ихэнх нь юу байна шүү дээ, дандаа нөгөө хуучин барилга байшингийнхаа санхүүжилт, тэрний урсгал зардал засвар руу явчхаж байгаа байхгүй юу. Яг жинхэнэ бүтээх юман дээр, сэдэлжүүлэх юман дээр байхгүй байна. Энэ дээр Номин сайд анхаарч ажиллах байх. Ингэх юм бол төсөв үр дүнтэй болоод хасагдахгүй болно. Магадгүй иргэд ... /минут дуусав/

Ч.Номин: Дахиад 1 минут Найдалаа гишүүн.

Б.Найдалаа: Шүүмжлээд байгаа нь яг энэтэй ч холбоотой байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр яг ингээд Номин сайд бас ярьж байсан. Тэр бүтцийн өөрчлөлтөө хийхгүй бол нэг 10, 15 жилийн дараа бид нар эрчим хүчний реформ гэдэг шиг соёлын салбарын реформ хийхгүй бол зардлаа дийлэхээ болилоо гэдэг асуудал үүсэх вий гэж байна.

Зүгээр Жавхлан сайдын тэр юун дээр би зүгээр ижилхэн юм ярьж байгаа, Жавхлан сайд аа, юу гол нь нэг л юм яриад байгаа юм. Төсөв заавал алдагдалгүй байна гээд шахаад, бүх юмаа хамаад тэгшитгээд хасчих юм бол төсвийн бодлого гэж байхгүй, хөгжлийн бодлого гэж байхгүй болно. Тэгэхээр хэрэгтэй юм бол алдагдлыг нь хүлээж байгаад, санхүүжүүлж байгаад сургуулиа ч байна уу, өөр юу байна уу, тийм ээ. Зөв юмаа Засгийн газар санхүүжүүлэх санал оруулж ирэх ёстой л гэж бодоод байгаа юм. Түүнээс заавал алдагдалгүй барих юм бол энэ бол төсвийн бодлого биш болчихно оо.

Ч.Ундрам: Үг хэллээ, тийм үү. Үг хэллээ.

Рэгдэл гишүүн асуулт асууя.

Д.Рэгдэл: Баярлалаа. Тэгэхээр Засгийн газраас алдагдалгүй төсөв оруулж ирэхдээ таналт хийх зарчмаа эхэлж ярьсан явдлыг би бол их зөв зүйтэй юм болсон гэж бодож байгаа юм. Тэгээд үүний үр дүнд үндсэндээ улсын хэмжээнд урсгал зардал 700 орчим тэрбум, хөрөнгө оруулалтын зардал 800 орчим тэрбум, ингээд зээл тусламжтай холбоотой ингээд 700 тэрбум гээд нийтдээ ингээд зөндөө зардал хасагдсан. Зарчмаа дагаж хассан учраас би энэ саналыг Засгийн газрын саналыг дэмжиж байгаа.

Харамсалтай нь зүгээр энэ хамтарсан Засгийн газар нийгмийн өмнө хүлээсэн, ард түмний өмнө хүлээсэн амлалт, үүрэгтэйгээ холбоотой олон зардлаа хамгаалж чадалгүй танаад ороод ирсэн явдалд би жаахан сэтгэл дундуур байгаа. Тэгээд тэрнийг эргэж сэргээх ер нь боломж их муу гэж үзээд байгаа юм. Зүгээр яах вэ, шинжлэх ухааны салбарын хувьд эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн нийт зардал хүрээлэнгийнхээ онцлогоос хамаараад 1,1-6 хувь танагдсан байгаа. Яагаад ийм бага танагдсан юм гэх дээр зэрэг энэ хүрээлэнгүүд чинь нээлттэй сонгон шалгаруулалтаар гүйцэтгэх судалгааны ажлаа авдаг учраас тэндээс тодорхой өртөгтэй төслүүд хэрэгжүүлдэг.

Тийм учраас тэндээс хасаад байхад төвөгтэй. Тийм учраас энэ хасалтын хэмжээ бусад салбартай харьцуулахад бага юм шиг болов ч үүнээс өөр арга зам байхгүй байсан нь ойлгомжтой. Гэхдээ энэ шинжлэх ухааны салбарын зардлыг

танаад танаад, эсвэл нэмээд нэмээд, бид нар ДНБ-ий 1 хувьд л хүргэж байж, шинжлэх ухааны салбар нь эдийн засагтаа бодитой хувь нэмэр оруулдаг гэсэн НҮБ-аас гаргасан зөвлөмж, 2001 оноос хойш ингээд НҮБ-ын гишүүн хөгжиж байгаа орнуудад байнга өгөгдөөд байдаг. Тэгэхээр манайх 1 хувьд хүргэнэ гэдэг асуудлыг энэ 2 Засгийн газрын 2024, 2028 оны хөтөлбөртөө оруулсан боловч Сангийн сайдын танилцуулгад төсвийг нэмэгдүүлэх эрсдэлт хүчин зүйлийн тоонд оруулаад байгаа юм. Энэ бол маш буруу. Бид нар энэ шинжлэх ухаан, технологийн салбараас үр өгөөж авъя л гэвэл 1 хувьд хүргэж байж л авна. Эсвэл зүгээр нийгмийн үзэгдэл мэтээр явуулаад байя гэвэл одоогийнх шигээ 0,1 хувьтай ингээд үлгэн салган явуулаад л байна, яваад л байна, амьтай.

Асуух гэж байгаа асуулт юу байна вэ гэхээр зэрэг энэ бага зардалтай ч гэсэн энэ бид нарт өгсөн материалыг ингээд харахаар зэрэг Боловсролын яамны харьяа хүрээлэнгүүдийн дотор МУИС-ийн Монгол судлалын хүрээлэн, Эдийн засгийн хүрээлэн, СУИС-ийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн гээд энэ хүрээлэнгүүдийн зардал ерөөсөө огт ороогүй байгаа юм, энэ дотор. Тэгэхээр энэ ... /минут дуусав/

Ч.Ундрал: Рэгдэл гишүүнд 1 минут нэмж өгөөрэй.

Д.Рэгдэл: Миний энэ дээрээс харснаас, би тэгээд хараа муутай болохоор энийг чинь бараг л харахгүй байгаа. Тэгэхдээ л саяын хэлдэг тэр 3 хүрээлэнгийн зардал энэ дотор ерөөсөө байхгүй. Тэгэхээр энэ чинь хуулийн этгээд, төсвийн байгууллага, тэгээд улсын төсөв дотор зардал нь орж ирэхгүй болохоор энэ ямар зохицуулалт байдаг юм бол. Үүнийг надад нэг тайлбарлаж өгнө үү гэсэн асуулт байгаа юм.

Ч.Ундрал: Наранбаяр сайд энэ саяын 3 Рэгдэл гишүүний хэлсэн хүрээлэн дээр нэмэгдээд ШУТИС дээр бас энэ хоол үйлдвэрлэлтэй холбоотой 1 хүрээлэн байгуулагдсан. Түүний зардал хаачсан бэ гээд багш нар нь асуугаад байсан. Тэгэхээр нийлүүлээд та хариулчхаарай. 4 тийм ээ. Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Энэ ер нь манай энэ Боловсролын яамны чинь харьяанд хэдхэн хүрээлэн үлдсэн байдаг юм шүү дээ. Энэ сая ингээд Боловсрол, шинжлэх ухаан 2 чинь салаад шинжлэх ухаан нь Эдийн засгийн хөгжлийн яамныхаа ШУТ сан руу яваад ингээд тэгээд энэ хүрээндээ энэ 4 хүрээлэнгийн асуудал ингэж орж ирсэн байгаа. Нийтдээ нэг 2,2 тэрбум төгрөгийн асуудал байгаа. Үүнийг бид яг энэ Боловсролынхоо яамнаас татаас хэлбэрээр олгоод явна. Сургуульд нь татаас олгох замаар ингээд олгоод явах, тэнд байгаа хүрээлэнгүүдийн үйл ажиллагааг нь дэмжээд явна. Эрдэм шинжилгээ, судалгааных нь зардлыг бас өгнө. Ингээд ямар нэгэн байдлаар үйл ажиллагаанд нь хүндрэл учруулахгүй ээ гэж ингэж харж байгаа.

Ер нь цаашдаа судалгааны их сургууль болж хөгжье л гэвэл их, дээд сургууль дээр түшиглэсэн энэ хүрээлэнгүүд хөгжих ёстой, ийм л байгаа. 2,2 тэрбум төгрөгийн асуудал байгаа. Үүнийгээ татаас эрдэм шинжилгээ судалгааны дэмжлэг хэлбэрээр өгөөд явах болно.

Ч.Ундрал: Рэгдэл гишүүн 1 минут тодруулга.

Д.Рэгдэл: Ямар ч байсан хүрээлэнгүүдээ аваад явчих гэж байгаа явдал их сайн байна. Гэхдээ ингээд татаас маягаар санхүүжүүлээд эхлэхтэй зэрэг одоо 1 сарын 1-нээс төрийн албан хаагчдын цалинг 6 хувь нэмнэ. Тэгэхээр тэд нарын цалинг нэмэх эрх зүйн үндэс байгаа болов уу. Манай улсуудын зөвлөх нь нэгэнт татаас олгох юм бол цалинг нь Засгийн газрын тогтоолын дагуу нэмэх боломж их муу гэж яриад байгаа. Энэ дээр сайд та ямар бодлого барьж байгаа юм бол? Ер нь манай улсын хэмжээнд чинь 1 сая хүнд оногддог эрдэм шинжилгээний ажилтны тоо нь Ази тивийн дунджаас 3 дахин бага байгаад байгаа юм. Тэгэхээр энэ эрдэм шинжилгээний салбарын ер нь орон тоог нэмэгдүүлэх, зардал нэмэгдүүлэх асуудал би түрүүн халти хэлсэн. Орон тоог нь эрдэм шинжилгээний ажилтны орон тоо нэмэгдүүлэх асуудал дээр ямар бодолтой байгаа юм бол. Та нэг хэлж өгнө үү?

Ч.Ундрам: Хүрээлэнтэй холбоотой татаас хэлбэрээр санхүүжигдээд явахаар цалин 1 сарын 1-нээс төрийн албан хаагч нэмэгдэхэд юу болох юм бэ гээд. Энэ хэсгийг Наранбаяр сайд хариулаад, дараагийн хэсгийг нь Эдийн засаг, хөгжлийн яамнаас хариулах нь байна шүү дээ. Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Энэ Дээд боловсролын хуулиар ер нь нэг хүрээлэнгүүдийн хөгжил, их сургуулиудын бие даасан байдал, академик эрх чөлөөг нь маш сайн хангасан ийм хууль бий болсон. Цалингийн асуудал. Энэ 6 хувь нэмэгдэж байгаа энэ Сангийн яам үүнийгээ сайн тайлбарлах байх. Бид энэ дээр нэмэх нь ер нь бол тухайн сургуулийн удирдах зөвлөл нь өөрсдөө цалингийнхаа нэмэгдлийг шийдээд явж байгаа, шийдээд явж байгаа. Цаашдаа ер нь эрдэм шинжилгээ нэмэлт орлого олох боломжийг ч гэсэн Дээд боловсролын хуулиар олгочихсон байгаа. Нэмэлт, өөрсдөө төсөл бичээд, янз бүрийн эрдэм шинжилгээний ажил хийгээд, хувийн хэвшилтэйгээ түншлээд, инновацын ийм төслүүд хийгээд явах боломжууд нь бий.

Тэгэхээр ингээд ер нь энэ эрдэм шинжилгээ гэдэг чинь өөрөө зөвхөн төрөөс татаасаар явдаг биш гэдэгтэй би Рэгдэл гуайтай яг санал нийлж байна. Энэ чинь инновацлаг байж байж, хувийн хэвшилтэйгээ түншилж байж ингэж явах ёстой. Профессорууд нь өөрсдөө энэ төсвөө олж ирдэг, хувийн хэвслээс төсвөө олж ирдэг, тийшээгээ ... /минут дуусав/

Ч.Ундрам: Нэмээд 1 минут өгье. Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Тийшээ боловсон хүчнүүдээ өгдөг, оюутнуудаа тэндээ сургаж авдаг ийм тогтолцоо руу л явах гээд бид ирээд хараад байгаа. Ер нь ингээд та мэдэж байгаа байх, Япон, Солонгосын ингээд их, дээд сургуулийн профессорууд өөрөө төсөвтэй, өөрөө ААН-үүдтэйгээ байнгын харилцаатай байдаг. Тэндээсээ төсөв олж ирээд төрөөсөө ч төсөв олж ирээд, чадалтай профессорууд доороо маш олон хүн ажиллуулдаг шүү дээ. Яг л ийм юм руу л бид явж байж явна. Түүнээс дандаа төрөөс ингээд санхүүжих ёстой, ингэх ёстой гээд ингээд байвал энэ хэд чинь ерөөсөө тэр социализмын үеийнхээ л байдлаараа л байна л гэсэн үг. Цаашдаа бид энэ инновацын бодлогыг дэмжвэл дэмжсэн шиг дэмжээд ингээд явна. Ингэхээр нөгөө тогтмол зардал дээр нь бид нар энэ их, дээд сургуулиудын цахилгаан, дулааных нь зардлыг хүртэл өгч эхэлж байна шүү дээ. Энэ чинь ерөөсөө л энэ чиглэл рүүгээ та нар хөгжицгөө л гэж ингэж хэлж байгаа юм. Тэгэхээр энэ зүг рүүгээ бид нар явна. Яг энэ таны энэ саналыг санааг яг дэмжиж байна. Яг 100 хувь санал нэг байна. Баярлалаа.

Ч.Ундрам: Жавхлан сайд нэмэлт тайлбар өгье.

Б.Жавхлан: Рэгдэл гишүүний асуултад нэмж хариулъя. Сүүлийн 2 жил дараалаад төрийн албан хаагч нарын цалин нэмэгдсэн. Ирэх жил ч гэсэн тэтгэврийн нэмэгдлийн хэмжээтэй ижлээр 6 хувиар нэмэгдээд явах юм байгаа юм, 1 сарын 1-нээс эхлээд. Энд бүгд хамрагдана гэсэн үг.

Дээрээс нь нэмж хэлэхэд боловсролын салбар маань энэ 24 оныхоосоо 580 тэрбумаар нэмэгдсэн байсан, 580-аар. 580-аар биш шүү 560 тэрбумаар. Сая эргээд 280 тэрбумаар хасагдаад, 24 оныхоосоо 280 тэрбум төгрөгөөр өсөж байгаа шүү гэдгийг хэлье. Тэгэхгүй бол нөгөө ингээд 280-аар 24 оныхоо түвшнээс буурч байгаа юм шиг ойлгогдоод байх шиг байна. Буурсан ч гэсэн 24 оныхоо суурь дээрээсээ 280 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаа гэдгийг тодруулж хэлье.

Ч.Ундрам: Эдийн засаг, хөгжлийн яамнаас Баттогтох дарга ирээгүй байгаа учраас Урьболд. Ерөнхийдөө энэ хүний нөөцийн бодлого, орон тоо нэмэх асуудалтай холбоотой хариулт өгье. 5 номерын микрофон дээр очоорой.

Б.Урьболд: Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулга энэ оны хаврын чуулганаар батлагдсан байгаа. Энэ дээр шинжлэх ухаан, технологийн хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх гээд 26 дугаар зүйл дээр бүхэл бүтэн нэг зүйл орсон байгаа. Энэ зүйлийн хүрээнд шинжлэх ухаан, технологийн хүний нөөцийн урт, дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн хэтийн төлөвлөгөөг тодорхойлох, шинжлэх ухаан, технологийн хүний нөөцийг сургах, тогтвор суурьшилтай ажиллах, нийгмийн батлах, хангах чиглэлээр нэгдсэн хөтөлбөр хэрэгжүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, шинжлэх ухаан, технологийн салбарын өндөр ур чадвартай хүний нөөцийг бэлтгэж эхэлсэн, шинжлэх ухаан дээд боловсролын сургалтын байгууллагыг хөгжүүлэх гэсэн ийм хуулийн заалтууд орсон байгаа. Энэ заалтуудын хүрээнд шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас энэхүү урт, дунд хугацааны хэтийн төлөвлөлт болон нэг ... /минут дуусав/

Ч.Ундрам: Дахиад нэмээд 1 минут байгаа шүү.

Б.Урьболд: Шинжлэх ухаан, технологийн хүний нөөцийг, хүний нөөцийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр нэгдсэн хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Ч.Ундрам: Ер нь энэ Рэгдэл гишүүн шинжлэх ухааны салбарыг цаашид бид нар ДНБ-ий 1 хувьд хүргэх ёстой шүү, зарцуулж байгаа мөнгө өө гэдэг ийм асуудал яриад байгаа шүү дээ. Энэ чинь боловсролоос гадна шинжлэх ухааны салбар байгаа. Тэгэхээр яах вэ, яг өнөөдөр бас тэр чадлынхаа хэрээр бид нар тодорхой хэмжээнд 24 онтой харьцуулбал нэмэгдүүлчихсэн байгаа. Нэмэгдчихсэн байгаа. Гэхдээ цаашид 26 оны төсөв дээр өшөө анхаарах хэрэгтэй. Танай Эдийн засаг, хөгжлийн яам энэ салбарыг өшөө яаж хөгжүүлэх юм, ШУА-тайгаа уялдаад, ШУТС-тайгаа уялдуулаад яаж хөгжүүлэх юм бэ гэсэн ийм реформ, бодлогын шинж чанартай ийм төлөвлөгөө гаргах ёстой. Тэгээд энийгээ Байнгын хороондоо танилцуулаад, Засгийн газар дээрээ яриад, 26 оны төсөвт нэг дорвитойхон шиг шинэчлэлийн шинж чанартай, хууль, эрх зүйн төсөл болон дагалдах төсвөө танилцуулах ёстой шүү. Тэгэхгүй ингээд л энэ байдлаараа мөлхөөд яваад байх юм бол манай улс орны шинжлэх ухаан гэж юм байхгүй. Тийм учраас үүнийг дарга нартаа, сайддаа бас хэлээрэй. Ойлгосон уу.

Баярлалаа.

Дараагийн асуулт Мөнхтуяа гишүүн.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Боловсролын сайдын багц нийтдээ 4 их наяд 424 тэрбум 938 сая төгрөг байна. Урсгал зардал 3 их наяд 952 тэрбум 260 сая төгрөг байх юм байна. 25 оны ДНБ 95 их наяд төгрөг байна гээд төсөөлөөд оруулаад ирсэн. ДНБ-ийхээ 4,65 хувийг боловсролд зарцуулж байгаа юм байна. 2025 оны төсвийн нийт зардал 33 их наяд 470 тэрбум төгрөг байгаагийн 13,2 хувийг боловсролдоо зарцуулж байгаа юм байна. Тэгэхээр Боловсролын сайдаас 2 асуулт, Сангийн сайдаас нэг асуулт асууна.

Боловсролын сайдаас эхний асуулт. Улсын Их Хурлаас 24 оны 12 сарын 08-ны өдөр батлаад Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьсан төсвөөс яг хэдэн төгрөгөөр буурсан, аль аль зардал, арга хэмжээнээс ямар хэмжээгээр буурсан талаар мэдээллийг өгнө үү. Наранбаяр сайд.

2 дугаарт нь, урсгал зардлын 3 их наяд 952 тэрбум төгрөгөөс яг хэдэн төгрөг нь цэцэрлэг, сургуулийн суралцагчийн хувьсах зардалд олгож байгаа мөнгө байгаа вэ гэдгийг Наранбаяр сайдаас асууж байна.

Сангийн сайдаас 1 асуулт байна. НҮБ-аас Тогтвортой хөгжлийн зорилго 2030, Боловсрол 2030 баримт бичгүүдийг баталж, түүний дагуу 2015 онд Боловсролын дэлхийн чуулга уулзалтаар Инчоно тунхаглалыг баталсан. Энэ тунхаглалын нэг зорилт мөн улс орнуудын хүлээсэн үүрэг бол төрөөс боловсролын салбарт зарцуулах хөрөнгийг өөрөөр хэлбэл боловсролын салбарт зарцуулах нийт төсөв нэмэгдүүлэх хэрэгцээг тодорхойлж, олон улс, бүс нутгийн жишгийг баримтлан ДНБ-ий 4-6 хувийг, эсвэл улсын төсвийн зардлынхаа 15-20 хувийг боловсролын салбартаа зарцуулахыг уриалсан байдаг. Монгол Улс хэзээ ДНБ-ийхээ 6-аас доошгүй хувийг эсвэл төсвийн нийт зардлынхаа 20-оос доошгүй хувийг зарцуулдаг болох вэ гэдэг асуултыг асуумаар байна. Баярлалаа.

Ч.Ундрам: Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ жилийн хувьд хөрөнгө оруулалтынх нь зардлаас нэг 26 тэрбум төгрөг байгаа. Хасагдсан. 25 онд сая 11 сард батлагдсан төсвөөс хойш тэр гол шалтгаан нь 12 сарын 02-ны байдлаар 24 оны гэрээ байгуулагдаагүй ийм зардлууд хасагдсан. Урсгал зардлаас нийт 3,6 хувь буюу 152 тэрбум төгрөг буурч ингэж орж ирж байгаа. Гэхдээ энэ нь 24 оны төсөвтэй харьцуулахад 524,8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаа. Тэгээд анх өргөн баригдсан төсвөөс ингэж буурсан болов ч багш, ажилчдын цалин болон нийгмийн баталгааг хангахтай холбоотой зардлууд буураагүй байгаа.

Цэцэрлэг, сургуульд олгогдож байгаа хувьсах зардлын тухайд нийтдээ 2,2 их наяд төгрөг ерөнхий боловсролын сургуулиудад, СӨБ буюу сургуулийн өмнөх боловсролын хувьсах зардал ойролцоогоор 1,1 их наяд төгрөгийн, насан туршийн боловсролын гүйцэтгэл үр дүнгээр олгох санхүүжилт нь нийтдээ энэ чинь 12,8 тэрбум төгрөг гэсэн ийм мөнгөн дүнгүүд байгаа. Баярлалаа.

Ч.Ундрам: Сая асуулт нь яг нөгөө хориг тавиулсан төсвөөс хэдэн төгрөгөөр яг аль аль зардал хасагдсан бэ гэж асуусан. Тэгэхээр 1 номер дээр хариулчих. Наранбаяр сайд тэгвэл хариулъя, 2 номер.

П.Наранбаяр: Энэ нэлээн хасагдсан 152 төгрөгийнх нь энэ задаргааг нь би та бүхэнд, танд бас бичгээр явуулъя. Тэгэхээр жишээлбэл энэ дээр дотуур байрны үйлчилгээнээс бусдаар гүйцэтгүүлэх үйлчилгээнээс нэг 3-10 хувь хүртэл ингээд хасагдаад явж байгаа. Тэгээд тэтгэлгүүд бас нэг 10 хувьтай буурч байгаа. Урсгал зардал нэг 3 хувьтай буурч байгаа. Эд хогшил, тавилга нь 100 хувь байхгүй. Гадаад зардал 100 хувь байхгүй. Ингээд ер нь энэ төсөв талаасаа, төрийн байгууллага талаасаа ч гэсэн нэлээн таналтууд хийгдэж байгаа.

Тийм учраас яг боловсролын үйлчилгээ үзүүлж байгаа төрийн захиргааны байгууллага болоод бусад энэ хэмнэж болох ийм төвүүдээсээ бид нар цомхотгол, бүтцийн өөрчлөлтүүдээ хийж, энэ чиг үүргийнхээ давхардлыг ингэж судалж үзээд арилгах эд нар гэсэн ийм зүйлүүд байгаа. Аль болохоор ер нь тэгээд ... /минут дуусав/

Ч.Ундрам: Энэ 152 сая төгрөгийн төсвийн задаргаа нь ЕБС-ийн гүйцэтгэл үр дүнгээр олгох санхүүжилт 58 сая биш ээ, тэрбум төгрөгөөр, СӨБ-ын гүйцэтгэл, үр дүнгээр олгох санхүүжилт 27 тэрбум төгрөгөөр, Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтыг дэмжих сан 11 тэрбум төгрөгөөр, Боловсролын ерөнхий газар 4,7 тэрбум төгрөгөөр, Боловсролын сайдын шууд зардал 1,7 тэрбум, Боловсролын мэдээллийн технологийн төв 1,2 тэрбум, Боловсролын үнэлгээний төв 615,8 сая төгрөгөөр, Боловсролын хүрээлэн 808,7 сая төгрөгөөр, Боловсролын салбарын хөрөнгө оруулалт, их засвар 26,9 тэрбум төгрөгөөр, Боловсролын зээлийн сан 17,5 тэрбум төгрөгөөр, бусад 1,5 тэрбум гэсэн ийм задаргааг би өөрөө олоод гаргасан. Ийм мэдээлэл байгаа шүү.

Сангийн сайд хариулт өгье. 4 номер.

Б.Жавхлан: Мөнхтуяа гишүүний асуултад хариулъя. Боловсролын салбарын нийт зардал, төсвийн нийт зардлын 11 хувь, төсвийн урсгал зардлын 16 хувь, ДНБ-ий 3,8 хувь. Боловсролын салбарын зардлыг хөрөнгө оруулалтыг манай нийгмийн бусад салбаруудтай ялангуяа эрүүл мэндийн салбартай их харьцуулж яриад байдаг юм. Тийм. Одоо энэ хасагдаад, хэмнэгдсэний дараа ч гэсэн эрүүл мэндийн салбараас өндөр л байгаа. Төрийн албан хаагч нарын хувьд боловсролын салбар 80 мянга болчхов уу даа тийм ээ, 80 мянга гаруй, 90 мянга. Эрүүл мэндийн салбар 40 мянга хүрдэггүй. Ингээд 2,2 дахин өндөр ийм албан хаагч нартай. Боловсролын бүхий л төрлийн үйлчилгээг үзүүлж байна. Тийм.

Ч.Ундрам: Нэмж асуух уу, тодруулах уу? Мөнхтуяа гишүүн. Өөр юм байхгүй шүү дээ. Та нэмж 1 минут л авах эрх байгаа. Нэмж 1 минут өгье.

Ц.Мөнхтуяа: Энэ нөгөө төсөв танаагүй ээ гээд байгаа, тийм ээ. Гэтэл энэ дээр нөгөө төсөв дагаж, тогтоол гээд орж ирж байгаа шүү дээ. Энэ дээр ингэж байгаа шүү дээ. Боловсролын салбарын 1 хүүхдэд ноогдох хувьсах зардал... тийм үү. Тэгвэл ерөнхийдөө ингээд хасаагүй гэсэн мөртөө тогтоолоор хасчихсан ийм тоонууд харагдаад байгаа. Тэрийг дараагийн юун дээр асууна, тийм. Үгүй ээ, энэ түрүүн ярьсан шүү дээ. 400 гаруй тэрбум хасагдаж байгаа гэсэн. Сая би Наранбаяр сайдаас асуухад их мөнгө хасагдаагүй ээ, Мөнхтуяа гишүүн ээ, гэж өөрөө хэлсэн

шүү дээ. Наранбаяр сайд. Үгүй ээ, харин 400 гаруй тэрбум хасагдах байсан юм. Харин 152 тэрбум хасагдсан байна гээд сая Наранбаяр сайд мэдээлэл өгсөн шүү дээ, надад.

Ч.Ундрам: Сая гэхдээ яг тэгж хэлсэн шүү, Наранбаяр сайд аа.

Дараагийн асуулт Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Хүүхдүүд өсөж байгаа. Тэгээд боловсролын салбараас ер нь энэ зардал танаагүй байж болоогүй юм уу гэдгийг зарчмын хувьд би 1 дүгээрт, хэлье.

Суурь одоо Үндсэн хуулиар олгогдсон энэ чухал үйлчилгээний төрийн үзүүлж байгаа чухал үйлчилгээний нэг учраас хасах хасахдаа 152 тэрбум орчмоор хасна гэдэг нь дандаа цаанаа л бас л асуудал дагуулсан л зардлын таналт байна л даа. Нэг.

Тэр гүйцэтгэлийн үнэлгээ гээд байгаа бас багш нар сургуулиудад нэлээн асуудал байж байгаа. Орчны үнэлгээ гээд, ялангуяа энэ хүнд нөхцөлд ажиллаж байгаа энэ хойшоо гэр хороолол руу, хөдөө орон нутагт байж байгаа боловсролын орчны үнэлгээг нь хийгээд хийгээд, ийм хүндрэлтэй, утаа тортог, зам харгуй аюултай байдал гэдэгчлэн үүнээс нь хамааруулаад хүртэл үнэлгээнд оруулчихдаг. Тэгээд энийг нь бас хасаж байгаа юм байна.

Дараагийн нэг асуудал нь урсгал зардлаас хаслаа гэж байна. Хэзээ манай энэ боловсролын систем эцэг, эхчүүдээс мөнгө цуглуулж, ангийн засвар хийх вэ? Одоо энэ яг ний нуугүй хэлэхэд нууц байдлаар ч гэсэн явж л байгаа шүү дээ. Тэгэхээр мөнгийг нь хасчихаар нөгөө ангиа засахын тулд урсгал зардлын, одоо эд хогшил гэдэг юманд тэр өчигдөр яригдсан. Нийгмийн бодлогын байнгын хороон дээр. Одоо энэ утаа тортог энэ хүндрэлтэй байгаа үед энэ боловсролын салбар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардал гэж хэдэн төгрөг байна вэ. Төсвөөрөө бол 0,5-аас доошгүй хувиар зарцуулах ёстой. Үүгээрээ ядаж тэр хүүхэд нь багтахдаа байчихсан 60, 70 хүүхэдтэй сургууль ангиуд байгаа. Ядаж энэ утаа тортогийн үед 1, 1 агаар шүүгч авч, тэр цонхыг нь агаар шүүгч хийх, хүүхдүүддээ ус өгөх гээд л одоо ийм асуудлууд дээр тавьж болоогүй юм уу гэдгийг би бас хэлмээр байна. Шаардлагатай бол би энэ дээр зарчмын зөрөөтэй санал оруулъя гэж бодож байгаа.

Тэр цалингийн гүйцэтгэл дээр бас энийг олон л хүмүүс санал хэлээд байх юм. Манай энэ үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудаас 2-ын хооронд энэ төсөвтөө тааруулж байгаа учраас багш нарын үнэлгээ, сургуулийн үнэлгээнүүдийг дахин үнэлгээ хийгээд бууруулчихсан гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр ямар ч нөгөө гүйцэтгэлийн үнэлгээ гэдэг юм байхгүй, сайн хийсэн ч чи энэ дотроо багтах учраас муу гэдэг үнэ авна гэсэн үг. Аргаа ядаад багш нар чинь зарим хүүхдүүдэд хуурамч байдал руу түлхэж байна шүү гэдгийг хэлмээр байна.

Дараа нь хүүхдийн цэцэрлэг, сургууль, дотуур байрны хүүхдүүдийн хоолны мөнгийг хасаж байгаа гэж байгаа юм. Тэгээд яаж ч төсвөө хассан, энэ хүүхдийн хоол унд руу ормооргүй байгаа юм гэдгийг хэлмээр байна.

Мэргэжлийн боловсролоос хасаж байна гэж байна. Мэргэжилтэй боловсон хүчин олдохгүй байна гээд байдаг. Тэгээд мэргэжлийн боловсролынхноосоо хасахаар энэ чинь болж байгаа юм уу гэдгийг хэлмээр байна.

Боловсролын зээлийн сангаас 17 тэрбум төгрөг хасаж байна гэж байгаа юм. Энийг нөгөө зээлээ төлүүлэх байдлаар буцааж олж аваад тавьчихна гэдэг байдлаар тайлбарласан, ойлгосон нь зөв үү? Ийм зүйлийг хэлмээр байна. Хариултаа авчхаад дараа нь.

Ч.Ундрам: Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр ер нь энэ дотуур байрны хүүхдийн хоолны зардлын тухайд 24 онтой харьцуулахад огт хасагдаагүй. Харин эсрэгээрээ нэмж байгаа. Тэгэхээрээ энэ 4300 байсан юм, хоолны зардал нь, дотуур байрны хүүхдийн. Тэрийг 6500, дунд анги, бага ангид 4000 байсныг 6000 төгрөг болгож тооцоод, 25 оны 11 сард батлагдсан тэр төсвөөр оруулаад батлуулсан байсан нь хоригт ороод, тэгээд одоо бид энэ өнөөдөр ингээд урсгал зардлаас хасагдаж байгаа энэ хэмжээндээ энд яг ийм хэмжээгээр нэмж чадахгүй болж байгаа. Гэхдээ, ер нь хүүхдийн ирц зэргээсээ хамаараад нэг яг энэ хоолны зардлын түүхий эдийн зардал шүү дээ. Энэ чинь нэг 85-90 хувийн гүйцэтгэлтэй яваад байдаг юм. Тийм, тэгэхээр зэрэг энэ тийм, 2-3 хувь нь, юу 85-90, тийм, тийм гүйцэтгэл нь. Тэгэхээр зэрэг энэ дээр яг хэмнэлтийг эд нар оруулж байна гэж ойлгоорой. Тэгэхдээ бид хүүхдүүдийн, ялангуяа дотуур байранд байгаа хүүхдүүдийн энэ зардлыг хасаагүй, харин эсрэгээрээ нэмж явж байгаа. Тэр нэмэлт нь арай жоохон хорогдсон л гэж ингэж л ойлгож болно.

Эрүүл мэндийн зардал эд нар бол багш нарын яг энэ хувьсах зардлын 0,3 хувийг багш нарын эрүүл мэндийн үзлэгт өгч байгаа. Тэгээд энэ жилд нэг 4 төрлийн үзлэг хийдэг байсныг бидний юугаар энийг нэмж байгаа юм. Багш нарт үзүүлдэг тэр эрүүл мэндийн үзлэгийнх нь тоо, төрлийг нь нэмж байгаа. Яг хүүхдийн аюулгүй байдал, хөдөлмөр аюул гүй байдал дээр 4 тэрбум байсан нь ингээд саяын юугаар хасагдаж байгаа юм. Энэ таналтаар ингээд хасагдаад ороод ирж байгаа юм. Энэ үнэн.

Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд бид нар бүр бүтэн олгож байгаа. Тэр нэг хэл ам гарсан нь үнэн. Сая 17 тэрбум батлагдчихаад 8 тэрбумыг л өгсөн тохиолдол гарсан. Гүйцээж олго гэсэн, өөрөөр хэлбэл Боловсролын үнэлгээний төвөөс өгчихсөн энэ үнэлгээнд нь яг суурилоод нийцүүлээд энийг гүйцээж олго оо гэсэн ийм яг би шийдвэрээ өгсөн. Ингээд энэ төсвийн зохицуулалт хийгээд, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний зардал нь бүрэн олгогдоно. Иймэрхүү.

Ч.Ундрам: Нэмж Сангийн сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Түрүүн тэр хэн, Номин сайд хэлсэн тоог би сая нягтлууллаа. Хаанаас ямар тоо гараад ярьчихав. Төсвийн ерөнхийлөн захирагч сайд маань төсвөө нэг сайн хараад аваарай. 25 оны өргөн баригдсан төсөв спорт дээр таных 71 тэрбум 547 байж байгаад сая өргөн баригдахдаа, дахиж өргөн баригдахдаа 63 тэрбум 282,7 сая төгрөг буюу 8,2 тэрбум төгрөгөөр буурсан байна шүү. Тэгэхээр 75 хувь гэдэг та хаанаас ямар харсан юм, тийм, дахиад сайн хараадхаарай.

Ер нь олимпын жил өсдөг. Олимпын дараа жилээс буцаад буурдаг ийм л форматтай явж ирсэн байгаа. Нийт төсөв бол юун 75 битгий хэл ... /минут дуусав/

Ч.Ундрам: Энэ сайд, надад ирсэн мэдээллээр энэ биеийн тамир, спортын салбарын төсөв 24 онд 35,6 тэрбум, 25 оны бид нарын ярьж байгаа төсөл нь 15,7 тэрбум гээд, Үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих нь 25,7 сая олимпын жилдээ байж байгаад, буураад 9,5 тэрбум болсон гэсэн ийм мэдээлэл байна шүү.

Тэгэхээр бид хэд энэ мэдээллээ нэгтгэх ёстой. Би таныг энэ Эрдэнэбат гишүүний асуултад хариулаач ээ гээд сая танд цаг өгсөн. Энэ хүүхдийн тоо нэмэгдээд байна. Тэгээд боловсролын салбараа энэ хүүхдийн тоотойгоо харгалзуулаад дорвитой нэмж болдоггүй юм уу гэсэн ерөнхий асуулт байсан гэж ойлгож байна. 4 номер.

Б.Жавхлан: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Хүүхдийн тоогоор дорвитой нэмнэ гэдгийг би ойлгосонгүй. Энэ чинь тарифтайгаа уялдуулаад ингээд л явж байгаа. Боловсролын салбар дээрээс би түрүүн хэлсэн. Тэр манай нийгмийн гол суурь салбаруудын нэг, хамгийн өндөр төсөвтэй явдаг. Энэ хэмжээг л бариад явж байгаа. ДНБ эсвэл нийт зардалд нь харьцуулаад 6 хувь байх ёстой, 10 хувь байх ёстой гэж ярих юм бол бусад салбаруудаа бид яах вэ. Бусад салбаруудаа яах вэ. Байнгын хороо болгон дээр өөр өөрсдийн салбаруудаа ярих юм бол бид нарын төсөв багтахгүй. Нөгөө төсвөө алдагдалгүй болгоно гэдэг бодол маань бүр мөрөөдөл болж үлдэнэ. Ийм байгаа.

Тэгээд ямар ч байсан боловсролын салбар дээрээс тодорхой хэмжээнд бусад салбаруудтай харьцуулах юм бол бага хасагдсан байгаа. Гэхдээ Боловсролын яамныхантайгаа бид ярилцаж байгаа. Яг шууд өрхийн орлогод очиж нөлөөлдөг зардлууд нь тухайлбал яг нэгж, яг багшид очдог зардал ... /минут дуусав/

Ч.Ундрам: Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Хүүхдийн тоо өсөж байгаа. Баахан байшин барилгууд баригдаж байгаа. Тэрийг дагаад зардал өснө өө. Тэгэхээр яах вэ, түрүү жилтэйгээ харьцуулахад зардал өссөн гэдэг чинь механик. Саяын тэр аудитын Загджав даргын дүгнэлтэд ч гэсэн механикаар шууд хасна гэдэг нь өөрөө эргээд сөрөг үр дагавар авчихна гээд дүгнэлт гаргаад байна шүү дээ. Тэгээд энийг хэлээд байгаа юм.

Дээрээс нь Наранбаяр сайдаас бүхэл бүтэн улсын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал 4 тэрбум төгрөг тавьчихаад тэрийгээ хасна. Үүнээс болоод хүүхэдтэй холбоотой, аюулгүй байдалтай холбоотой, осол эндэгдэл янз бүрийн зүйл гарвал хэн хариуцлагыг нь хүлээх вэ. Энэ чинь өөрөө цаанаа хуультай зардал шүү дээ. Тийм учраас энэ тал дээр би энэ хариуцлагын асуудал цаана байгаа, хүүхдийн аюулгүй байдлын асуудал байгаа. Шаардлагатай бол тэр хүүхдийн сан, фондоосоо оруулж ирээд энэ хүүхдийн аюулгүй байдал, эрүүл юу руу оруулж ирэх ийм боломж бололцоо байгаагүй юм уу гэдэг зүйлийг хэлмээр байна.

Соёлын сайдаас асуумаар байна. Энэ татан буугдана, ингэнэ, тэгнэ, боловсрол энэ соёл урлагийнхнаас маш их саналууд ирээд байна. Яг энэтэй холбоотойгоор ямар сөрөг үр дагаврууд ... /минут дуусав/

Ч.Ундрам: Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Өнөөдөр боловсролын яг Монгол Улсын хэмжээнд нэг 2400 орчим боловсролын байгууллага байна. Тэр болгон дээр нь өөрсдөө төсвийн захирагч нар нь байгаа, захирлууд нь гэсэн үг, дарга нар нь гэсэн үг. Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ дотор нь энэ хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах ийм зүйлүүд нь ороод явж байгаа.

Хүүхдийн аюулгүй байдлыг хангахад хороотой хамтран ажиллаж байна, нийгмийн ажилтнууд байна, анги удирдсан багш нар нь байна, эцэг, эхийн өөрийнх нь хяналт байна, сэтгэл зүйч нь байна, Хүүхэд хамгааллын хууль байна. Тэгэхээр энэ ингээд энэ хувьсах зардлаараа ингээд олгогдоод явж байгаа. Яах вэ, хөдөлмөрийн аюулгүй байдлын яг энэ бодлогоо хэрэгжүүлэх дээр ийм мөнгө байсан нь үнэн, энэ боломжгүй болсон. Цаашдаа бид харин таны яриад байгаа зүйлийг анхаарах болно. Энэ зүгээр нэмээд нэг яахад энэ энэ жилд нэг 30-аад мянган хүүхэд нэмэгдэж орж ирж байгаа, 6 настнууд. Тэгээд ингээд иргэд орж нэмэгдэж байна гэсэн үг шүү дээ, ерөнхий боловсрол дээр. Харин СӨБ дээр бага ... /минут дуусав/

Ч.Ундрам: Наранбаяр сайдад нэмээд 1 минут.

П.Наранбаяр: Тэгээд Монгол Улсаас хүүхэд ЕБС-д сурахад 1 жилийнх нь хувьсах зардал нь нэгж дээрээ сууриалаад тооцоод үзэхэд 1,8 сая орчим төгрөгийн бид хувьсах зардал өгч байгаа. Энэ 30 мянган хүүхдээр ингээд үржүүлээд үзэхээр 54 мянган төгрөг уучлаарай, 54 тэрбум төгрөгийн нэмэлт ийм санхүүжилт шаардлагатай. Энэ нь бүрэн тусаад явж байгаа. Тэгэхээрээ бид цаашдаа ч гэсэн энэ нэгж дээр энэ асуудлыг бууруулахгүйгээр хүүхэд болгонд хүрэх ёстой боловсролын үйлчилгээг хүргээд явах болно. Баярлалаа.

Ч.Ундрам: Номин сайд хариулт өгье.

Ч.Номин: Энэ Кино урлагийг дэмжих санг татан буулгахтай холбоотой танд санал ирсэн болов уу гэж бодож байна. Ер нь Кино урлагийн сангаар дамжуулан бид нар яг цэвэр эдийн засгийн эргэлтийг дэмжих, Монгол уран бүтээлч дэлхийн зах зээл дээр гаргах дэмжлэгийг үзүүлдэг ийм сан байгаа. Өнгөрсөн хугацаанд энэ сангаар дамжуулан нийтдээ 670 гаруй уран бүтээлчид нийт Монгол Улсын хэмжээнд байдаг 33 мянган энэ бүтээлч үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн 670 гаруй орчим, 600 гаруй ийм уран бүтээлчдийг буюу уран бүтээлийг дэмжиж, олон улсын зах зээл дээр гаргах, үүнээс гадна энэ салбарын уран бүтээлчдийг чадавхжуулах ийм олон улсын хэмжээний сургалт хийдэг. Энэ ажлууд бүрэн зогсоно. Кино урлагийн салбарыг дэлхийн зах зээл дээр гаргах энэ дэмжлэгүүд бүрэн зогсоно. Өнгөрсөн хугацаанд энэ “Баавгай болохсон”, “Сэр сэр салхи”, “Чимээгүй хотын жолооч” гэх мэтчилэн энэ олон кинонууд энэ сангаар дамжиж, өөрсдөө нийт санхүүжилтийнхээ 70 хувийг олж, сангаас 30 хувиа авч, энэ олон улсын зах зээл дээр гар ... /минут дуусав/

Ч.Ундрам: Нэмээд 1 минут өгье. Номин сайдад.

Ч.Номин: Ийм боломжууд бий болсон. Нэг талдаа Засгийн газрын энэ сангаар дамжуулан кино урлагийн салбарыг дэлхийд таниулах, нөгөө талдаа

өөрсдийн Монгол контентыг буюу Монгол агуулгатай контентыг дэмжих энэ боломжууд бүрэн зогсох ийм эрсдэлд хүрч байгаа.

Ч.Ундрам: Энэ дээр нэмээд асуухад энэ Кино урлагийг дэмжих сан маань зөвхөн төсвөөс гадна бусад эх үүсвэрээр санхүүжигдэж болно шүү дээ. Тийм ээ. Тэгэхээр цаашид ирэх жил энэ сан нь өөрөө байж байвал бид нар төсөв дээр мөнгө байхгүй ч гэсэн өөр эх үүсвэрээр мөнгө төгрөг босгоод, ингээд үйл ажиллагаагаа явуулах боломж байгаа юу, Номин сайд аа.

Ч.Номин: Баярлалаа. Тийм, яг үнэн. Энэ сан маань болохоор яах вэ, төсвөөс санхүүжихээс гадна нэмэх нь энэ сая гарч ирсэн татварын 1 хувийг урлаг, спортод зарцуулах боломжтойгоор санхүүжилт олох боломжтой байгаа. Сая мөн энэ Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тухай хууль дээр нэмэгдэж орж ирсэн зүйл юу байгаа вэ гэхээр олон улсын буюу гадаад кино Монгол улсаас орлого олсон тохиолдолд олсон орлогынхоо 2 хувийг энэ санд төвлөрүүлж, энэ сангаараа дамжуулан Монгол агуулга, Монгол уран бүтээлийг дэмжих боломж бий болж байгаа.

Тийм учраас сангаа авч үлдэх нь цаашдаа энд орлого төвлөрөөд, энэ олдсон орлогоороо буцаагаад энэ салбарынхаа уран бүтээлчид, энэ салбарынхаа чадавхжуулалтыг дэмжих боломж үүсэж байгаа гэсэн үг.

Ч.Ундрам: 2 дахь асуултыг нь Ундрал даргаас асууя. Хүмүүс нэлээн эргэлзээд байна. Та хэдийг ингээд киногоо шалгаруулахдаа, сонгон шалгаруулахдаа янз бүрийн субъектив нөлөөлөл байгаад байна уу, үгүй юү гээд. Ийм олон нийтийн сүлжээнд нийгэмд ийм мессеж нэлээн яваад байна л даа. Тэгэхээр яг сонгон шалгаруулалтаа танайх яаж шийдэх юм бэ? Энэ процессоо нэг яриад өгчих.

Ч.Ундрал: Манайх яг кино хууль батлагдсанаас хойш 2022 оноос эхлээд хуулиа хэрэгжүүлээд, ингээд хуучнаар Соёлын яам бол Кино урлагийн зөвлөлийг үүсгэн байгуулсан байгаа. Ингээд 22 онд бид нар 1 удаа сонгон шалгаруулалт хийсэн. 23 онд 2 удаагийн сонгон шалгаруулалтыг хийсэн байгаа. Тэр олны яриа бол жишээ нь Оскарт явуулах гэдэг энэ сонгон шалгаруулалтын асуудал биш. Кино урлагийн зөвлөлийн гишүүд Оскараас эрх бүхий киног явуулах эрх бүхий этгээдүүд байгаа. Тэгээд Монгол Улсаас жил болгон Оскар луу кино явуулах процесс нь саяынх байсан. Дэмжих сан бол тусдаа өөр процесстойгоор явагдаж байгаа. Дэмжих сан яг энэ төрийн байгууллагын 4 гишүүд, бусад киноны салбарын 7 гишүүдтэй ингээд 11 гишүүний бүрэлдэхүүнтэй зөвлөлийн гишүүд маань мэргэжлийн үүднээс эдийн засгийн талаас нь харж байж кинонуудаа сонгон шалгаруулдаг байгаа. Ер нь манай дэмжих сан 22 оноос хойш 10 тэрбум төгрөгөө ... /минут дуусав/

Ч.Ундрам: Нэмээд 1 минут, 5 номер дээр.

Ч.Ундрал: 10 тэрбум төгрөгөөс 3,6 тэрбумын зарцуулсан. Манай санд үлдсэн 6 аравны тэрбум нь байгаа. 3,2 тэрбумыг зарцуулсан байгаа. Тэгээд ер нь ингээд 22 оноос хойш яг түрүүний хэлсэнчлэн манай кинонууд спортоор ярих юм бол олимпын аваргыг хийчхээд байгаа байхгүй юу. Жишээ нь Венец, Кан, Берлин, Талинал гэх мэт энэ дэлхийн А зэрэглэлийн наадмуудад түрүүлсэн нь маш үр дүнтэй асуудал байгаа.

Дээрээс нь бид бүхэн татварын буцаан олголт олгосноороо Вивант гээд Ти Би Эс телевизийн Японы кино орж ирсэн. Энэ нь 13 тэрбум төгрөгийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зарцуулсан байгаа. Энийг дагаад аялал жуулчлалын маршрутын 4 удаагийн ийм 480 хүний бүрэлдэхүүнтэй 3 тэрбум 272 сая төгрөгийн орлого орж ирсэн. Мөн хуулийн хэрэгжилтийн хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт 22-24 онд нийт 16 улсын кинонд бид нар ... /минут дуусав/

Ч.Ундрэм: Дахиад 1 минут нэмээд өгчихье. 1 минутдаа багтаагаарай, Ундрал дарга аа.

Ч.Ундрал: 12 тэрбум төгрөгийн орлогыг оруулсан байгаа. Ингээд гадаадын мөнгөн урсгалыг нийтдээ 29 тэрбум орчим төгрөгийг манай Кино урлагийн дэмжих сан ингээд урсгалыг татан оруулж ирж байгаа гэсэн үг. Одоо бид нарт дэмжих сан дээр маань бол 6,2 тэрбум төгрөг байгаад байгаа байхгүй юу. Тэгээд бид нар энийгээ хамгийн гол нь их бага мөнгө уран бүтээлчдэдээ өгөх нь л чухал биш. Бүх л олон улсад яг ийм дэмжих сангууд гэж байдаг. Эд нар нь бараг 20, 30 жилээр ингээд аваад явчихсан байгаа. Манайд ийм шинэ тогтолцоо дөнгөж бий болж байгаа. Бүх юм маань анхных болж байна. Хэрвээ бид бүхэн энэ дэмжих сангаа байхгүй болгох юм бол ер нь энэ кино урлагийн индустриг байхгүй болгосонтой ямар ч ялгаагүй болж байгаа юм.

Тэгээд түрүүний таны хэлсэнчлэн бид нар нөгөө зөвхөн төрөөс санхүүжээд байх биш гадаадын юнивишн, өү ти ти, кино театруудаар гарч байгаа гадаад кинон дундаас 0,2 хувийг ... /минут дуусав/

Ч.Ундрэм: 0,2 хувийг сан руугаа төвлөрүүлнэ. Тэгээд Оскарт хэн явах вэ гэдгийг танай сан шийддэггүй гэсэн үг юм байна, тийм ээ. Зөвлөл тэр чинь тусдаа өөр газар гэсэн үг байх нь байна шүү дээ, тийм ээ.

Номин сайд нэмээд энэ дээр 1 минут. Номин сайдын микрофоныг нээгээрэй.

Ч.Номин: Энэ дэмжих сангийн шалгуур үзүүлэлтийн талаар та асуулаа гэж бодлоо. Дэмжих сан болон энэ зөвлөл бий болоогүй байсантай холбогдуулан энэ зөвлөл нь үүсээгүй байсан бол Монгол Улс өнөөдөр Оскарт ямар кино дэвшүүлэх үү гэж хэрэлдэх биш Оскарт хүн явуулж чадахгүй байх байсан байхгүй юу. Дэлхий дахинаа Оскарт зөвхөн 1 газраас л санал авдаг. Зөвлөлийн гишүүд буюу энэ 11 гишүүн, үүний 7 гишүүн нь яг салбарын төлөөллүүд байж байгаад, тухайн киног Монгол Улсыг илэрхийлэх боломжтой гэдэг талаас нь шийдвэр гаргаж явуулдаг ийм зүйл байгаа. Тэгэхээр бид нар амжилт гарсан гэж энийг харах хэрэгтэй. Өмнө нь Оскарт нэр дэвшүүлэх боломжгүй байсан. Одоо бид нар Оскарт хэнийг дэвшүүлэх вэ гэдэг дээр ярьдаг болсон.

Энэ дэмжих сангийн шалгуур үзүүлэлтүүд 4 зүйл дээр ер нь голчилдог. Энэ Монгол түүх, Монгол соёлыг, Монгол хүүхдийн оюун санаанд зориулсан контентууд байх ёстой гэж үздэг. Нөгөө талдаа хамгийн гол шалгуур нь өөрсдөө санхүүжилтийнхээ 30 хувийг олсон байх ёстой гэж үздэг. Тэгэхээр санхүүжилтийнхээ суурь санхүүжилтээ олоогүй хүмүүс дэмжих ... /минут дуусав/

Ч.Ундрэм: Одоо бол. Ерөнхийдөө энэ Кино урлагийг дэмжих тухай хууль өнгөрсөн парламентад Соёлын яам байгуулагдаад энийг санаачлаад, өнгөрсөн парламентад манай Байнгын хороо батлаад, үүний дагуу энэ салбар нэлээн

хөгжиж байгаа. Гадаадаас маш олон хүмүүс ирж, манайд кино хийдэг болсон. Дагаад аялал жуулчлал нь өсөж байгаа. Энийг үгүйсгэх арга байхгүй. Тэгээд энэ парламентын Байнгын хорооны гишүүддээ та хэд яг энэ хуулийнхаа хэрэгжилтийг бас нэг танилцуулаарай, дараа нь Байнгын хороон дээр. Тийм дэлгэрэнгүй танилцуулга өгье.

Сангийн сайд нэмж тайлбар өгөх юм уу, тийм ээ. 4 номер.

Б.Жавхлан: Энэ кино урлагийг дэмжих сан одоо үлдэгдэл нь 6 орчим байгаа юм байна. Тэгэхээр 3,6 тэрбум, сүүлд нь ингээд 6 тэрбум үлдсэн юм байна. Тэр ингээд сан байхгүй болохоор энэ индустри нь энэ үйлдвэрлэлийн салбар нь бүр байхгүй устаж байгаа бол энэ төсвөөс 100 хамааралтай ийм салбар гэж байдаг юм уу? Өнөөдрийг хүртэл бид нар төсвөөс хамааралтай ийм кино урлагийн салбарыг босгож ирсэн байдаг юм уу? Бидний харж байгаагаар одоо үйл ажиллагааных нь явж байгаа энэ түвшнийг харахад заавал ингэж сан гэж тусдаа байх шаардлагагүй. Яам дотор нь яамны нэгж байгаад, ингээд явахад ерөөсөө болохгүй юм байхгүй. Энэ сан бол хандивын сан биш, эргэлтийн сан. Эндээс тараагдсан тэр дэмжлэг үзүүлсэн жишээ нь тэр уг нь бүгдээрээ зээл л байх ёстой, эргэж төлөгдөх ёстой ... /минут дуусав/

Ч.Ундрам: Сангийн сайдад 1 минут нэмье.

Б.Жавхлан: Тэгэхээр бид яг сан гэдэг ер нь яах вэ, ганц энэ сан ч биш, ер нь энэ Засгийн газар дээр байгаа олон энэ сангуудыг ер нь нэг цэгцэлье гэдэг дээр сүүлийн хэдэн жил яваад нэг их сайн амжилтад хүрэхгүй байгаа. Тэгэхээр одоо жишээ нь сан дээр 18 хүн байдаг байх тийм ээ, 18 хүн байдаг үйл ажиллагааны зардал нь 90 гаруй сая төгрөг, ирэх жилийнх дээр энэ зардал нь бүрэн тусгагдсан байгаа. Тэгэхээр яам дотроо нэгж байгаад ингээд явахад болохгүй юм байхгүй. Хэрвээ яг энэ Кино урлагийн сангийн үйл ажиллагаатай холбоотой өөр нэмэлт орлого олж байвал энэ сангийн гадуур төсвийн гадуур 1 төгрөг ч зарж болохгүй. Засгийн газрын санал бол орж байгаа орлого болгон төсөвт нь суугаад, орлого болж ороод, буцаагаад төсөв дээрээ зарлага нь тавигдаад ингээд явах учиртай. Хэрвээ Засгийн газрын сангаар л цаашаа үргэлжлүүлье гэж байвал. Түүнээс биш гадуур нь орлого олоод, гадуур нь зараад байдаг тийм Засгийн газрын сан гэж хуулиараа ... /минут дуусав/

Ч.Ундрам: Орлого нэмж олох үүргийг Төсвийн тухай хуулиар өгье гэсэн ийм санаа байна гэсэн үг үү. Та 2 тэгээд дараа нь тусдаа ярь.

Дараагийн асуултыг Галбадрах гишүүн асууна.

Ж.Галбадрах: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хэт үрэлгэн төсвийг танахыг иргэд маань хүсэж, шинэ төсөв орж ирсэн. Төсвийг хараад үнэхээр бидэнд хөгжлийн бодлого стратеги байна уу ч гэж бодогдож байна. Төсөв ерөөсөө л хөгжлийн бодлогын тусгал шүү дээ. Тэгээд хөгжлийн бодлогоо чиглүүлж зангиддаг яг нэг баздаг тийм хүн байна уу, институц яаманд байна уу гэж ингэж бодогдохоор байна. Өөрөөр хэлбэл аудитын дүгнэлтэд сая төсвийг танахдаа хувь тэнцүүлсэн байдлаар танасан гэсэн дүгнэлт орсон байна. Энэ нь хөгжлийн бодлого байхгүй, ерөөсөө л салбар болгоноос хасах гэсэн ийм чиглэл 10 хувь хасна гээд. Тэгтэл өнөөдөр энэ хэт үрэлгэн салбарт чинь манай боловсролын салбар, эрүүл мэндийн

салбар, аюулгүй байдал, цагдаа, цэрэг хүч маань орсон байна. Ингээд цөмөөрөө л хасагдсан байна. Ингээд хэдэн асуулт байна.

Эдийн засгийн хөгжлийн яамнаас боловсрол бол тэргүүлэх салбар гэдгийг бид нар тодорхойлсон. Тэгээд энэ хөгжлийн бодлоготой уялдуулан төсөвт хэрхэн тусгасан бэ? Энэ тэргүүлэх салбар гэдгийг нь 1 дүгээр асуулт.

Сангийн яамнаас асуумаар байна. Би эртээр МАН-ын бүлэг дээр нэг боловсролд оруулах хөрөнгө оруулалтыг мега төслийн хэмжээнд авч үзэх үндэслэл ба шаардлага гэсэн нэг ийм мэдээлэл тавьсан юм байгаа юм. Тэгээд энэ дотроо юуг үндэслэсэн бэ гэвэл өнөөдөр барилгын нормоороо бол нэг 30 хүүхэд суухаар барилга барьчхаад байдаг. Тэгтэл 40 давчихсан, 35 хувь больё, 40 давчихсан хүүхэд 214 мянган хүүхэд 40 давсан бүлэгт сууж байгаа нь эрх нь зөрчигдөж байна. 1400-аас дээш сургууль байхгүй ээ, нийт хүүхдийн тоо гэж ингэж заасан байдаг. Энд нь 1800-аас дээш бүр 6000 хүрчихсэн сургуулийн тоог нь тоолж гаргаад л сурч байгаа хүүхдийг нь гаргахад 328 мянган хүүхэд гээд, энэ давхардаж байгаа л даа.

Тэгээд ийм их олон хүүхдүүдийн маань Монголын ирээдүй болсон хүүхдүүдийн маань эрх нь ингээд зөрчигдөөд байхад, манай Сангийн яамныхан маань бид нар боловсролд хангалттай хөрөнгө оруулсан. Ер нь энэ хамгийн их өндрийг оруулж байгаа. Өчигдөр би Цахим хөгжлийн бодлогын, Инновац цахим хөгжлийн бодлогын байнгын хороон дээр асуухад бид нар 2 дугаарт, зам, тээврийн дараа салбарын дараа тавьсан гэж ярьж байгаа. Тэгээд энэ бол тэнд зам тээвэр энэ тэртэй харьцуулах зүйл биш. Зам тээврээс 500 тэрбум хасагдлаа гэхэд тэнд өөрчлөлт гарахгүй байж болно. Энд бол хүүхэд, хүн, багш ингээд байж байгаа. Ийм учраас бид нар энэ хөрөнгө оруулалт энэ юуг урсгал засварыг хасмааргүй байна аа?

Тэгээд миний судалгаагаар бид нар судалгаан дээр ярих ёстой. Судалгаагаар үзээд ойрын үед 3 их наяд төгрөг хөрөнгө оруулалт хэрэгтэй. Үүгээрээ бид нар мега төслийн хэмжээнд авч үзье ээ гэсэн. Тэгтэл өнөөдөр эсрэгээрээ 152-ыг хассан байна. Энэ нь ямар үндэслэл зарчим баримталсан бэ?

Дараагийн асуудал Боловсролын сайдаас асуумаар байна. Бид анхны төсөв орж ирэх үед хэлэлцэж байсан. Тэр үед өнгөрсөн жилээс даруй 200 тэрбумаар багассан байна хөрөнгө оруулалт гэдгийг шүүмжилж ярьж байсан ... /минут дуусав/

Ч.Ундрам: Нэмээд 1 минут өгье.

Ж.Галбадрах: Гэтэл одоо энэ шинэчилсэн төсөвт маань ахиад 152 тэрбумыг таначихжээ. Тэгвэл салбарын үйл ажиллагаа доголдохгүй юу? Би Наранбаяр сайдыг энэ дээр бүр их тодорхой юу, юун дээр доголдол үүсэх юм? Урсгалд ЕБС 58, цэцэрлэгт 28 тэрбум ерөнхий хассан. Үүнээс гадна үдийн цайг сургуульд 13,6 тэрбум, цэцэрлэгийн хоолыг 13,2 тэрбумаар хасжээ. Үнэхээр ийм байх уу? Наранбаяр сайд өөрөө цэцэрлэгийн хоол хүрэлцэхгүй учраас өдөрт нэг 1000 төгрөг нэмье ээ гэж уриалж байсан. Ахиад уриалах уу? Тэгээд багшийн зардал нь гүйцэтгэлийн урамшуулал 6,7 тэрбумаар хасагджээ. Ингэхээр багш нар маань улам ажлаасаа гараад дайжихгүй юу? Энэ асуудал ямар байх вэ?

Тэгээд зарчмын зөрөөтэй санал оруулмаар байгаа юм. Яав ч бид нар энэ хүүхдийн хоолны мөнгийг хасах хүртлээ явахгүй. Ийм учраас аудитын дүгнэлтийн 6.14-д заасан төсөв төлөвлөгөөгүй 170 ... /минут дуусав/

Ч.Ундрам: Эхлээд Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуулт асуусан. Баттогтох дарга ирсэн үү, Урьболд оо, чи тэгээд 1 олигтой хариулахгүй юм. Чи хэзээ ажилд орсон юм? Хөгжлийн бодлого гээд байна шүү дээ. Танай яам хариуцдаг шүү дээ. Чи асуулт ч ойлгохгүй байгаа юм уу? Даргаа дууд.

Дараа нь Сангийн яамнаас асуулт асуусан. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Галбадрах гишүүний асуултад хариулъя. 14 мега төсөл гэдэг маань сая бид мөрийн хөтөлбөр батлахдаа маш тодорхой бүгдээрээ ойлголтоо болсон байгаа. 14 мега төслөөс яг эхний 3 төсөл нь төсвийн харилцаанд ороод ингээд явж байгаа. Тэр 3 маань нефть боловсруулах үйлдвэр, хиймэл дагуул байсан юм гээд хасагдаж байгаа. Эрдэнэбүрэнгийн УЦС. Энэ 3 маань яг ийм бодитойгоор эхлээд явж байгаа. Бусад 11 төсөл бол улсын төсөвт үйлдвэрийн газрууд болон төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын зээл, тусламж гээд олон талт эх үүсвэрүүдээр хийгдэхээр төлөвлөгдөөд урьдчилсан ТЭЗҮ болон ТЭЗҮ дээрээ ажлууд нь ингээд явж байгаа. Тийм учраас яг төсөв дээр ингээд шууд харагдахгүй байгаа. Ингээд ямар ч байсан ажлууд явж байгаа.

Тийм учраас 14 мега төсөл рүү энэ өргөн баригдсан төсөв дээрээс зардал хасагдаад, тэрний улмаас эрсдэл үүсэх зүйл бол харьцангуй бага. Ирэх жилийн яах вэ, гадаад зээлийн ашиглалт дээр байгаа нефть боловсруулах үйлдвэрийн ирэх жилийн санхүүжих дүн тодорхой хэмжээнд хасагдана. Тэгэхдээ төсөл зогсох хэмжээнд эрсдэл учрахгүй. Төсөл цаашаа үргэлжлээд явна. Тийм.

Ч.Ундрам: Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Тэгэхээр ер нь 152 тэрбум төгрөг ингээд хасагдаж байгаа. Энэ удаагийн энэ хасалт ер нь л салбар болгоноос л хасаж байгаа ийм л зүйл байгаа. Тэгээд би гишүүний таны хэлж байгаатай 100 хувь санал нэг байна. Гэхдээ өнөөдөр яг энэ хасагдсан хүрээндээ бид нар аль болохоор үйл ажиллагааг нь доголдуулахгүй байх ийм л зорилго тавиад ажиллаж байгаа. 24 оны төсөвтэй харьцуулахад энэ нь нэмэгдэл нь нэмэлтүүд нэмэгдэж гарч ирж байгаа. Сая харин 25 оны төсөвтэй харьцуулахад л ингэж 11 сард барьсан төсөвтэй харьцуулахад бууж орж ирж байгаа юм.

Хүүхдийн хоолны тухайд бол би түрүүнд ярьсан. Энэ ялангуяа цэцэрлэгийн энэ хүүхдийн хоол, нийслэлийн хүрээнд 1000 төгрөг нэмээд, эцэг эхчүүд нь төлөөд, хүүхдийн хоолны орц нь нэмэгдээд ингээд явж байгаа. Энэ ажил нь явж байгаа. Уриалаад ... /минут дуусав/

Ч.Ундрам: Нэмээд 1 минут 2 номер дээр.

П.Наранбаяр: Тийм уриалж дуусаагүй шүү. Энэ яг нэмэгдээд бодитой ажил болоод явж байгаа. Түрүүнд хариулсанчлан яг энэ дотуур байрны хүүхдийн энэ хоолны зардал дээр бид нэлээн сайн нэмэгдүүлэхээр барьж орж ирсэн ч эндээ хүрч чадаагүй. Ахлах ангийн хүүхэд 4300 байсныг 6000 төгрөг, дунд ангид 4000 байсныг 6000 төгрөг болгохоор төлөвлөж оруулж ирсэн боловч энэ удаагийн энэ

хасалт дээр энэ орсон. Тэгэхээр байгаа хэмжээнд нэмнэ ээ. Яг байгаа энэ 4300-аасаа дээшээ 6500 болгож чаддаггүй юм гэхэд нэмнэ ингээд явна. Цаашдаа ер нь бол хүүхдийн хоол дээр эцэг эх ч гэсэн хуваалцаж болно гэсэн ийм хуулийн заалттай, эцэг эхчүүд ч гэсэн өөрсдийнхөө үүргийг ингээд асуугаад бид ингээд нэмж явж болно. Энэ бол ингээд асуудалгүй гэж. Бүх юмыг төр дангаараа хариуцна гэж хэцүү шүү дээ.

Тэгэхээр энэ дээр эцэг, эхчүүдээсээ бид асуугаад, нийгмийн хувьд консенсус буюу зөвшилцөлд хүрсэн тохиолдолд сая цэцэрлэгийн хоол дээр энэ шууд ажиглагдсан. Ингээд хүрсэн тохиолдолд энэ чинь зөвхөн хүүхэд ... /минут дуусав/

Ч.Ундрам: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Би Галбадрах гишүүний асуултад нэмж хариулъя. Энэ аудитын дүгнэлтийн 6.14 дээр тэр 177,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтөө 99,2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 4 төслийг би таныг хэллээ гэж ойлголоо. Энэ 4 төсөл нь ийм юм байгаа шүү. Тэр 26 онд зохион байгуулах нэг СОР-той холбоотой энэ барилга байгууламж биш одоогоор яг нэг бүхэл, нэг бүтэн цогцолборын тийм ТЭЗҮ хийх боломжгүй, зохион байгуулалтын болон тийм мобайл хэлбэрээр хэрхэн яаж хийх вэ гэдэг дээр урьдчилсан байдлаар зохион байгуулалт нь яригдаж байгаа ийм асуудал юм байгаа юм. 50 тэрбум төгрөгөөр ингээд төсөвлөгдсөн зүйл байгаа. Энэ бол олон улсын өмнө ялангуяа НҮБ-ын өмнө Монгол Улсын амласан зохион байгуулахаар үүрэг авсан ийм үйл ажиллагаа байгаа.

Дараагийнх нь энэ Өнөр бүл энд, Өнөр бүл төв дээр нөгөө хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төрөлжсөн асрамжийн газар гээд. Энэ Монгол Улсын Ерөнхийлөгч ... /минут дуусав/

Ч.Ундрам: Нэмээд 1 минут өгье.

Б.Жавхлан: Тийм. Тус төв дээр ажиллах явцдаа энэ өргөтгөлийг хийх үүргийг Засгийн газарт өгсөн. Төсөв өргөн барих үед эцсийн байдлаар зураг төсөв нь бэлэн болж хараахан амжаагүй, одоо хийгдэж байгаа. Гэхдээ ямар ч байсан ирэх жил барина гэсэн ҮАБЗ-өөс ирсэн чиглэлийн дагуу төсөвт тавигдсан байгаа.

Төрийн албан хаагчдын орон сууцжуулах цогц хөтөлбөр. Энэ мөн нэг цогцолбор биш ТЭЗҮ баригдах, нэг цогцолбор биш. Төсвийн ерөнхийлөн захирагч нь БХБ-ын сайд. Энэ бол орон даяар хийгдэх төслүүд. Өөрсдөө сайд нар тэр тоног төхөөрөмжтэй ижилхэн бэлэн байдал нь хаана илүү хангагдсан байна, хаана илүү шаардлагатай байна, аль болох тухайн жилдээ баригдаад дуусах ийм эрэмбэ дараалалтайгаар сайд нь өөрөө зохицуулалт хийгээд явдаг ийм зүйл байгаа.

Гадаргын ус хуримтлуулах төв гээд энэ баруун аймагт байгаа. Энэ нь тийм, энэ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд дээр тавигдсан төсөл. Энэ зураг ... /минут дуусав/

Ч.Ундрам: Зураг төсөл нь хийчихсэн юм уу тийм ээ.

Галбадрах гишүүн нэмэлт 1 минут.

Ж.Галбадрах: Тэгээд би зүгээр, мега төслийн хэмжээнд авч үзээч л гэж хүсэлт гаргаад байгаа юм. Ерөөсөө тэгэхээр, үнэхээр ирээдүйн Монгол орон хөгжье өө л гэвэл хүнээ хөгжүүлнэ. Тэгээд хүний хөгжил нь боловсролтой байна. Үнэхээр тэр 40 хүүхэд авчихсан, 1800 хүүхэд авчихсан сургууль дээр боловсролын чанар ерөөсөө яригдахгүй байна. Тэгэхээр энэ чанар яригдахгүй байгаа үед ирээдүй маань ямар болох вэ гэдэг нь хүн болгонд ойлгомжтой. Хүн болгон л боловсролоо яриад байгаа. Тэгэхээр тэр тийм хэмжээнд авч үзье ээ, тэгээд эрэмбэлье ээ, тэргүүлэх салбар гэдгээр нь 1 дүгээрт нь авч үзье ээ л гэдгийг хэлэх гээд байгаа юм. 152-ыг ер нь тэрбум төгрөг хасахгүй байж болоогүй юу? Наранбаяр сайд энэ тайлбаруудыгаа судалгаан дээрээ үндэслээд ингээд яриад, засаг дээрээ сайн ярих ийм боломж байдаггүй юм уу л гэдгийг асуугаад байгаа юм.

Ч.Ундрам: Ерөнхийдөө нөгөө боловсролын салбарт зарцуулж байгаа мөнгө хөрөнгө оруулалт, зардал биш. Тэгээд ирээдүйд энэ нь эргээд Монгол Улсад эдийн засгийг улам өсгөж тэлэх тэр боловсон хүчнийг бэлдэж байгаа гэдгийг манай энд сууж байгаа бүх хүн мэдэж байгаа байх гэж найдаж байна. Тэгээд Галаа, Галбадрах гишүүн бүлэг дээр мега төсөл, боловсролын салбарыг мега төсөл болгох нь гээд ингээд судалгаатай ийм санал дэвшүүлсэн. Мөн энэ Боловсролын хуулийн хэрэгжилтийн ажлын хэсгийг та ахалж байгаа. Тэгэхээр хэдүүлээ энэ ажлын хэсгээрээ ажиллаад, тэгээд 2026 оны төсөвт одоогоос бэлдэх хэрэгтэй. Яаж энийгээ оруулах юм, тусгах юм. Тэгээд энэ асуудлаа Ерөнхий сайдад, Шадар сайдад, мөн Сангийн сайд гээд энэ Засгийн газрынхандаа Байнгын хорооныхоо гишүүдтэйгээ хамт ингээд яриад, танилцаад, эртнээс төсвийн цикл эхлэхээс өмнө хэдүүлээ энийг боловсролын жил болгох ч юм уу, ийм уриаг дэвшүүлээд явъя гэж би бодоод байгаа. Ер нь цаашид.

Тэгээд Наранбаяр сайд та энэ хүүхдийн хоолны мөнгө 24 онд яг хэд байж байгаад одоогийн энэ өргөн барьсан төсөвт яг хэд болсныг 24 оны төсөвтэй нь нэг харьцуулаад хэлээд өгөөч. Мөн саяын энэ Галбадрах гишүүний хэлээд байгаа зүйлд Сангийн сайд нэмээд бас тайлбар өгчих.

П.Наранбаяр: Ер нь хоол, хүнснийх нь зардал 24 онд 130 тэрбум байсан, 130 тэрбум 336 сая. Энэ жил одоо энэ 25 оны сая өргөн баригдсан энэ төсөв нь 178 тэрбум 121 сая төгрөг болж байгаа. Тэгэхээрээ нэг 48 тэрбум төгрөгөөр нэмэгдчихээд байгаа юм, ер нь нэмэгдчихээд байгаа юм.

Тэгээд мега төслийн хүрээнд ингээд яриад байгаа боловсролууд тэргүүлэх салбар болгоё гэсэн энэ бол зайлшгүй хэрэгтэй шүү. Энэ микрофоныг ашиглаад нэг уриалахад ирэх жил энэ манай Сангийн яамныхан, Эдийн засаг, хөгжлийн яамныхан ч гэсэн яаж байгаад Галбадрах гишүүний яриад байгаа яг энэ мега төслийн хүрээнд сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэг мөсөн шийдчихье л дээ. Тэгэхгүй л бол энэ чинь жил жилдээ явсаар байгаад 2030 он гэхэд хамгийн айхтар ачаалал дээрээ очно. 40 он хүртэл энэ чинь ачаалал дээрээ очно. Энийг ингээд нэг мөсөн нэг загварын ... /минут дуусав/

Ч.Ундрам: Сангийн сайд нэмээд хариулъя.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмж хариулъя. Мега төсөл гэхээр сая бид 4 жилийн Засгийн газрын мөрийн хөтөлбөр баталсан. Тэнд мега төсөл гэж юуг хэлэх вэ гэдгийг тодорхойлоод, 14 эдийн засгийг дэмжих, эдийн засгийн салбарын өөрөөр хэлбэл арилжааны гэсэн үг шүү. Арилжааны бизнесийн бүтээн

байгуулалтуудыг энд оруулсан байгаа. Нийгмийн салбарууд бол тусдаа. Ингээд, өөрөөр хэлбэл эдийн засгаа дэмжээд, эдийн засгийн эргэлтээ нэмээд, ДНБ нэмэгдэх хэрээр төсөв тэлэх боломж гарах юм бол тэр боломжууд дандаа л нийгмийн салбар руу л ордог. Төсөв нэмэгдэж байгаа, төсөв нэмэгдсэн хамгийн их хувь нь боловсролын салбарт очдог. Дараа нь эрүүл мэндийн салбарт л очдог.

Тийм учраас энэ эдийн засаг талдаа ч тэр, нийгмийн салбар талдаа ч тэр бид нар энэ аль аль их үүргийг нь их сайн харж ингэж явах хэрэгтэй.

Нийгмийн салбар дотроо яаж эрэмбэлж энэ яаж явах вэ гэдгийг дээр тусдаа энэ бодлого яриад явахад энэ нөгөө эдийн засгийн 14 мега төслөөсөө тусдаа гэдэг асуудал шүү. Тийм.

Ч.Ундрам: Тэгэхдээ та дэмжиж байгаа шүү дээ, тийм ээ. Угаасаа өнгөрсөн 4 жил яах вэ, манай боловсролын салбарын төсвийг дэмжээд л, нэмээд л ирсэн л дээ. Тэгээд гол нь нөгөө мега төсөл гэж нэрлэхгүй ч гэсэн тэр хэмжээнд ингээд цаашаа авч яваад төсөв дээрээ, дараа дараагийн төсөв дээрээ хэдүүлээ тал талаасаа анхааръя л гэдэг би энэ асуудлыг тавиад байгаа шүү дээ, тийм ээ.

Дараагийн асуулт Бум-Очир гишүүн.

Д.Бум-Очир: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Түрүүн Байнгын хорооны дарга Ундрам гишүүн асуугаад байна. Би урьд нь хэлж байсан. Тэр үр дүн, гүйцэтгэлээр Боловсролын яаман дээр үр дүн гүйцэтгэлээр олгох гэдэг дээр ерөнхий боловсролоос 57 билүү, 58 билүү тэрбум, СӨБ-өөс бас нэг 27 билүү тэрбум гэхчсэн байгаа. Үүний задаргааг мэдмээр байх юм. Энэ, би ойлгохдоо багш нарын гүйцэтгэлийн үнэлгээг нэмж байгаад тэрийгээ хүссэн хэмжээндээ нэмж чадахгүй буцаагаад буулгаж байгаа юм байна гэж ойлгосон. Зөв ойлгоод байна уу, буруу ойлгоод байна уу?

Дараагийн нэг зүйл. Нийт боловсролын салбараас 52 тэрбум хасаж байгаа гэдэг ийм зүйл сайд нар, 152 тэрбум. Тэгээд энэ саяын бид нарт тараасан бичиг дээр болохоор 148,9 буюу 3,3 хувь гээд ингээд өмнө нь бас 7 хувь гэдэг нэг үг гарсан. Энэ тоонуудаа нэг хэдүүлээ ойлголцоод, ойлголцоо нэгтгэж авахгүй бол би хүртэл чуулган дээр нэг үг хэлээд л авсан. 152 гэдгээр хэлсэн 7 хувь гэдгээр хэлсэн. Энэ дээр 3,3 болчхож. Одоо тэгээд та хэдээс орж ирсэн, эс үгүй бол хэлж байгаа тоог бид заавал нэг нягталж үзэж байж хэлэхгүй бол ингээд буруу мэдээлэл цаашаа явах гээд байна л даа. 1 дүгээр зүйл. Энийг нэг тоолоод, тооцоод, яг тодорхой хэлээд өгөөч. Үнэхээр л багш нарын гүйцэтгэлээс бууж байгаа юм уу? СӨБ-ийн багш нарын гүйцэтгэлээс бууж байгаа юм уу? Гүйцэтгэл үр дүн гэдгийн ард эс үгүй бол өөр юм байгаад байгаа юм уу гэдгийг 1 дүгээр зүйл.

2 дугаар зүйл сая тэр соёлын тухай асуудал дээр яригдлаа. Жавхлан сайд бол яам дээрээ нэг тийм нэгж болгоод энийгээ үйл ажиллагаагаа явуулаач ээ гээд тэгж байна л даа. Тэгээд тэгэх шаардлага юм уу тэгэх боломж байгаа юм уу. Би энэ сан байх байхгүй асуудлыг ингээд 2 сайд ярьж байна. Энэ дээр гайхаад байна л даа. Хуулиараа байгаад тэр нь өөрөө өөрийгөө ингээд тодорхой хэмжээгээр эд нар өөрсдийгөө санхүүжүүлэх алхам хайгаад яваад байх шиг байна л даа. Тэгэхээр өөр нэгж гэдэг нь чухам юу байх юм? Одоо тийм хууль, эрх зүй байх юм уу, яах юм гэдгийг нэг тайлбарлаад өгөөч. Баярлалаа.

Ч.Ундрам: Эхлээд Наранбаяр сайд боловсролын төсөвтэй холбоотой тайлбар.

П.Наранбаяр: Энэ 152 тэрбум төгрөгийн урсгалаас ингээд хасагдаж байгаа. Энэ бол 3,6 хувь юм байна лээ шүү. Тэр би жоохон он биш ээ, тоо андуурч тэр хувь, хувийг нь хэлсэн ийм тал бий. Тэр дээр ер нь ингээд засъя. 3,6 хувь. Анх бол ер нь Засгийн газар дотор хэлэлцэгдэх үед нэлээн өндөр дүнтэй орж ирж байсан, 404 тэрбумаар 10 хувь гээд. Тэгээд энэ бол ингээд 152 хүртлээ бууж, ингэж орж ирж байгаа. Юуны хувьд ерөнхий боловсролын гүйцэтгэл үр дүнгээр олгох сургуулийн, СӨБ-ийн, насан туршийн, мэргэжлийн болон техникийн сургалтыг дэмжих сан гээд энэ 2025 онд өргөн баригдаад сая хоригт орчихсон төсөвтэй харьцуулахад 58 тэрбум, 27 тэр тэрбумаар бууж байгаа. Жишээ нь СӨБ нь бол ЕБС нь бол. Гэхдээ энэ нь өөрөө 24 оны төсөвтэй харьцуулахад жишээлбэл ерөнхий боловсрол нь 194 тэрбум 840 сая төгрөгөөр нэмэгдэж байгаа юм. СӨБ нь 76 тэрбум 553 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж байгаа зүйл байгаа юм. Энэ задаргааг нь ингээд харах юм бол байр ашиглалтын үйлчилгээ, үдийн цай, дотуур байрны үйлчилгээ, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт, сургууль, цэцэрлэгийн гүйцэтгэлийн үнэлгээний санхүүжилт, багшийн гүйцэтгэлийн үнэлгээ, тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардал, төрийн бус өмчийн СӨБ, ЕБС-ийн хувьсах зардал гэх мэт зүйлүүд ингээд орж ирж байгаа. Ер нь ЕБС-ийн гүйцэтгэл үр дүнгээр олгох санхүүжилт бол нийт хасагдсан дүнд яг 25 оны хоригт орсон төсөвтэй харьцуулахад нөгөө -2,6 хувь байгаад байгаа юм. Ийм байгаа шүү гэдгийг танд тайлбарлаж хэлье.

Ер нь энэ боловсролын салбар энэ эдийн засгийн өсөлтийг өөрийг нь бий болгодог салбар шүү. Энэ чинь тэнд байгаа боловсон хүчин чинь л хүн нь байж байж хөгжил нь орж ирдэг ийм салбар. Энэ тэргүүлэх салбарын хүрээнд Монгол Улс ч гэсэн энэ бодлогоо тууштай хэрэгжүүлнэ. Хэрэгжүүлэх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа. Баярлалаа.

Ч.Ундрам: Жавхлан сайд нэмэлт хариулт.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмж хариулъя. Наранбаяр сайдын хэлж байгаа концептой Засгийн газар 100 хувь цуг шүү дээ. Гагцхүү энэ төсвийн өөрөө хэмжээ боломж маань л ийм байгаа гэсэн үг. 4,4 их наяд гэдэг бол нөгөө 14 мега төслийнх чинь төсөл бүрээс том дүн, бүр мегагийн мега дүн, дүнгээр нь ярих юм болбол. Тийм учраас цаашдаа ч гэсэн энэ зарчим алдагдахгүй. Харин бид нар энэ 14 мега эдийн засгийн төслүүдээ түлхүү явуулж байж, ДНБ маань тэлнэ. Төсвийн боломжууд маань тэр хэмжээгээр тэлнэ. Тэр хэмжээгээр нийгмийн суурь салбарууд руугаа хөрөнгө оруулалт хийх боломжууд нэмэгдэнэ. Тэгээд боловсролын салбар Мегагийн мега төсөл шүү, одоо, одоо ч гэсэн.

Ч.Ундрам: Та нөгөө сантай холбоотой асуултад нь хариулчих. Номин сайд уу? Номин сайд.

Ч.Номин: Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Энэ Кино урлагийг дэмжих сан үүний үйл ажиллагааг явуулж байгаа Кино урлагийн зөвлөлийг бид нар бие даасан хараат бус салбарын төлөөллүүдээр суурилсан мэргэжлийн болгох үүднээс төрөөс гадуур байх ёстой гэж үзэж байгаа. Тэр утгаараа нөгөө талдаа бид нар нэгэнт шинэ эдийн засгийг бий болгож, бие даасан салбар болгож, олон улсад хөгжүүлээд, олон улсын зах зээл дээр байгаа 2,2 их наяд долларын зах зээл рүү

өрсөлдөх чадвартай Монгол уран бүтээлчдийг бий болгохын тулд бид нар бойжуулж авч явж байгаа салбартаа тодорхой түвшний дэмжлэг үзүүлэх үүднээс энэ сан үйл ажиллагаа явуулдаг байгаа. Тэгээд энэ ч утгаараа хараат бус, шууд, төрийн аль нэг хүний үзэмжээр шийдэгддэггүй. Мэргэжлийн гишүүд нь өөрсдөө олон улсын чанартай бүтээлээ сонгон шалгаруулах үүднээс ийм тусдаа төрөөс гадуур ийм зөвлөл байх нь зүйтэй гэж үздэг. Энэ зөвлөл дан ганц Монголд бид нар санаж гарч ирээд хийчхээд байгаа зүйл биш. Дэлхий би 100 гаруй оронд яг ийм зөвлөл үйл ажиллагаа явуулдаг. Өнөөдөр ... /минут дуусав/

Ч.Ундрам: Нэмээд 1 минут.

Ч.Номин: Өнөөдөр бид нарын бүгдээрээ магтаж яриад Солонгос шиг сайхан газар алга гээд байгаа, яриад байгаа газар чинь яг ийм сан 430 сая долларын төрийн санхүүжилттэйгээрээ тухайн улсынхаа агуулгатай контентыг дэлхийд сурталчлаад явж байна. Яг энэ шиг бид нар нэг 10 тэрбум төгрөг дотор эргэлдээд, энийгээ эргэлтийн сан болгоод, нөгөө талдаа бид нар хувийн хэвшлээсээ санхүүжилт төвлөрүүлээд, төрөөсөө тодорхой дэмжлэг үзүүлээд ингээд Монгол уран бүтээлчдээ, Монгол агуулгаа, Монгол бүтээлээ дэлхийн тайзан дээр гаргах гээд байгаа энэ сангийн хувьд болон энэ зөвлөлийн хувьд үйл ажиллагаа нь сүүлийн 2 жилийн хугацаанд маш сайн болж жигдэрч, Монгол уран бүтээлчид үүний үр шимийг хүртээд, дэлхийд өөрсдийнхөө хөрөнгө оруулалтыг дээрээс нь нэмээд оруулаад, манай оруулсан 1 төгрөг болгоныг хувийн хэвшил 3 төгрөг нэмж оруулаад ингээд дэлхийд өрсөлдөөд явж байгаа ийм үйл ажиллагаатай сан байгаа.

Бид нар төсвийг танахыг хүлээн зөвшөөрч байгаа. харин Үндсэн хуульд битгий орооч ээ л гэж байгаа юм.

Ч.Ундрам: Тодруулах уу? Бум-Очир гишүүн.

Дараагийн асуулт Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Баярлалаа. Тэгэхээр сая Номин сайд ч хэлчихлээ л дээ. Яг нэг яах вэ, нөгөө Монгол Улсыг нөгөө эдийн засаг талаас нь ингээд аваад үзэхээр ер нь цаашдаа бид нар ингээд томроод явахад нөгөө уул уурхайгаас хэт хамаарлаас ямар салбар аврах вэ гэх юм бол яг үнэнийг хэлэхэд өрсөлдөх чадвартай салбарууд л байх юм. Тэгэхээр түүн дээр нэг их олон салбар байхгүй. Ер нь урт хугацааны хөгжлийн бодлого дээрээ ч бид нар тодорхойлчихсон байдаг. Тэрний нэг нь яалт ч үгүй хэчнээн маргаан дагуулсан ч нөгөө соёлын бүтээлч үйлдвэрлэл мөн л дөө. Тэр дундаа энэ кино урлаг бусад уул уурхай ч юм уу, үйлдвэрлэлтэй ингээд харьцуулах юм бол олон өөрийн гэсэн давуу тал байгаа байхгүй юу. Өрсөлдөх давуу тал тийм ээ, тэр бүтээлч сэтгэлгээ, Монголын арвин түүх байна. Үүгээрээ дамжуулаад дараагийн тэрбум долларын салбар болж өргөжих бүрэн боломж байгаа юм л даа.

Тэгэхээр яах вэ, энэ удаагийн төсөв дээр ингээд хасагдсан ч гэсэн гэхдээ энэ Кино урлагийг дэмжих сангийн тухай хууль 2 жилийн хэрэгжилт дээрээ сая ингээд сонсож байхад нэлээн олон үр дүн гарсан харагдаж байгаа юм л даа. Тэгэхээр эдийн засгийг солонгоруулах талаасаа ер нь ерөөсөө цоо эдийн засаг талаас нь харсан ч, яалт ч үгүй энэ хамгийн өрсөлдөх давуу тал үүсгэж чадах

салбаруудын нэг байхгүй юу. Тэгэхээр энэ дээр байгаа залуучуудаа дэмжих ёстой л гэж бодож байгаа юм.

2 дугаарт, боловсрол сая Мөнхтуяа гишүүн ч ярилаа л даа. Сая Сангийн сайд дурдах шиг боллоо. Ер нь бид нар бусад улстай л харьцуулах ёстой. Ер нь боловсролын салбар дээр бид нар хөрөнгө оруулалтыг хаана явна? Тэгэхээр дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулахад Мөнхтуяа гишүүн сая 4,6 хувь гэж тоо гарсан тийм ээ. 4,4 их наяд төгрөгийг бид нар 95 их наяд их наядаар харьцуулах юм бол нэг 4,6. Гэхдээ Сангийн сайд сая 3,8 гээд, яах вэ 4,6 хавьцаа л байх шиг байгаа юм. Энэ нь яах вэ, юу юм. Бид нар олон улсын жишигтэй харьцуулах юм бол дэлхийн дундажтай ер нь маш ойролцоо. Яг л дэлхийн дундаж дээр л яваа юм. Гэхдээ бид нар яг ийм байгаагүй. Ер нь 2000 он, 2010 он, 2015, 2016 он хүртэл бид нар дотоодын бүтээгдэхүүнийхээ ойролцоогоор нэг 5-6 хувийг бид нар зарцуулж ирсэн юм байна лээ, төсөв дээрээ. Тэгэхээр энэ ингээд эдийн засаг томрох тусам эзлэх хувь нь ингээд буураад байгаа нь яг үнэнийг хэлэхэд бид нар хамгийн урт хугацаандаа шаардлагатай хөрөнгө оруулалтаасаа бид нар танаад байна л гэсэн үг болчхож байгаа юм л даа. Тэгэхээр энийг бид нар тогтмол нэг 5-6 хувиасаа огт бууруулахгүйгээр явах энэ зарчмаа 1 дүгээрт хадгалах хэрэгтэй байгаа юм.

2 дугаарт, бас юу байгаа. Бид нар Үндэсний баялгийн сангийн тухай хууль баталсан. Ер нь ард түмний хүсээд байгаа зүйл нь баялгийн шударга хуваарилалт л гээд байгаа юм. Гэхдээ баялгийн шударга хуваарилалт гэдэг нь нэг бэлэн мөнгөөр тараах биш яг үнэнийг хэлэхэд тэдний үр хүүхдэд нь боловсрол руу нь хөрөнгө оруулчих л гээд байгаа юм. Тийм учраас бид нар Хуримтлалын нэгдсэн сан гэж баталсан шүү дээ, тийм ээ. Тэгэхээр боловсрол руу бид нар тэр уурхайгаас орж ирж байгаа орлогынхоо хэсэг хувиар ... /минут дуусав/

Ч.Ундрэм: 1 минут нэмье.

О.Батнайрамдал: Хийе ээ гэж байгаа юм. Хэрвээ тэгж чадах юм бол бид нар дотоодын нийт бүтээгдэхүүний 6 хувьд хүрэх бол ер нь асуудалгүй амархан, ер нь хүрэх бүрэн боломжтой юм. Тэгэхээр яах вэ, энэ дээр бид нар олон талаасаа ажиллаж байгаад хуримтлалын нэгдсэн санг бид нар хуулиа баталчихсан байна. Бүх боломж нь байна. Тэгэхээр 6 хувьдаа л хүргэж чадах юм бол ер нь алсдаа Монгол Улсын ирээдүйг аврах ганц зүйл ерөөсөө л боловсрол шүү дээ.

Бас нэг асуулт Боловсролын зээлийн сан сая Наранбаяр сайд ярьж байна л даа. Яах вэ, Боловсролын зээлийн сан дээр 17,5 тэрбум хасагдсан гээд. Гэхдээ энэ тал нэг талаасаа би хар даа, ингэж бодож байгаа юм. Магадгүй муу зүйл биш байх аа, яах вэ бүгд ингээд хасагдаж байхад Боловсролын зээлийн сангаас нэг 17,5 хасагдсан байна. Гэхдээ нөгөө талаасаа энэ нь эргэн төлөлтийг тэгвэл Боловсролын зээлийн сангийн төлж чадахгүй байгаа эргэн төлөлтийг та зайлшгүй бүр авч хараад тийм ээ, илүү серъёзний авч үзэхээс өөр аргагүй болж тулгаж байна гэсэн үг юм. Тэр магадгүй ... /минут дуусав/

Ч.Ундрэм: Дэгээрээ дараа нь 1 минутын тайлбар авах эрх байгаа шүү.

Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Ер нь Батнайрамдал гишүүний хэлээд байгаа энэ маш чухал зүйл. Манай улс бол 1 хүүхдэд сургах хувьсах зардал нь нэг ойролцоогоор 1,8 сая төгрөг буюу ердөө нэг 500 орчим долларыг зарцуулж байгаа юм. Тэгэхэд дэлхийд нөгөө боловсролоороо гайхагдаад байгаа Финлянд чинь 13700 долларыг зарцуулж байгаа байхгүй юу, 1 хүүхдэд. Тэгэхээр бид энэ нэгж дээр энэ хуваарилагдаж байгаа энэ хувьсах зардлыг өсөх бодлогыг зайлшгүй барих хэрэгтэй. Ингэж байж энэ төсөв өөрөө хүүхдээ дагаад, өсөлтөө дагаад нэмэгдээд явах учиртай. Өнөөдөр төсвийн нийт зарлагын ердөө 12,5 хувь байгаа шүү дээ. Уг нь Тогтвортой хөгжлийн зорилтод 20 хувь хүргэнэ ээ гээд заачихсан байгаа. Ийм зүйлүүд байдаг. Тэгэхээр уул уурхайгаас орж ирж байгаа энэ орлогуудыг энэ боловсрол руу оруулах эд нар гээд энэ их бодлогуудыг нь макро эдийн засгийн түвшинд шийдэх ёстой гэж бодож байгаа.

Боловсролын зээлийн сан дээр 17 тэрбум хасагдаж орж ирж байгаа нь бид эргэн төлөлтөө сайжруул л гэсэн ийм дохио. Тэгэхээр бид хуульчдад хандана. Хуулийн ферм дээр хандана. Эргүүлж төлүүлэх асуудлыг хуулийнх нь хэллэгээр ярина. Мөн чөлөөлөгдөх ёстой, үгүй гэсэн ярвигтай ийм асуудал байгаа. Энийг нэг мөр гаргана. Тэгэхээрээ манай зүгээс дахиад сүүлийн үеийн мэдээллээ Байнгын хороон дээр байгуулагдсан ажлын хэсэгт явуулъя. Тэгээд тантай хамтарч ажиллаж байгаад эргэн төлөлтөө ч сайжруулъя. Чөлөөлөх энэ дүрмээ ч гэсэн ойлгомжтой болгоё. Ингэж байж энэ урагшаа явна. Тэгэхгүй бол 2011 онд гарсан хуулиас болоод ерөөсөө ингээд нэг ийм гацалтын байдалд орчихсон ийм сонин байдалтай яваад байгаа юм. Баярлалаа.

Ч.Ундрам: Наранбаяр сайд аа. Энэ Боловсролын зээлийн сангийн төсөв 24 оны төсөв, одоо энэ өргөн баригдсан төсөв 2 яг ямар дүнтэй байгааг нэг хэлээд өгөөч. Тэгээд Батнайрамдал гишүүн энэ Боловсролын зээлийн сантай холбоотой ажлын хэсгийг та ахалж байгаа. Ирэх 7 хоногийн Байнгын хороон дээр танай асуудал, ажлын хэсгийн чинь явц танилцуулагдах ёстой. Тэгэхээр та хэд маань тийм хуваарьтай байгаа шүү. Ажлын хэсгээ хуралдуулаад, Наранбаяр сайдтай уулзаад тэгээд танилцуулгаа бэлдэнэ.

Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Энэ Боловсролын зээлийн сан одоо бол 124 тэрбум, байж байгаарай, энд энэ тийм, өргөн барьсан 158 тэрбум төгрөг, биш ээ юу билээ, тийм, 158 тэрбум төгрөг, тэгээд тэрнээсээ 17 тэрбум төгрөг өнөөдөр хасагдсан ийм байдалтай байгаа.

Ч.Ундрам: 24 оны төсөв чинь хэд юм бэ? Энэ жилийн боловсролын зээлийн сан

П.Наранбаяр: 24 онд чинь 125 орчим тэрбум төгрөг байсан, эндээсээ нэмэгдээд өнөөдөр ингээд 158 тэрбум тийм байгаа. 30 орчим тэрбумаар нэмэгдсэн.

Ч.Ундрам: Окэй. Би та хэдийг нөгөө яг энэ жилийн төсөв, ирэх жилийн төсөв 2-ыг харьцуулж мэдэж, мэдээсэй гэж хүсээд ингээд давхар асуугаад байна шүү дээ, тийм ээ. Та бүх хариултдаа энэ яг энийг ойлгоод ийм байдлаар хариулаасай гэж хүсээд байна.

Хэн Жавхлан сайд бас хариулъя.

Б.Жавхлан: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Одоо нээрээ болдог бол боловсролын салбараа дотоодын нийт бүтээгдэхүүний 10, 20 хувь ч хүргэсэн яах вэ, нийгмийн салбарын хувьд номер нэг явсаар ирсэн, цаашдаа ч байх болно. Энд ямар ч эргэлзээ байхгүй.

Хувь хэмжээ ярих юм бол харин хэдүүлээ дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулж биш, төсөв дотроо эзлэх хувь хэмжээг нь ярих нь илүү оновчтой. Цаашдаа бид дотоодын нийт бүтээгдэхүүн төсөв 2-ын хэрвээ шүү, 3-ны 1 байгааг 4-ний 1 буюу 30-аас доош, 25-аас доош оруулъя гэж ийм зорилт тавьчихсан явж байгаа. Тийм үед дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулж ярих юм бол энэ хэмжээ чинь улам л багасаад байна. Тийм учраас бид төсөв дотроо эзлэх хэмжээгээ ярих нь илүү оновчтой. Нийт төсөв дотроо энэ чинь 11 хувь, 35 их наядын 4,4 их наяд гэдэг чинь 10 хувиас илүү гараад явж байгаа байхгүй юу. Урсгал зардал дотроо 26 их наядын 4,4 гэдэг чинь ... /минутдуусав/

Ч.Ундрам: Нэмээд 1 минут өгье.

Б.Жавхлан: Тэгэхдээ цаашдаа манай Наранбаяр сайдын яриад байгаа барьж байгаа чиглэл бол төсвийн тоондоо чухал биш, төсвийн үр ашиг, болсон салбарт зарцуулагдаж байгаа ирээдүйдээ зарцуулж байгаа 1 төгрөг болгоны энэ хөрөнгө оруулалт маань, хөрөнгө оруулалт ч бай, урсгал зардал ч бай, илүү их үр дүн гаргах тийм ээ, илүү их масс сургалт, илүү их боловсролтой ирээдүгээ бэлтгэх энэ чанарын асуудалд нь илүү анхааръя гэж байгаа энэ асуудал би номер нэг л гэж ингэж харж байгаа юм. Тийм.

Ч.Ундрам: Хуримтлалын нэгдсэн санд хуримтлагдах мөнгийг энэ уул уурхайн салбараас эргээд боловсролын салбар луу нь шууд нөгөө жишээлбэл хүүхдийн мөнгө ч гэдэг юм уу, хувь хүнд нь биш шууд, салбар луу ингээд оруулчих боломж байна уу гэсэн ийм асуулт байгаа. 4 номер хариулъя.

Б.Жавхлан: Тийм, Хуримтлалын сан дээр бид нар маш тодорхой заачихсан байгаа шүү дээ. Боловсрол, эрүүл мэнд дээр зарцуулъя гээд тийм ээ. Харин Хуримтлалын сангаасаа хэрхэн яаж зохицуулалт хийж, яг юу руу чиглэсэн эдийн засгийн ангиллаараа хөрөнгө оруулалт нь явах вэ гэдгээ салбар л их нарийн тооцож гаргаж ирэх хэрэгтэй. Тоо бол бэлэн байна. Ирэх жил маш сайн нэмэгдэнэ. Энэ жил ч 24 оны үлдэгдлээрээ ч чамгүй нэмэгдэнэ. Тийм.

Ч.Ундрам: Тэгэхээр Батнайрамдал гишүүн хуримтлалын сангаас боловсролын салбарт зарцуулагдах тэр мөнгийг яавал яаж зарцуулбал зүгээр юм бэ гэдэг саналыг бид нар солилцож болох нь байна шүү дээ, засагтайгаа тийм ээ. Нэмэлт 1 минут.

О.Батнайрамдал: Баярлалаа. Яах вэ, бид нар нөгөө Баялгийн сангийн хууль батлахдаа түүн дээрээ хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж боловсрол руу ингээд хөрөнгө оруулалт хийнэ ээ гээд хуультай байхгүй юу. Тэгэхээр энэ хуулиа л хэрэгжүүлэх л нэг ажил юм л даа. Тэгэхээр өнөөдөр бид нар 4,4 их наядын төсвийг боловсролын салбар дээр хийсэн. Гэхдээ анзаараарай. 88,6 хувь нь урсгал зардал шүү дээ. Тэгэхээр чанарын хөрөнгө оруулалт хийгдэхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр чанарын хөрөнгө оруулалт бид нар хийхгүй бол боловсролын

салбар чинь бид нар байшин барьсаар байгаад л дуусах гээд байна л даа. Тийм болохоор хуримтлалын нэгдсэн сан бол гол ерөөсөө концепц чинь баялгаас уул уурхайгаас орж ирж байгаа баялгийг бид нар боловсролын чанар луу хөрөнгө оруулалт хийдэг тэр сувгийг л нээж өгч байгаа гэж байгаа юм л даа.

Тэгэхээр 25 оны төсөв дээр ч гэсэн хуримтлалын нэгдсэн сан энэ дээр бид нар нэлээн мөнгө төвлөрүүлэхээр болж байгаа. Тэгэхээр энийг л бид нар боловсрол руу ордог энэ зохицуулалтыг л бид нар хурдан цаг алдалгүй хиймээр байгаа юм. Энэ бол яг үнэнийг хэлэхэд олон хэдэн сая сурагчдын аав, ээж нарын хүлээж байгаа яг нэг зүйл яг энэ байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр Сангийн сайд хамтарч ажиллая. Энэ дээр энийг бид нар заавал гаргах ёстой шүү л.

Ч.Ундрам: Ер нь бол бид нар яг ийм чанарын хөрөнгө оруулалт нэлээн хиймээр байгаа шүү дээ. Бүх сургуулиуддаа лаборатори байгуулахаас авхуулаад л манай цэцэрлэгүүд чинь олигтой тоглоом ч байхгүй ийм газрууд зөндөө байна. Тэгээд мэдээж багш нарын цалин, урамшуулалтай холбоотой манай Мөнхтуяа гишүүн, Эрдэнэбат гишүүдийг байнга ярьдаг тийм ээ гэх мэтчилэн ийм тал руугаа хэдүүлээ бас Байнгын хороон дээрээ нэг өдөр ингээд хэлэлцүүлэг хийгээд сайд нарыгаа урьж авчирч байгаад ингээд ярилцъя, тийм ээ.

Сангийн сайд нэмж хариульъя гэсэн үү. Болсон уу.

Хосбаяр гишүүн асуулт.

Г.Хосбаяр: Ирэх 4 жил Засгийн газар маань томоохон бүтээн байгуулалтууд, хөрөнгө оруулалтууд хийнэ гээд. Тийм ч учраас энэ өргөн баригдсан төсвийг тухайн үедээ дэмжиж байсан. Тэгээд өмнө нь бид нарын баталсан төсвөөр чинь 4,2 их наядын санхүүжих дүнтэй хөрөнгө оруулалтыг 2025 онд хийнэ гэж байсан бол одоо нэг 3,1 их наяд болоод буураад ороод ирж байна л даа. Тэгээд манай энэ Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд 670 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэх юм шиг байна. Тэгээд энэ бол чамлалттай л байна л даа. Тэгээд хөрөнгө оруулалтаа хасаад гайгүй хэдэн зам, Налайхын зам, Сүхбаатар, Сэлэнгэ чиглэлийн зам энэ тэрийг ингээд хасаад хаячих юм. Тэгээд энэ дээр үнэхээр харамсалтай санагдаж байна.

Хөдөө орон нутагт бол сургууль, цэцэрлэг, энэ боловсролын салбар, соёлын салбарын хөрөнгө оруулалт маш чухал байгаа. Маш их хүсэлтүүд ирж байна. Тэр хөдөө чинь нураад унах гэж байгаа сургууль, цэцэрлэг, халахаа байчихсан барилга байшин дотуур байр маш их байна. Тэгээд энэ их хөрөнгө оруулалт юмнууд энэ нийгмийн зөөлөн дэд бүтцээ хөгжүүлэх тал дээр бид нар онцгой анхаарч явах л шаардлага байгаа юм л даа. Тэгээд энэ жил яах вэ, нөгөө мега төсөл хэрэгжүүлнэ, бас төсөв санхүү маань ээдрээтэй байгаа учраас чимээгүй л өнгөрч байгаа. Ирэх жилүүдэд энэ салбарын хөрөнгө оруулалт дээр онцгой анхаарах байх гэж бодож байна.

Тэгээд Боловсролын сайдаас нэг асуулт байгаа юм. 2023 онд Энх-Амгалан сайдын үед төр, хувийн хэвшлийн түншлэлээр 23 оны 8 сард байх аа. Ямар ч байсан нэг сургууль цэцэрлэгтээ сугалаагүй ордог боллоо. Мөн сургууль 3 ээлжээр хичээллэхгүй боллоо гээд ингээд үр дүн гарсан тухай хэвлэл мэдээллээр нэлээн яваад байсан. Тэгэхээр энэ дээр ер нь яг ямар ахиц дэвшил гарсан юм бэ. Ер нь цаашдаа энэ төр, хувийн хэвшилтэй түншлээд энэ сургууль, цэцэрлэгийн хангамж,

хүртээмжийг сайжруулах тал дээр ямар бодлого баримталж байгаа юм бэ гэдэг ийм асуулт байна.

Сангийн сайдаас болохтойгоо зэрэг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн байгаа. Тэгэхтэйгээ зэрэг энэ нийгмийн зөөлөн дэд бүтэц буюу энэ шинжлэх ухаан, соёл спорт, боловсролын салбарт энэ төр, хувийн хэвшлийн түншлэл дээр ямар бодлого баримталж ажиллах юм бэ? Хувийн хэвшилд нэлээн нөөц боломж байх шиг байна. Сургууль, цэцэрлэг бариад улсад ашиглуулах ч юм уу, магадгүй барьж хүлээлгэж өгөөд, дараа нь өртөг зардлаа тооцох гээд ингээд олон ийм боломжууд байгаа. Тэгэхээр энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудлыг яаж авч үзэх юм бэ? Ер нь бид цаашдаа энэ бүтээн байгуулалтаа хурдан хугацаанд, мөн цаг хожоод л хийж байхгүй жил ирэх тусам л энэ бүтээн байгуулалтын зардал өсөж байгаа. Тэгэхтэйгээ зэрэг аль болохоор л энэ бүтээн байгуулалтын салбараа дэмжиж, юмнуудаа цаг алдалгүй эртхэн хийж байвал ... /минут дуусав/

Ч.Ундрам: Наранбаяр сайд эхлээд хариулъя.

П.Наранбаяр: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. 2024 онд түрээсийн цэцэрлэгт 26 тэрбум, сургуульд 16 тэрбум төгрөг төлөвлөгдсөн байгаа. Тэгээд энийгээ хэрэгжүүлсэн. Нийтдээ одоогоор 99 цэцэрлэгийн байр, 31 сургуулийн байрыг түрээслээд энд нь цэцэрлэгт 13 мянган хүүхэд, сургуульд 117 мянган хүүхдийг хичээллүүлж байна. 3 ээлжийн сургууль нийслэлд өнөөдөр 2 болчхоод байгаа. Хичээлийн шинэ жил эхлэх гэж байхад 10 байсан. Одоо ингээд оны эцэс гэхэд бүрэн шийдвэрлэхээр ажиллаж байна.

Юуны хувьд бид ер нь нийт хөрөнгө оруулалт 189 төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт 1,3 их наяд төгрөгийг санхүүжих дүнтэй. Ингээд тийм, төсөвт өртөгтэй. Тэгээд эндээс 472 тэрбум 667 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг бид нар энэ жилд өргөн барьчхаад байгаа юм. Энэ нь болохоороо 25 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар энэ жил 58 цэцэрлэг, 85 сургууль, 20 дотуур байр баригдахаар ингээд орчхоод байж байгаа. Цааш ер нь энэ гишүүдэд яахад, ер нь сургууль, цэцэрлэгийн хүртээмж хаана хаанаа хэцүү байгаа. Тэгэхээр бид их өгөгдөлд суурилсан ийм газрын зураг дээр яг энэ хүүхдийнхээ нягтшил, юман дээр байрлал дээр нь яг чухам хэдий хэмжээний сургууль, цэцэрлэг хэрэгтэй гэсэн ийм газрын зураг, мапинг хийчихсэн байгаа. Энийгээ та бүхэнд танилцуулаад энэ хүрээндээ хөрөнгө оруулалтаа хийгээд явна гэсэн ийм байр суурьтай байгаа.

Түүний зэрэгцээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бол энэ 1 хувийн татварын хөнгөлөлт бол хувийн хэвшлийнхэнд маш их юу болж байгаа, ийшээгээ орж ирэх ийм дэм болж байгаа, сонирхлыг төрүүлж байгаа. Тухайлах юм бол СУ гэхэд нийслэлийн бүх сургуулиудын жорлонг өөрсдийнхөө 1 хувийнхаа татварын хүрээнд хийгээд, тэгээд татварынхаа хөнгөлөлтийг эдэлье ээ, шинэчилье ээ гэсэн ийм санаачилга гаргаж байх жишээтэй.

Тэгэхээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийх ажил их байна. Санхүүгийн түрээс систем схемийг ч гэсэн оруулж ирэх боломжтой. Ингээд ирэх юм бол хүртээмжээ зөвхөн төсвийн хүрээнд биш төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх ийм боломжууд гараад байгаа юм. Сая Засгийн газраар бид нэг тогтоол гаргуулсан. 3 ээлжийн сургуулийг шийдвэрлэх. Энэ тогтоолын дотор энэ санхүүгийн түрээсийн системийн талаар дурдаж оруулж

ирсэн байгаа. Тэгэхээр иймэрхүү хэн хэндээ ашигтай хэлбэрээр түншлэх боломж байна. Баярлалаа.

Ч.Ундрэм: Сангийн сайд нэмж хариулах уу? 4 номер.

Б.Жавхлан: Тийм. Хосбаяр гишүүний асуултад нэмж хариулъя. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль бол сая яг Наранбаяр сайдын хэлсэн ийм онцлогтой байгаа. Өмнөх концессын хууль зөвхөн эдийн засаг дэд, бүтцийн салбар дээр хэрэгжихээр ийм хууль байсан бол энэ хууль маань эдийн засгийн ч тэр, дэд бүтцийн ч тэр, нийгмийн суурь салбарууд дээр ч гэсэн төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөрөнгө оруулалт хийх боломжуудыг тавьж өгсөн байгаа. Гэхдээ яах вэ, одоо төр, хувийн хэвшлийн түншлэл маань шүүмжлэлд өртөөд байгаа өнцөг нь хэт их нөгөө эрсдэлээ хаах, эрсдэлгүй цаашаа явах гэдэг энэ чиглэлээ нэлээн түлхүү барьчихсан юм болов уу даа гэсэн ийм Засгийн газар дээр бид яриад байгаа, хэрэгжиж эхлээд 2 жил болж байна л даа. Тэгээд амжилттай ерөөсөө 1 ч төсөл явж өгөхгүй байгаад байгаа.

Тийм учраас одоо нэгэнт ингээд хэдүүлээ төсөв дээрээсээ томоохон хөрөнгө оруулалтуудаа ингээд хийх цаашдаа ер нь боломж нэлээн хязгаарлагдмал. Өөрөөр хэлбэл дараагийн өөр эх үүсвэрүүдийн боломж ялангуяа төр ... /минут дуусав/

Ч.Ундрэм: Нэмээд 1 минут.

Б.Жавхлан: Төр, хувийн хэвшлийн түншлэлээ илүү их боломжийг нь гаргаж өгөх, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтуудыг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтуудыг дэмжих, газрын баялгаа эргэлтэд оруулж, энийгээ бүтээн байгуулалт руу чиглүүлэх гэсэн ийм чиглэл рүү нь Хөрөнгө оруулалтын тухай хууль, одоо бид нарын тулчхаад байгаа энэ Арана, энэ Чайна Энержиг тулчихсан байгаа, нэмэлт орлого олж болох ийм төслүүдээ урагшлуулах энэ хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг бид дахиж эргэж харна. Илүү жоохон либералчлаад, жоохон илүү тавьж өгөх ямар боломжууд байна харъя гэж бодож байгаа.

Дээрээс нь манай энэ Байнгын хороо дээр нэг чухал сэдэв бас сая Наранбаяр сайд хөндлөө. Тэр 1 хувийн татварын бодлогын асуудал энэ хөнгөлөлт, чөлөөлөлт. Энэ бол ерөөсөө яг цэвэр яг энэ Байнгын хорооны салбар луу л чиглэж байгаа зүйлүүд байгаа. Одоо яг яамд, яамнууд, сайд сайд нар өөр өөрсдийнхөө энэ загваруудаа гаргаж ирнэ. Одоо зүгээр нэг байшингийн буланд нэг ширээний теннис тавьчихаад спортын салбарын хөрөнгө оруулалт хийчихлээ, энийг чөлөөлүүлнэ ээ гэдэг тийм байж болохгүй ... /минут дуусав/

Ч.Ундрэм: Яг наадхаа тайлбарлаад өг. Сангийн сайд нэмээд 1 минут.

Б.Жавхлан: Тийм, энэ 100, 200 хүний дор хаяж ийм үзэгчтэй ийм павильон, ийм спортын ордон гэдэг ч юм уу ийм босгоо тавина. Соёлын салбар дээр жишээ нь ямар хөрөнгө оруулалт хийгдэх юм, тэрийгээ босгоод тавина. Байгаль орчны салбар дээр гэхэд ногоон байгууламж гэхэд гаднаа нэг 3 мод тарих уу, эсвэл энэ цэцэрлэгт хүрээлэнгийн паркийн өмнөх шиг сайхан тийм ногоон байгууламж барих уу гээд гэх мэт энэ салбар салбарын нийгмийн чиглэлийн хөрөнгө оруулалтын босгуудаа гаргаж байгаа. Манай дээр цуглаад маргааш Засгийн газрын хуралдаан

байх байсан, төсөвтэй холбоотойгоор хойшилчихлоо. Уг нь маргааш энэ журам ороод батлагдчихаар олон нийтэд танилцуулахад бэлэн болж байгаа.

Тэгэхээр энэ дээр одоо манай компаниуд чинь их том болж байна, том болж байна. 1 хувь гэдэг бол гологдохооргүй болчхоод байгаа шүү. Энэ чинь ашгийн 1 хувь биш орлогын 1 хувь байхгүй юу. Тэгэхэд уул уурхайн манай үндэсний том компаниуд 1 их наядаар эд нар тоологдох ийм том жилийн орлогууд нь болж ирж байна. Тийм учраас энэ 1 хувь гэдэг бол бас гологдохоор дүн биш, энэ бол маш том ... /минут дуусав/

Ч.Ундрам: Сангийн сайд аа, энэ Боловсролын яам дээр яг энэ 1 хувьтай холбоотой журам батлагдчихсан, өчигдөр. Тэгээд би энийг нь аваад хараад сууж байна. Энэ хүчин төгөлдөр үү, үгүй юү гээд 1 дүгээр асуудалд. 2 дугаарт, одоо жишээ нь энэ уул уурхайн компаниуд чинь АМНАТ нь ороод аягүй их татвар төлөгдөөд байгаа байхгүй юу. АМНАТ. Тэгэхээр ААНОАТ-ын 1 хувь гэдэг нь зөв биз дээ тийм ээ. Сангийн сайд хариулъя.

Б.Жавхлан: Тийм, яах вэ, олон нийт ААН-үүдээс нэг ийм хүсэлт ирээд байгаа юм. Ингээд салбар салбар чинь ингээд өөр өөрсдийн босго тавиад ингэчихээр нь ингээд бүх яамнууд чинь нэг татварын байцаагч шиг болчхоод байна. Тийм учраас энэ босго энэ яг загваруудаа нэгдсэн байдлаар гаргаад Засгийн газар дээрээс танилцуулж өгөөч ээ гэдэг ийм хүсэлт ирсэн юм. Тэгэхээр ганц Боловсролын яам ч биш хэд хэдэн яамд энэ загварууд гарч байгаа. Тэгэхдээ наадах чинь журам биш, нийтлэг зарчим байх тийм ээ. Шаардлага тийм. Тэгэхээр нэгдсэн зарчим буюу нөгөө татварын орчин руугаа хөрвүүлж, татварын хэллэгээр нийтлэг журам гарч ирнэ. Тэгэхээр илүү их ойлгомжтой болно гэсэн үг.

Ч.Ундрам: Тэгэхээр танай журмыг хүлээх нь байна шүү дээ. Яагаад гэвэл яг одоо жишээлбэл том том компаниуд энэ жилийнхээ ААНОАТ-ын 1 хувийг бушуухан шиг энэ соёл, спорт, боловсролын салбарт руу зарцуулчихмаар байна гэсэн хүсэлтүүд ирээд байгаа байхгүй юу. Та энэ дээр яг хариултад өгнө үү?

Б.Жавхлан: Тийм, тийм. Тэгэхээр одоо ингээд 1 сарын 1-нээс журам маш тодорхой болоод, мөрдөгдөөд эхэлнэ. Тэгэхээр ялангуяа ер нь манайд хүлээлт энэ юун дээр соёл дээр нэлээн хөрөнгө оруулалт явахаар шинжтэй байна. Спорт руу нэлээн хөрөнгө оруулалт орох шинжтэй байна. Ногоон байгууламж, байгаль орчны салбар дээр нэлээн хөрөнгө оруулалт оруулах шинжтэй хүлээлтүүд байна.

Дээрээс нь нийслэлийн түгжрэлтэй холбоотой, гол өөрөөр хэлбэл хийгдсэн бүтээн байгуулалт хөрөнгө оруулалт нь өөрөө нийтийн зориулалттай байх ёстой гол нь. Тухайн ААН, компанийн албан хаагч нарт зориулалттай биш, нийтийн зориулалттай байх ёстой гэдэг л ийм үндсэн шаардлага. Өөрөөр хэлбэл, заавал нөгөө татвараар дамжиж ороод буцаад энд нэг бөөн юм болоод л, тэнд энд гэж мапинг хийхгүйгээр салбарууд өөр өөрсдийнхөө чиглэл, өөр өөрсдийнхөө дуртай дэмжье гэсэн салбарууд руугаа бараг хоббигоо дагаж л гэсэн үг шүү дээ, тийм ээ, ийм хөрөнгө оруулалтууд хийгээд бодитойгоор төсөв дээрээс ачааллыг хуваалцаж байгаа ийм л хөрөнгө оруулалтыг дэмжинэ ээ гэсэн үг. Тийм.

Ч.Ундрам: Яг энэ ААНОАТ-ын 1 хувь бол би бүр Их Хурлын гишүүдээ хүртэл уриалмаар байгаа байхгүй юу. Компаниудтай яриад, ийм нийтийн төлөө ажлууд

руу хөрөнгө оруулахад нь тийм ээ, уриалаад өөрсдөө ч гэсэн бараг компанитай хүмүүс байвал ийшээ орвол их зүгээр байгаа юм.

Сангийн сайд гүйцээгээд хариулчих.

Б.Жавхлан: Ундрам дарга аа, юу шүү. ААНОАТ-ын 1 хувь биш, татвар ноогдуулах зардлыг нь саяын энэ хэлж байгаа энэ хөнгөлөгдөх салбар чиглэлээр нь хөнгөлнө. Хязгаар нь тухайн ААН-ийн жилийн орлогын 1 хувиар хязгаарлагдана гэж байгаа юм. Тийм.

Ч.Ундрам: Бүр их биш тийм ээ. Ойлголоо.Бас тийм хязгаар байгаа юм байна.

Наранбаяр сайд нэмээд.

П.Наранбаяр: Энд энэ 24 оны 12 сарын 04-ний өдөр Боловсролын сайдын тушаалаар ААНОАТ-ын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.11 дэх заалтад үндэслээд ийм нийтлэг шаардлагыг нь гаргачихсан. Тэгээд энийгээ Сангийн яам руу хүргүүлчихсэн байгаа. Засгаар журам нь гараад бүрэн энэ шаардлага өөрөө хэрэгжээд явна. Энэ юун дээр бид энэ сургалтын байгууллагын орчныг дэмжих хөрөнгө оруулалт, хүний хөгжил сургалтыг дэмжих үйл ажиллагаа, мөн их, дээд сургуульд суралцагчдын тэтгэлгүүд, мөн эрдэм шинжилгээ, судалгаанд зориулсан, инновацад зориулсан, тэгээд ийм төрийн болон орон нутгийн өмчит боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд өгсөн хөрөнгө оруулалт эд нар гээд ийм зүйлүүд ангилагдаад ингээд явчихсан байгаа. ААН-үүд бол хурд шаардаад байгаа юм. Одоо энэ он чинь дуусах гээд байна. Татварынхаа энэ тайланг гаргахаас өмнө 1хувиа ингээд хэрэгжүүлчихье ээ гээд байгаа юм. Тэгэхээр зэрэг засаг бол ингээд ... /минут дуусав/

Ч.Ундрам: Хосбаяр гишүүн тодруулъя.

Г.Хосбаяр: Яг л би энэ 2 сайдын яриад байгаа асуудлыг л яриад байгаа юм л даа. Төр, хувийн хэвшлийн түншлэл бас хувийн хэвшилд чинь боломж байна. Тэгэхээр энийг ашиглаад энэ журмаа хурдан гаргаад, манай Байнгын хорооны гишүүд санаачилгатай, манлайлалтай ажиллаад энэ хувийн хэвшлийн боломжоо ашигламаар байна л гэж хэлээд байгаа. Ер нь хувийн хэвшилд маш их боломж байгаа. Тэр төр, хувийн хэвшлийн түншлэл ч гэсэн сая Сангийн сайд хэлж байна. Хэрэгжээд, хууль нь хэрэгжээд 2 жил болж байхад амжилттай явсан төсөл байхгүй гээд. Тэгэхээр бид нар ч гэсэн энэ дээрээ эргэж хараад бас сайжруулах тэр хэт нэг талд төрд давуу тал үүсгэчихсэн, төр эрсдэлээс өөрсдийгөө хамгаалчихсан, бүх эрсдэлээ хувийн хэвшилд тохчихсон энэ асуудлаа эргэж нэг хараад, хаана хаана харилцан ашигтай байвал энэ Монгол Улсад чинь бас нэг хувийн хэвшилд ч тэр, төрд ч тэр эд эдийн засгийн боломж нөөц байна. Энэ дотоодынхоо нөөц боломжийг бүрэн дүүрэн ашиглая. Тэгээд энэ салбарт тэр дундаа илүү их орж ирэх боломжтой учраас ашиглая гэдэг. Тэгээд байнгын хорооны гишүүддээ санаачилга ... /минут дуусав/

Ч.Ундрам: Хосбаяр гишүүн маш чухал асуудал хөндлөө шүү дээ. Энэ төр, хувийн хэвшлийн түншлэл. Уул нь өмнөх парламентад анхдагч хууль энэ Сангийн яамнаас өргөн бариад батлагдсан. Одоо энийг сайжруулах асуудал дээр Хосбаяр гишүүн та өөрөө бизнес эрхлэгч, баялаг бүтээгч хүний хувьд Сангийн сайдтай

санал бодлоо хуваалцаад, тийм үү. Эдийн засаг хөгжлийн яамныхаа сайдтай уулзаад, санал солилцоод хуулийг та өргөн барих боломжтой шүү. Сайжруулах төсөл. Тийм ээ.

Асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо зарчмын зөрөөтэй саналаар бид нар санал хураалт явуулж эхэлнэ. 3 санал ирсэн үү? Санал дэгээр байхгүй шүү дээ. Зарчмын зөрөөтэй санал гаргасан гишүүн саналаа хэлнэ. Үүний дараа бид нар дагалдах тогтоолын төслийг хэлэлцэх үеэр та бүхэн маань дэгийнхээ дагуу асуулт асуугаад явж болно. Харин тийм шүү. Рэгдэл гишүүн ээ.

3 санал уу, тийм ээ. Одоогоор 4 санал ирсэн байна. Яг санал ирсэн цаг санал, ирсэн хугацаа, цаг минутын дарааллаар нь хураалгах ёстой юм байна. Эхний саналыг Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг гаргасан байна.

Энэ санал дээр Улаанбаатар хотын төвлөрлийг задлах зорилгоор Улаанбаатар хотод байрлаж байгаа хувийн сургуулиудын хувьсах зардлыг бууруулж гэсэн байна. 38,5 тэрбумаар бууруулаад, зардал нэмэгдүүлэх хэсэгт нь хөдөө орон нутгийн дотуур байрны хангамжийг сайжруулах, нийслэл дэх сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх. Энэ нь яг адилхан дүн 38,5 тэрбумаар гэсэн ийм санал ирсэн байна.

Сайнзориг гишүүн байна уу. Энэ тэгэхдээ гол нь хуультай л зүйл л дээ. Тэгэхээр энэ дээр тайлбар Боловсролын яамнаас авах ёстой юм байна. Наранбаяр сайд тайлбар хэл дээ.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ Боловсролын ерөнхий хууль болоод Үндсэн хуулийн зарчмууд байгаад байгаа юм. Ер нь түрүүн би хэлсэн 1,8 сая төгрөгөөр нэг хүүхдийг сургаж байгаа. Хувьсах зардал хэлбэрээр ингээд төрийн өмч, хувийн өмч, өмчийн хэлбэр үл харгалзаж өгөөд энэ сургалтыг явуулаад байгаа юм. Нийтдээ 165 байгууллага буюу 165 хувийн хэвшлийн сургуульд 78957 хүүхэд сурч байгаа. Энэ дээр энэ жил 38 тэрбум төгрөг ингээд төсөвлөгдсөн. 10 саяас дээш төлбөртэй 24 сургууль байгаа юм. Тэнд хувьсах зардал огт очихгүй байгаа, нойлилчихсон, бүр өгөхгүй. 5-10 сая төгрөгийн хооронд нэг 83 сургууль байна. Энэ төрийн ачааллаас үүрэлцэж байгаа, хуулийн заалттай, өмчийн хэлбэр үл харгалзан олгоно гээд заачихсан ийм заалттай ийм зүйл.

Тэгээд дээр нь нэмээд энэ бол хувийн өмчийн хөрөнгө оруулалтыг боловсрол руу татаж байгаа их чухал ийм үзүүлэлт юу байдаг. Тэгээд бид 1-5 сая төгрөгийн хооронд эхлээд л хувьсах зардлыг нь бууруулаад олгоод явчхаж байгаа юм. Тэгэхээр ийм байгаад байгаа. Тэгэхээр нийслэлийн хүрээнд гэхэд чинь 68909 хүүхэд 92 сургуульд сурч байгаа байхгүй юу. Тэгэхээр хэрвээ энэ хувьсах зардалгүй болгоод, зарим сургуулиуд нь ингээд үүд хаалгаа бариад ингээд эхлэх юм бол ийм олон хүүхдийг сургахад нийтдээ 1,3 их наяд төгрөгийн дахиад шинэ ийм хөрөнгө оруулалт хэрэгтэй, сургууль савтай болгохын тулд. Тэгэхээр энэ саналыг Боловсролын яам дэмжихгүй ээ, дэмжихгүй.

Ч.Ундрам: Энэ дээр санал хураалт явна. Тэгэхээр Сайнзориг гишүүний саналыг дэмжих нь дэмжинэ гэж саналаа өгөх нь байна шүү дээ. Дэмжихгүй нь дэмжихгүй ээ. Яамны Наранбаяр сайдтай нэг байна гэсэн үг байх нь байна.

Санал хураалтыг эхэлье.

Хэдэн хувь болчхов, сая. 1 хүн. 1 хүн дэмжээд бусад гишүүд дэмжээгүй учраас саяын санал уналаа.

Дараагийн санал нь Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас ирсэн байна.

Энэ Боловсролын сайдын төсвийн багцын төсвийн нийт зардал хэсэг дэх бараа үйлчилгээний бусад зардал. Энэ код нь 210901-ийг бууруулж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал буюу 210801 код руу шилжүүлэх замаар боловсролын салбарын багш ажилтны 8-10 хувьд нь ажлын байрны эрсдэлд суурилсан хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх гэсэн санал ирсэн байна. Энэ дүн нь 4 тэрбум юм байна тийм ээ? Тийм.

Энэ саналаа Мөнхтуяа гишүүн тайлбарлана.

Ц.Мөнхтуяа: Боловсрол, шинжлэх ухааны салбарт 24 оны 6 сарын байдлаар төрийн албаны цалингийн сүлжээгээр 94332 ажилтан албан хаагч ажиллаж байна гэсэн статистик мэдээлэл байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйлд иргэд хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5-д ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэх үүргийг ажил олгогчийн үүрэгт оноосон ч боловсролын салбарын ажилтан, албан хаагчдын ажлын байрны эрсдэлд суурилсан хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ нэгдсэн журмаар хийсэн судалгаа, тайлан алга байгаа нь туйлын харамсалтай байна. Хэдийгээр ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх үүргийг ажил олгогчид оноосон ч төрийн өмчийн цэцэрлэг, сургууль, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын төсөвт энэ зардлыг хангалттай суулгаж өгдөггүй нь салбарын хэмжээнд улсын төсвийн зардлаар нэгдсэн журмаар хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг зайлшгүй хийх ийм шаардлага үүсэж байгаа юм. Энэ нь СӨБ, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, насан туршийн боловсролын сургалтын байгууллагуудад ажиллаж байгаа багш, ажилтны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг орчин үеийн эрсдэлийн болон хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний арга, аргачлал, норм стандартаар хийгээгүй байгаа нь эдгээр ажилтны ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, цалин хөлс, нийгмийн баталгааг бодитоор хангах, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс болон эрүүл мэндийг хамгаалах ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд үндсэн саад тотгор болж байна.

Боловсролын яамнаас гаргасан тоон мэдээллээр 24-25 оны хичээлийн жилийн эхэнд ЕБС-д 4200 багшийн дутагдалтай байгаа нь багшийн цалин, хөлс, нийгмийн баталгаа муу, сул байгаагаас гадна ажлын байрны орчин нөхцөл тааруу, хөдөлмөрлөх таатай орчин бүрэлдээгүй байгаатай холбоотой гэсэн ийм үндэслэлийг гаргаж байна. Тэгээд саналын томьёолол нь сая Ундрам гишүүн уншчихсан. 4 тэрбум төгрөгийг бус бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ рүү шилжүүлээд, ингээд энэ 4 тэрбум төгрөгөөр боловсролын салбарын багш, ажилчдын хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг 8-10 хувьд нь хийх ийм боломж байгаа юм. Өнөөдөр яг энэ хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийсэн нарийн судалгаа байхгүй байгаа.

Тийм учраас энийг хийх, яаралтай нэн тэргүүний ийм шаардлага байгаа, энийг улсын төсвөөс нэмж мөнгө гаргая гээгүй, тийм ээ, юунд нь шилжүүлж байгаа юм. Ийм саналыг та бүхэн маань дэмжиж өгнө үү.

Ч.Ундрам: Үгүй зөвхөн энэ саналтай л холбоотой тийм тайлбар. Наранбаяр сайд тайлбар өгье.

П.Наранбаяр: Энэ санал зарчмын хувьд энэ би үгүйсгэхгүй. Яагаад вэ гэвэл ажлын байран дахь энэ эрсдэлийн үнэлгээг хийх ёстой. Тоон дүн нь 8-10 хувьд гэхээр арай их байна. Статистикийн магадлалаараа 3 хувь дотор хийхэд л хангалттай байдаг. Өөр эх үүсвэрээс энийг хэрэгжүүлбэ, тэгэх үү? Олон улсын байгууллагуудын өөр эх үүсвэрээс. Тийм, өөр эх үүсвэрээс. Тэгэхгүй бол энэ бараа үйлчилгээ дотор чинь нөгөө гүйцэтгэл үр дүнгээр санхүүждэг мөнгө ч явж байгаа. Ингээд энэ цахимжуулах цахим шилжилтийн бодлого ч яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр 4 тэрбумыг хасах ямар ч гүйлгэх ямар ч боломжгүй орон зай алга байна. Тэгэхээр Мөнхтуяа гишүүнд би хандаад яахад өөр ОУБ-тай ярьж, өөр санхүүгийн эх үүсвэрийг шийдье ээ. Та энэ саналаа татаад авчихвал их зүгээр байна л гэж Танаас. Өөр эх үүсвэр оруулъя тэгэх үү? Тэгье. Тэгэхгүй бол, хийнэ ээ, хийнэ, хийнэ. Тэгэхдээ энэ бол нөгөө магадлалын онолоороо заавал 8-10 хувь биш, өшөө ч энийг бууруулах боломжтой. Тэгээд хийе, тэгээд эхлүүлбэ, тэгээд эхлүүлбэ. Тэгээд өөр эх үүсвэрээс та энэ саналаа татаж явна уу танд Баярлалаа.

Ч.Ундрам: Тэгэхээр Мөнхтуяа гишүүнд Боловсролын сайд Наранбаяр энийг бид нар өөр эх үүсвэрээр мөнгө олж хийнэ ээ гэдгээ хэллээ шүү дээ, хариуцлагатайгаар. Тэгэхээр Мөнхтуяа гишүүн энэ саналаа татаж авах уу? Тэгвэл микрофон дээр хэлнэ. Мөнхтуяа гишүүн.

Ц.Мөнхтуяа: Наранбаяр гишүүн өөр эх үүсвэрээс энэ хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийе ээ гэсэн тийм ээ. Ийм санал гаргаж байгаа учраас би өөрийнхөө энэ гаргасан зарчмын зөрөөтэй саналаа татаж байна.

Ч.Ундрам: Дараагийн зарчмын зөрөөтэй санал Үүрийнтуяа нарын 10 гишүүнээс ирсэн байна. Үүрийнтуяа, Болормаа, Сарнай, Ундраа, Нарантуяа-Нара, Эрдэнэбат, энэ Лодойсамбуу, Энхцэцэг, Мөнхсайхан, Батчимэг гээд ийм 10 гишүүнээс санал ирсэн байна. Энэ болохоор Үндэсний аудитын газрын дүгнэлтээр зураг төсөвгүй, төслийн шаардлага хангаагүй, 4 арга хэмжээний нийт 99,2 тэрбум төгрөг байна. Үүнээс түрүүн нөгөө Сангийн сайд 4 арга хэмжээгээ та бүхэнд нэг бүрээр нь тайлбарласан. 2 арга хэмжээ буюу төрийн албан хаагчдын орон сууцжуулах цогц хөтөлбөр 1 дүгээр үе шат бүсүүдэд гэсэн зардлын 30 тэрбумыг бууруулаад, мөн гадаргын ус хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах баруун бүс гэсний дүнгээс 1,4 тэрбумыг бууруулаад, ингээд нийт 31,4 тэрбум болж байгаа. Үүнийгээ юунд нэмэх вэ гэхээр цэцэрлэг, сургууль, дотуур байрны хүүхдийн хоолны материал худалдан авах зардал дээр нэмнэ ээ гэсэн ийм санал байгаа. Энэ 10 гишүүний. Тэгэхээр энэ саналтай холбоотой тайлбараа Үүрийнтуяа гишүүн хийнэ.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

1 дүгээрт, би эхлээд эх үүсвэр яагаад энэ 2 ажлаас татсан бэ гэдгээ тайлбарлая. Хамгийн гол суурь зарчим бол төсвийн хуулийн шаардлагыг

хангаагүй төсөл, арга хэмжээ гэж Үндэсний Аудитын газрын дүгнэлт гарчихсан байгаа, 4 ажил. Үүн дотроосоо тэр СОР-ийг олон улсын түвшинд хийгдэж байгаа гэрээ хэлцэлтэй холбоотой олон улсын арга хэмжээ гэдгээр нь үлдээгээд, төрийн албан хаагчийн тэр орон сууцжуулах хөтөлбөр гэж байгаа юм. Үнэхээр хөтөлбөр урт удаан хугацаанд хийх гэж байгаа хэрэгжүүлэх гэж байгаа бодлогын баримт бичиг юм бол ядаад зураг төсвөө гаргачхаад энийгээ оруулах хэрэгтэй. Зураг төсөв гараагүй байхад яаран дааран мөнгө тавих шаардлагагүй ээ гэж үзэж байгаа юм.

Тэгэхээр энэ 25 онд оруулахаасаа илүүтэй, 25 онд бэлтгэлээ хангаад, хөтөлбөрөө сайн боловсруулаад, хаана юу барихаа тохироод, зураг төсвөө хийчхээд, энэ ажлаа оруулж ир ээ гэдэг үндэслэлээр 30 тэрбумыг хасаж байгаа юм. Цаана нь 1,4 тэрбумын эх үүсвэр дутаж байгаа. Тэрийг энэ гадаргын усны хөв, цөөрөм байгуулах ажил бол хийгдэх нь зүйтэй. Гэхдээ мөн ялгаагүй зураг төсөв байхгүй. Одоо он гараад зураг төсөв нь хийгдээд, гүйцэтгэл нь санхүүжиж байтал энэ бүтэн дүнгээр санхүүжих боломжгүй он дамжих боломж үүснэ, шаардлага үүснэ. Тийм учраас үлдэгдэл 1,4 тэрбум төгрөгийг энэ ажлаас хасах саналаар оруулж ирж байгаа. Эх үүсвэрээ. Яагаад хэрэгцээ шаардлага байна вэ гэж. Өнөөдөр бид нар Монгол Улсын хэмжээнд 2000, надад сүүлийн судалгаа алга. Наранбаяр сайдаас хүсье. Сургууль, цэцэрлэг энэ СӨБ, ЕБС, дотуур байранд байгаа хүүхдийн тоог авчихмаар байгаа юм. 2022 онд хийсэн судалгаагаар 1 сая орчим хүүхэд энэ хоолны үйлчилгээнд хамрагдаж байгаа юм. Дотуур байран дээр ганцхан жишээ авахад хамгийн сүүлийн 2022 онд нэмсэн нь 1 хүүхдийн хоолны зардал 4300 төгрөг байгаа. 4300 төгрөг. Үүгээр өдрийн 3 хоол, 2 унд идэж байгаа юм. Энэ материалын зардал гэж байгаа юм.

Тэгээд энийг тухайн үед 2-3 дахин нэмэгдүүлэх шаардлага байна гэж 22 онд мэдээлэл хийж байсан. Түүнээс хойш огт өсөөгүй явж байгаа. Сая харин анхны юун дээр төсөв дээр батлагдаад хүчингүй болдог төсөв дээр 6600 төгрөгөөр яам, Сангийн яам төлөвлөж оруулж ирсэнд талархалтай хандаж байсан. Гэхдээ энэ өөрөө хангалттай дүн биш, 6600 гэдэг тоо чинь өөрөө хангалттай дүн биш байхгүй юу. Ядаад 6600-г оруулчих хэрэгтэй байгаа юм. Гэтэл энэ 6600-аар төлөвлөсөн дүнгээсээ нөгөө 10 хувь бууруулах автоматаар механикаар хассан зардал дотроо энэ хүүхдийн хоолны зардлыг оруулчхаж байгаа юм. Бид нар ядаж ирээдүй хойчоосоо хоол унднаас нь, хүнсний аюулгүй байдлаас нь хасмааргүй байна. Энэ чинь хүүхдийн хоолны шим тэжээл илчлэгийн асуудал. Амьдрал хүнд байгаа үед хүүхдүүд хаана хоол идэж байна. Сургууль дээрээ ирж, дулаан байранд халуун хоолтой байж байгаа айл өрх олон байна шүү, цаана чинь.

Тэгээд хүүхдийнхээ хоолонд өгч байгаа чанарын энэ материалын чанарын асуудалд онцгой анхаарах шаардлагатай байна. Тойрогт ажиллаж байхад ямар асуудлууд үүсдэг вэ гэхээр би асуулт дээр давхардчих тайлбар хэлэх гээд цаг алдчих болов уу гээд Байнгын хорооны хурлыг би ажиглаад хараад суугаад байгаа. Түрүүний асуултууд дээр сайд хариулж байна лээ. Наранбаяр сайд. Гүйцэтгэл 85-90 хувь л гардаг юм гэж байгаа юм. Гүйцэтгэл тэгж гарч байна гэдэг нь 4300 төгрөгөө нэмээд зарцуулах эрх өгч байгаа юм ерөөсөө байхгүй шүү дээ. Тарифыг нь Засгийн газрын тогтоолоор батлаад өгчихсөн. 100 хүүхдээр тухайлбал 1 дотуур байрыг 100 хүүхдээр төлөвлөөд энэ 100 хүүхдэд 100 сая төгрөг дунджаар зарцуулна гээд төлөвлөчихсөн байхад гүйцэтгэлээр 80 хүүхэд ирээд 80 сая төгрөг зарцуулах ёстой л гэж аудит шалгадаг. 80 хүүхэд ирэхэд 100 сая төгрөг

зарцуулчихсан байвал 20 сая төгрөг нь зөрчил гэж үздэг. Яагаад гэвэл 1 хүүхдэд ноогдох Засгийн газрын тогтоолоор баталсан нормативыг зөрчсөн байна гэж.

Тэгэхээр би энэ 6 ... /минут дуусав/

Ч.Ундрэм: Дэгээр нэмэхгүй. Ер нь тэгэхдээ манай гишүүд аягүй сайн ойлгосон байх гэж бодож байна. Тэгээд манай маш олон гишүүд энэ боловсролын салбарт санаа зовоод, ингээд мөнгө нэмж оруулж ирж байгаад баяртай байна. Тэгээд өнөөдөр хэрвээ дэмжигдэх юм бол Үүрийнтуяа гишүүн ээ, та энэ нөгөө 2 өөр Байнгын хороо, 1 нь Эдийн засгийн байнгын хороо, нөгөөдөх нь Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хороон дээрээ очиж та хэд энийгээ хамгаалах хэрэгтэй шүү.

Тэгээд, үгүй одоо ингээд санал хураалт. Үгүй, санал гаргасан гишүүн дэгээрээ. Одоо хэдүүлээ яг дэгээрээ л явна. Үүрийнтуяа нарын 10 гишүүний гаргасан саяын миний уншиж танилцуулсан саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт эхэлье.

12 гишүүнээс 9 гишүүн дэмжээд, 75 хувиар дэмжигдлээ.

Ингээд энэ нэг Хэрлэн гишүүний санал. Хэрлэн гишүүний зарчмын зөрөөтэй санал байна. 2025 оны нэгдсэн төсвийн төсөл хавсралт 16. Гадаад суралцагчдын зардал 19 тэрбум 595 сая 800 мянган төгрөг юм байна тийм ээ. Энийг хасаад, мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтыг дэмжих санд энэ саяын хассан 19,5 тэрбумынхаа 11 тэрбумыг ийшээ нэмэгдүүлнэ. Боловсролын зээлийн санд 8 тэрбум 595 сая 800 мянган төгрөгийг нэмэгдүүлнэ гэж ийм санал өгч байна. Нэг ёсондоо гадаад суралцагчдын зардал гэдгийг тэр чигээр нь хасаад, тэгээд 2 хувааж байна шүү дээ тийм ээ. Мэргэжлийн болон тэ техникийн боловсрол руу 11 тэрбумыг нь, үлдсэн 8,5 тэрбумыг нь Боловсролын зээлийн сан руу нэмье ээ гэсэн ийм санал байна.

Хэрлэн гишүүн саналаа тайлбарлая.

Б.Хэрлэн: Тэгэхээр энэ хэрвээ бид нар энэ 25 оны нэгдсэн төсвийн төслийн зориулалтаар гэсэн хавсралт 16-г харах юм бол энд гадаадад суралцагчдын зардал 19 тэрбум 596, 800 гээд, тэгсний дараад нь гадаадад суралцагчдын зээл 15 тэрбум 325 500, Засгийн газрын гэрээгээр гадаадад суралцагчдын тэтгэлэг 5 тэрбум 605 400, Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг 53 тэрбум 181 500, Монгол Улсын Засгийн газрын тэтгэлэг 18 тэрбум 735 гээд ингээд ийм зардлууд байгаа. Өөрөөр хэлэх юм бол гадаадад суралцагчдын зардал гэдгээ чухам энэ 19 тэрбумыг гадаадад суралцагчдын зардал гэдэг нь тэтгэлгээс гадна зээл, тусламжаас гадна гадаадад суралцагчдын зардал гээд 19 тэрбум төгрөг ингээд ороод ирчихсэн байгаад байгаа юм. 19 тэрбум 595800. Тэгэхээр яахаараа энэ гадаадад суралцагчдын зардал гэж энэ тэтгэлэг тусламж тийм ээ, энэ зээлээс гадна ийм тусдаа ийм зардал мөнгө орж ирээд байгаа юм бэ? Өнөөдөр ядуурал их байна, өнөөдөр ажилгүйдэл их байна. Тэгэхээр түрүүн Боловсролын зээлийн сангаас 17 тэрбумыг хасчихсан. МСҮТ-ийг дэмжих хөтөлбөрөөс 11 тэрбумыг хасчихсан.

Тэгэхээр чинь яг нийгэмд дөнгөж энэ дотооддоо боловсрол эзэмших гэж байгаа мэргэжил эзэмших гэж байгаа, МСҮТ-ээ дэмжих, тэнд сурч байгаа хүмүүсээ

дэмжих, дотоодод их, дээд сургуульд тэтгэлэг зээл аваад сурах гэж байгаа, дотоодод байгаа оюутнуудаа дэмжих зорилгоор тэр давхардсан гадаадад суралцагсдын зардал гэсэн 19 тэрбумыг хувиргаж энэ сайдын багц дотроо зориулалтыг нь өөрчилж, яг нийгмийн дунд тийм ээ, болон ер нь амьдрал хүнд байгаа хүмүүс рүү чиглүүлсэн энэ зардалд хуваарилъя гэсэн ийм утгаар энэ зарчмын зөрөөтэй саналыг оруулж өгч байгаа. Та бүхэн маань энэ дээр дэмжиж саналаа өгнө үү.

Ч.Ундрэм: 4 минут дууслаа. Хэрлэн гишүүний гаргасан зарчмын зөрөөтэй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт эхэлье.

Наранбаяр сайд тайлбар хийчих.

П.Наранбаяр: Энэ юу, шууд ингээд гадаадад энэ чинь ерөөсөө л зээлийн сан дотроо тэр гадаадад сурч байгаа хүүхдүүдийн амьдрах зардал, зээл байхгүй юу даа. Ер нь бакалаврт сурч байгаа хүүхдүүдийг бүгдийг нь зээлээр, зээлээр явуулж байгаа юм. Магистр, доктор бол буцалтгүй тэтгэлгийн хэлбэрээр ингээд явуулж байгаа. Одоо энийг ингээд шууд хасчих юм бол тэр хүүхдүүд юугаа идэж, амьдрах вэ? Юу юугаараа амьдрах вэ? Ийм болчихно. Энэ жил нөгөө Ерөнхийлөгчийн тэтгэлгийн чинь юу нь 4 дэх жилдээ яваад энэ жил хамгийн топ дээр ирж байгаа юм. Тэгээд ирэх жилээс буцаж ирнэ. Тэр хүүхдүүд. Ингээд ирэхээр яг энэ жил ингээд нэмэгдэж байгаа нь энэ жил Боловсролын зээлийн сан өөрөө ингээд бараг юу билээ, 30-аад тэрбумаар нэмэгдэж байгаа нь энэ нэмэгдэлтэй л холбоотой юм.

Мэргэжлийн боловсролыг дэмжих сангийн энэ өөрийнх нь ноднин жилтэй харьцуулахад өсчхөөд байгаа шүү дээ. Бас зээлийн сангийнх нь мөнгөн хэмжээ нь өсчхөөд байгаа. Өсөлтөөс нь л 11 тэрбум хасагдсан болохоос биш тэнд ямар нэгэн юу, өөрчлөгдөхгүй. Тэгэхээр зэрэг энэ дээр та яг ингээд нэг зээлийн сангаас нөгөө ... /минут дуусав/

Ч.Ундрэм: Нэмээд та тайлбараа 1 минутад дуусгачих.

П.Наранбаяр: Уучлаарай. Тэгээд ингээд явуулчих юм бол өнөөдөр тэнд гадаадад сурч байгаа хүүхдүүдийн чинь тэтгэлэг зогсоход хүрнэ. Энэ жоохон аюултай. Бид би танд түрүүн ч хэлсэн, амласан, мэргэжлийн боловсролыг дэмжих сангийн хэвийн үйл ажиллагааг хангаад явж чадна. Энэ дээр санаа зовох юм байхгүй. Баярлалаа.

Ч.Ундрэм: Хэрлэн гишүүн яах вэ, Хэрлэн гишүүний микрофон.

Б.Хэрлэн: Би зарчмын зөрөөтэй саналаа татаж авъя.

Ч.Ундрэм: Хэрлэн гишүүн саналаа татаж авсан учраас санал хураалт явуулж дууслаа.

Бүх зарчмын зөрөөтэй. Аль байна. Сангийн асуудлууд дагаж байгаа хуулиуд орно шүү дээ. Одоо хэлэлцээгүй байна. Эрдэнэбат гишүүний 2 санал хаана байна. Дагаж байгаа хууль юм уу.

Та хэд наадхаа сайн шалга. Одоо дахиад Эрдэнэбат гишүүний гаргасан 2 зарчмын зөрөөтэй санал байгаа юм байна.

Боловсролын салбарын гүйцэтгэлийн санхүүжилт 86 тэрбумыг хасах юм байна тийм ээ, хассаныг хэвээр үлдээнэ гэхээр чинь хаанаас өөр нэг газраас хасаж байж нэмнэ шүү дээ. Та өөрөө энийгээ тайлбарлачих тэгэх үү?

С.Эрдэнэбат: Энэ боловсролын салбарын гүйцэтгэлийн үнэлгээний санхүүжилт гээд энэ сүүлийн хэдэн жил хийсэн боловсролын салбарт нэг наашаа багш, ажилчдыг тогтоож барих чухал зардал юм. Тэгээд 85 тэрбум төгрөг гэдэг бол асар их мөнгө л дөө. Тэгээд энэ мөнгийг яг энэ дээрээ тулж хасаж байгаа бол энэ олон хүмүүсээс ирж байгаа санал шүү. Зарчмын хувьд. Түүн дээрээ ирж байгаа бол магадгүй маш олон улсын сургуулиудаас хувийн сургуулиуд руу шилжих байдал нэмэгдэнэ. Олон багш нар ажлаасаа гарах ийм нөхцөл байдал эрсдэл туулна. Тийм учраас би энэ зардлыг хасахгүй хэвээрээ үлдээгээч ээ, 1 дүгээрт би яг 85 тэрбум бүрэн хасагдаж байгаа юу? 1.

2 дугаарт, өндөр төлбөртэй хувийн сургуульд олгож байгаа хувьсах зардлаа яг хасах эсвэл зураг төсөвгүй хөрөнгө оруулалтаас хасах гэдэг ийм саналыг би зарчмын хувьд оруулж байгаа юм.

Ч.Ундрам: Эрдэнэбат гишүүн ээ, хуулиараа та заавал эндээс хасна гээд бүр зүйл, заалтаар нь хасах ёстой байхгүй юу. Тэгж байж энэ дээр нэмнэ гээд. Тэгэхээр яг л би энэ хуулийн дагуу л энэ Байнгын хорооны санал хураалтыг явуулахгүй бол наадах чинь ингээд болохгүй болчхоод байна.

С.Эрдэнэбат: Тэгэхээр харин энэ дээр зардал нь тодорхой байгаа шүү дээ тийм ээ. Өндөр төлбөртэй хувийн сургуулиудад олгож байгаа хувьсах зардал 100 орчим тэрбум төгрөг байгаа гэж. 38 тэрбум. Зураг төсөвгүй хөрөнгө оруулалтуудын зардал гээд саяын энэ 4 зардлаас хасах.

Үгүй ээ, тэгээд энэ дээр би нэг яах вэ, горимын нэг санал хэлмээр байгаа юм. Одоо ингээд нэг гишүүдээс хаанаас хасахаа өөрсдөө ол гээд ингээд тавьчхаад байгаа юм. Ажлын хэсгийн гишүүд тэгвэл яах гэж гарсан юм бэ? Энэ дээр чинь зохицуулалт хийх ёстой байхгүй юу. Эрэмбэлэх, өөрчлөх, энэ Байнгын хороо дотор зохицуулалт хийх гэдэг ийм ажиллагаа дутаад байгаа болохоос би зарим талдаа энд тэндхийн зардлаас хасна гэхэд хэцүү харагдаж байгаа. Гишүүд хооронд ч гэсэн зөрчил гарах нь байна шүү дээ. Түүрүүн ингээд нэг салбараас нөгөө салбар луу татах гээд. Тийм учраас уул нь яах вэ ийм боломжийг би ажлын хэсэг гаргаж өгсөн бол гишүүд хооронд, Байнгын хороод хооронд ийм зөрчил үүсгээд байхгүйгээр л уг нь шийдэх боломж байгаа. Магадгүй нэг төсвөөс 100 хувь хасах биш энд тэндээс цуглуулж авчирч ирж байгаад, багш, ажилчдынхаа ажилласан гүйцэтгэлийн үнэлгээ 80 тэрбумыг хасахгүйгээр өөр ийм ийм зардлуудаас хасъя гэдэг боломжийг нь энэ Сангийн яам, ажлын хэсгүүд хооронд ярьж байгаад гаргаж ирвэл уг нь юу байгаа. Би тэгээд сая харж байгаад заавал нэг зардал хас гэхээр ийм л юм харагдаж л байна л даа.

Ч.Ундрам: Энэ дээр бид нар хэлэлцүүлэг хийх ямар ч дэг байхгүй. Та ерөөсөө та 2 тусдаа уулздаг юм уу, яадаг юм. Та яг ийм хасуулах зүйл заалт л хэлэхгүй бол энэ саналыг хураалгах боломжгүй, дэгээрээ. Тийм учраас тийм, албан бичгээр ажлын хэсэгт өгчхөж болно. Би давхар ажлын хэсгийн даргад нь ч

гэсэн хэлээд өгье. Тэгээд та өөрөө уулзаад явахгүй бол одоо ингээд дэгээрээ бид нар дараагийн асуудалдаа орохгүй бол тодруулах ч дэг байхгүй, Эрдэнэбат гишүүн ээ. Та одоо нэг бол надад яг зүйл заалтаа өгөөд саналаа хураалгаад явна. Эс үгүй бол хэдүүлээ ядаж энэ дагаж гарч байгаа Улсын Их Хурлын тогтоолын төсөл байгаа шүү дээ. Түүн дээр та саналаа манай энэ референтүүдтэй зөвлөлдөж байгаад гаргаад хураалгаж болно. Тийм л 2 асуудал байна. Болохгүй, одоо бол болохгүй, яг энэ төсөв дээр болохгүй. Бид нар санал хураасан ч хэн ч хаана ч хэлэлцэхгүй. Үндэслэлийг чинь би аягүй сайн ойлгоод байна. Төсвийн хууль чинь яг одоо батлагдчихсан хууль чинь төсөв хэлэлцдэг хууль чинь яг л ийм л дэгтэй байхгүй юу.

Тэгэхээр та энэ дэгийн хуульд өөрчлөлт оруулж болно. Бид нар чинь 3, 4 төсөв хэлэлцээд нэг туршлагатай болчихлоо, энийг сайжруулах ёстой юм байна гэдгээ ойлгоод авчихсан байгаа юм чинь санаачлаад энэ хууль дээр өөрчлөлт оруулаад ингээд явж болно. Тэгэхээр яг одоо бол бид нар нэгэнт батлагдсан байгаа хуулиараа л явахгүй бол болохгүй болчихоод байна.

Та ирээд хэлчих. 2 дугаар асуудалдаа орно. Би та нарт хангалттай яриулаад байгаа шүү, тийм ээ, яамдаа.

Одоо дараагийн. Энэ юу яах ёстой юм байна. Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бум-Очир Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай энэ төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

12.26 цаг

Та зүйл заалтгүй юмыг чинь би болохгүй шүү дээ. Үгүй ээ, хасах заалт нь байхгүй шүү дээ. Та 2 уулзаад ярь. Одоо бусад хүмүүсээ юу яа. Наранбаяр сайд аа, сууя.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэгт хүчингүй болсонд тооцох тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хэвээрээ юу. Түрүүний хүмүүс хэвээрээ байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо энэ хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэх ёстой. Тэгэхээр зүйл бүрээр нь хэлэлцэнэ. Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас асуулт асууж болох юм байна.

Тэгэхээр би 1 дүгээр зүйл дээр асуулт байна уу гээд асуухаар та хэд маань асуулт байна гээд зүйл бүрээр нь асууж болох нь байна шүү. Дараа нь, үүний дараа.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье.

1. Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл. Энэ төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Байхгүй.

Энэ хуулийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Зөрчлийн тухай хууль дээр. Байхгүй тийм ээ.

Энэ хуулийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Дараагийн хууль. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Энэ хуулийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Байхгүй.

2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Байхгүй.

3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Тусгай сан шүү дээ. Байхгүй.

Саяын энэ хуулийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

3. Төрийн хэмнэлтийн.

Энэ тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах зарчмын зөрөөтэй санал ирсэн байна. Бум-Очир гишүүнээс санал ирсэн байна.

Санал нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “Кино урлагийг дэмжих сан” гэснийг 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийн 5.3.13 гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.9, 5.3.13 дахь заалт, 13 дугаар зүйлийг тус тус хүчингүй болгосонд тооцсугай гэдгийг. Ер нь бол үндсэндээ Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь буцаая гэсэн ийм санал гаргасан юм байна. Саналаа тайлбарлая, Бум-Очир гишүүн.

Д.Бум-Очир: Баярлалаа. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай энэ ерөөсөө заалт нь соёлын салбарын 2 сангийн тухай л байгаад байгаа юм. 2 санг татан буулгах. 1 нь Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сан, нөгөөдөх нь Кино урлагийг дэмжих санг татан буулгах тухай асуудал байгаад байгаа юм. Өнгөрсөн чуулган дээр та бүхэн санаж байгаа байх. Соёлын тухай хууль, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тухай хууль, Кино урлагийг дэмжих тухай хуулийг Их Хурлаар хэлэлцэхийг дэмжихгүй гэдэг шийдвэр Их Хурлаас гарсан. Гишүүд үүнийг хэлэлцэх шаардлагагүй гээд.

Хэрвээ хэлэлцэх шаардлагагүй болчхож байгаа бол бид нар яг үүнтэй холбоотой Засгийн газраас орж ирсэн Засгийн газрын тусгай сангийн тухай энэ хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүй болчхож байгаа юм гэдгийг 1 дүгээрт, хэлмээр байна.

2 дугаарт, юу вэ гэхээр энэ 2 сан дээр 25 онд ямар ч төсөв тавигдаагүй байгаа. Тэгээд энэ төсөв хэлэлцэхэд ямар ач холбогдолтой юм. Яагаад энэ 20 хэдэн сангаас энэ 2 санг нь татан буулгах гээд энэ санал, энэ танилцуулга дээрээ татан буулгах гээд байна л даа. Тэгэхээр ямар ч юу гэдэг юм, ач холбогдолгүй зүйл болон хувирч байгаа юм гэдгийг хэлмээр байна. Төсөвт ямар ч өөрчлөлт орохгүй.

Нөгөө талдаа бас нэг зүйл бид нар яриад байгаа. Яах вэ, төсөв дээр мөнгө тавиагүй байж болно. Гэхдээ энэ салбарын хууль энэ юмнуудыг чинь өнгөрсөн 4 жил соёлын салбарынхан арай гэж манай Байнгын хорооны, өмнөх Байнгын хорооныхон ч гэсэн мэдэж байгаа. Арай гэж батлуулсан. Энэ бол манай соёлын салбарт гарсан нэг өрөм нь ахиц дэвшил нь байхгүй юу. Тэгэхээр ингээд одоо ямар үндэслэлээр юм мэдэхгүй. Энэ 20 хэдэн тусгай сангаас 2-ыг нь татан буулгах санал оруулаад ирж байгаа нь жаахан зарчмын хувьд ойлгомжгүй байгаа юм. Хэрвээ тэр 20 хэдэн сангаа бүгдийг нь татан буулгах гэж байгаа бол нэг нэгээр нь ярья л даа. Аль нь идэвхгүй байгаа юм, аль нь асуудал гараад байгаа юм гэдгийг.

Түүнчлэн энэ тусгай сан дээр ямар тохиолдолд татан буулгах вэ гэдэг заалт байгаа. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.6. тусгай санг дараах үндэслэлээр татан буулгана гээд. Тусгай сан анх байгуулагдсан зорилгоо биелүүлээд дуусчихсан бол өөрчлөн зохион байгуулсан бол эс үгүй бол би тоог нь дурсахгүй байна шүү. Тусгай сангийн үйл ажиллагаа нь доголдсон үр ашиггүй болох нь тогтоогдсон бол тэгээд мөн Засгийн газрын сангийн хууль тогтоомж зөрчсөн бол гэсэн чинь. Тэгэхээр яг ийм тусгай санг татан буулгах тийм зөрчил үүссэн эсэхийг нь мэдмээр байгаа юм. Миний бодлоор ямар ч тийм тайлбар алга. Яам, холбогдох яам энэ дээрээ тайлбараа хэлэх болов уу. Үнэхээр тэр яам нь идэж уусан, зөрчил гаргасан тийм асуудал байгаа бол бид нар энийг магадгүй татан буулгах хүртэл асуудал ярьж болох байх.

Сүүлд нь нэг зүйл хэлмээр байна. Энэ соёлын салбарт байгаа олон асуудлуудыг яриад байгаа. Бид дандаа уул уурхайн орон гээд хөгжөөд байгаа. Хэчнээн жил солонгоруулах гэж яриад байгаа. Солонгорох боломжтой нэг салбар нь энэ соёлын салбар шүү дээ. Энийг солонгоруулчихмаар байгаа байхгүй юу. Тэр киногоо хийгээд чадвал тэр олон улсад зараад хэдэн төгрөг төсөвтөө нэмэрлэмээр байна шүү дээ. Тэгээд энэ чинь энэ соёлын салбарын эдийн засгийг сэргээх гээд энэ салбарынхан сүүлийн хэдэн жил ажиллаж байгаа гэдгийг би хэлмээр байна.

2-т, энэ хувийн хэвшлийг дэмждэг юм байгаад байгаа шүү дээ. Энэ уран бүтээлчид гээд байгаа нэг жүжигчин ч юм уу, уран бүтээлч бүх мөнгийг нь авчихдаг юм биш шүү дээ. Нэг студи байгаа, нэг компани байгаа, нэг продакшн байгаа. Энэ хэдэн улсууд бүгд шүү дээ. Тэгэхээр бид нар хэчнээн жил хувийн хэвшлээ дэмжье гэж ярьж байж энэ хувийн хэвшилдээ дэмжлэг олгохгүй ийм байдал үүсчхээд байгаа юм.

Дараагийн нэг зүйл юу вэ гэхээр өнөөдөр та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Бид нар даяаршлын соёлын орон зайд амьдарч байгаа шүү дээ. Монголоор дүүрэн гаднын соёл Монголын соёлыг дарангуйлах ийм хэм хэмжээнд хүрчихсэн,

хүүхдүүд чинь өнөөдөр эхнээсээ Монголоороо гэхээсээ илүү англиараа хоорондоо яриад гудамжинд явж байгаа шүү дээ. Энэ Монголын соёлын орон зайг тэлэхэд маш чухал үүрэгтэй ийм зүйл байгаа юм.

Дараагийн нэг зүйл юу вэ гэхээр үүний хүрээнд бид нар үндэсний соёлын дархлаагаа бэхжүүлэх тухай асуудал яригддаг юм гэх мэтчилний би энэ 2 сангийн ард байгаа ач холбогдол, үүрэг, элдэв зүйлийг бүгдийг нь тайлбарлаад байж болохоор байна. Та бүхэн ч гэсэн мэдэж байгаа болов уу гэж бодож байна. Миний хамгийн харамсаж байгаа зүйл юу гэхээр ямар ч төсөв тавихгүй байж байж, яахаараа энэ салбарын хуулийг нь оролдох гээд оруулаад ирчихсэнийг би ойлгохгүй байгаа юм. Ямар санаа байгаад байгаа юм. Салбар луу нь дайраад байгаа юм уу, сайд руу нь дайраад байгаа юм уу. Дайрмаар байгаа бол онож дайрмаар байна. Яагаад энэ соёлын салбар луугаа дайраад байгаа юм. Яагаад ямар ч зүв зүгээр байж байгаа, төсөвтэй хамаагүй энэ салбарынхаа юу гэдэг юм тэр 2 санг нь татан буулгахаар, хаанаас гарч ирсэн ямар санал юм. Ойлгомжгүй байгаа юм. Цаашдаа ийм юм байж болохгүй ээ гэж бодож байна. Баярлалаа.

Ч.Ундрам: Эх хэл, түүх, соёл байж байж л үндэстэн оршдог. Тэгэхээр бид нар ийм соёлоо ойлгодог, үүнийхээ тэр их чухал байдлыг нь мэддэг тийм улс орон үндэстэн байх ёстой. Тэгээд энэ рүү чиглэсэн төсвүүдийг ямар зорилготойгоор дайраад байдгийг бас ойлгохгүй байгаа. Маш бага мөнгө байгаа шүү дээ. Бусад салбартай харьцуулбал. Тэгээд одоо яах вэ, бүх төсвийг нь хасчхаад байдаг. Сангаа хэвээр нь үлдээчхээч ээ бид нар өөрсдөө мөнгөө олоод энэ сангийнхаа үйл ажиллагааг тэгээд үргэлжлүүлээд салбаруудаа дэмжээд явъя гэдэг ийм л асуудал ярьж байгаа гэж ойлгож байгаа, тийм ээ.

Салбарын яамнаас нэг тайлбар өгчих. Тэгээд санал хураалт.

Ч.Номин: Баярлалаа. Бум-Очир гишүүнтэй 100 хувь санал нэг байгаа. Тэгээд энэ дээр нэмж хэлэх юм байхгүй. Зүгээр би ганцхан зүйлийг энэ яг сантай холбогдуулаад хэлье гэж бодож байна. Эдийн засгийн үр өгөөжийг нь дурдчихъя гэж бодлоо. Бид нар 3 гаруй тэрбум төгрөгийн зарцуулалтыг хийж одоогийн байдлаар 26 гаруй уран бүтээлчдийн олон улсын тавцанд гаргахад, уран бүтээлийг гаргахад дэмжсэн бол нөгөө талдаа Монгол Улсын эдийн засагт өнөөдрийн байдлаар шууд 12 тэрбум төгрөгийн эдийн засгийн эргэлтийг яг энэ 3 тэрбум төгрөгөөс улбаалан орж ирсэн. Цаашлаад аялал жуулчлалын салбарт бас эдийн засгийн эргэлтийг бий болгосон байгаа гэдгийг хэлмээр байна.

Тэгэхээр энэ соёл урлагийн салбар бол өөрсдөө шууд эдийн засгийн эргэлт бий болгохоос гадна дам нөлөөгөөр олон салбарт нөлөөлж чаддаг, эдийн засгийн эргэлтийг бий болгож чаддаг ийм салбар байгаа гэдгийг нэмээд хэлчихье. Тэгэхээр сангийн үр өгөөжийн хувьд үр өгөөжтэй буюу 1 төгрөг зарцуулсан болгон нь буцаад 4 төгрөг болгож эдийн засгийн өгөөжийг бий болгож байгаа гэдгийг хэлье.

Ч.Ундрам: Сангийн яамнаас хүн байна уу? Байхгүй, хэлэх юм байхгүй гэж байгаа юм байна.

Бум-Очир гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая.

76 хувиар Бум-Очир гишүүний саналыг дэмжлээ.

Дараа нь энийгээ хамгаалах ажил болговол.

Саяын хуулийг хэлэлцэж дууслаа, тийм ээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ. Энэ хуулийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Байхгүй.

Энэ хууль. Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Нэг хэмнэлтийн хуулийг яангуут хуульд байдаг маш олон зүйлүүд ингээд хасаад байгаа юм. Бүх байгууллагууд хамтын гэрээ хэлэлцээр байгуулаад, байгууллага байгууллага дээрээ боломж байвал, үр дүн байвал тэрийг нь нэмээд түрүүний миний ярьдаг тэр хөдөлмөрийн аюулгүй байдлын зардлыг үлдээгээч ээ гэдэг дээр санал ч хураалгасангүй. Бүхэл бүтэн боловсролын салбар байж байж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардал дээр 1 ч төгрөг байхгүйгээр хасаж байна гэдэг бол би харамсаж байна. Энэ дээр харин хассан хүмүүс тэр хүүхэдтэй, орчинтой холбоотой осол аваар, элдэв янзын асуудал гаргаад, одоо энэ хойшоо 7 буудал руу, 5 буудал руу та нар очоод үзээрэй дээ. Тэнд хүүхэд хичээл үзэх байтугай тэнд маш их хордлого, хүнд металлын илэрц юунаас гарч байгаа. Тэгээд ингээд харангуут хэмнэлтийн хууль дээр хуульд туссанаас бусад зардлыг яахгүй гээд маш олон хамтын гэрээ хэлэлцээр дээр байгаа зардлуудыг хасаад байгаа юм.

Тийм учраас энэ хэмнэлтийн хууль дагаж гарч байгаа хууль дээр, хууль дээр байж байгаа зардлаас бусад тэр хамтын гэрээ хэлэлцээртэй холбоотой энэ зардлуудыг хасахыг би дэмжихгүй байгаа юм. Тийм ч учраас энэ хэмнэлтийн хуулийн зарим хэсгийг нь өөрчлөн зохицуулахгүй бол одоо хүмүүс тэр тэмцээн, уралдаан хийхгүй гэж байгаа юм. 10 жилийн сургуулийн хүүхдүүд тэмцээн, уралдаан, наадам, багш ажилчдыг юуны хийж байгаа юмыг энэ чинь тэмцээн, уралдаан хийж байж хөгждөг салбар шүү дээ. Урлагийн үзлэг бараг хийхгүй гэдэг ч юм уу, нэг хэт ингэж хавтгайрч тавьснаараа зарим салбарын онцлогийг харгалзахгүйгээр хэмнэлтийн хууль гэдэг нэрийдлийн дор бүгдийг нь хасаад хаячхаж зарчим тавьж байгаа буруу.

Төрийн албан хаагч нар заавал тэмцээн, уралдаан энэ яам, Тамгын газрын хүмүүс тэмцээн уралдаанаас хойшлуулж байж болно. Яг энэ боловсрол, соёлын салбар чинь өөрөө тэмцээн, уралдаан, уулзалт, ярилцлага, ойлголцож байж юм явдаг салбар байхгүй юу. Тийм учраас энэ хуулиуд дээр хэт хавтгайрч нэг талдаа гардаг нь би эргээд сөрөг үр дагавар гаргах вий дээ гэдэг дээр манай салбар энэ соёл, боловсролын салбар өөрөө онцлог салбар учраас би нэг онцолж хэлье гэж бодсон юм.

Ч.Ундрам: Ер нь зарчмын санал хэллээ шүү дээ, Эрдэнэбат гишүүн. Тэгээд энэ асуудлыг түрүүн бас Мөнхтуяа гишүүний саналтай энэ таны энэ санал хураалгах гээд байгаа 4 тэрбумын хөдөлмөрийн аюулгүй байдлын зардал чинь ерөнхийдөө 1 шүү дээ. Тэгэхээр энэ 2 гишүүнтэйгээ Наранбаяр сайд аа, уулзаад, та өөр эх үүсвэрээс мөнгө олоод энэ ажлыг хийнэ шүү. Баярлалаа.

Хуулийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Байхгүй.

Хуулийн 3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Хуулийн 4 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Байхгүй.

Саяын хуулийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

4. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Энэ төсөл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? 1 зарчмын зөрөөтэй санал ирсэн байна тийм ээ, Мөнхтуяа гишүүний.

Саналын томъёолол энийг нь л унших юм уу тийм ээ. Энэ тогтоолын төсөлд 4 дүгээр зүйл бүхлээр нь шинээр нэмье ээ гэсэн ийм санал ирсэн юм байна.

4. Боловсролын салбарт зарцуулах төсвийг нэмэгдүүлэх, НҮБ-аас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилго 2030, Боловсрол 2030, Инчоны тунхаглалын зорилтыг хэрэгжүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ хангамжийг сайжруулах, багш, ажилтны хөдөлмөрийн нөхцөлийг шинэчлэн тогтоох, цалин хөлсийг тооцох шинэ аргачлал нэвтрүүлэх, нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар Л.Оюун-Эрдэнэд даалгасгай.

4.1. 2026 оны төсвийн жилээс эхлэн боловсролын салбарын төсвийн нийт зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 6 хувиас багагүй, эсвэл улсын төсвийн нийт зардлын 18 хувиас багагүй байхаар тооцон боловсруулж өргөн барих

4.2. ажлын байрны эрсдэлд суурилсан хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийх ажлыг салбарын нийт багш, ажилтны 10-аас доошгүй хувьд хийхэд шаардагдах зардлыг шийдвэрлэх, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах гээд.

Саналаа Мөнхтуяа гишүүн тайлбарлая.

Ц.Мөнхтуяа: Боловсролын салбар 90 гаруй мянган багш, ажилтан ажилладаг, 1 сая хүүхэд суралцдаг маш том салбар. Энэ дээр сая түрүүн Жавхлан сайд хэлээд байсан, өөрөө байхгүй байна. Их том мега төсөл гэж тоглоом маягаар хэлээд байна лээ. Энэ нэг 1 сая хүүхэд суралцдаг, 90 гаруй мянган багш, ажилтан ажилладаг энэ том салбарт 4 их наяд төгрөг нэг их мегасаад байх, гайхуулаад байх мөнгө биш. 1 сая хүүхэд 90 гаруй мянган багш, ажилтан ажилладаг энэ том салбарт дөрөвхөн их наяд төгрөг тавьчхаад том мега төсөл явж байна гээд шоолоод инээгээд байгаа Сангийн сайдад би гайхаж байна. Ингэж болохгүй 1 дүгээрт, энийг би бүр хатуу хэлмээр санагдлаа.

Тэгээд ер нь бид боловсролын салбараас харамлаж байна гэдэг бол Монголын ирээдүйд хийж буй гэмт хэрэг гэж үзэж байна. Үнэхээр миний бүр эгзoor хөдөлж байна шүү. Тэгээд энэ тогтоолын төслийн энэ 5 дээр би нэг гайхаад байна. Төсөв дотор бол 152 тэрбум хасчихсан гээд байгаа юм. Үүний хар аа, Засгийн газрын 53 дугаар тогтоолын 5 дугаар, 5-ын А дээр ингэж байгаа юм. Боловсролын салбарын 1 хүүхдэд ноогдох хувьсах зардлаар санхүүжүүлэх арга хэмжээ, сургууль, цэцэрлэг, дотуур байрны хоолны материал худалдан авах, гадаад,

дотоодын их, дээд сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол олгох, сургуулийн суралцагчид тэтгэлэг олгох, төрийн өмчийн их, дээд сургуулиудын тогтмол зардлыг төлөх, боловсролын салбарын ажилтнуудыг чадавхжуулах сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж олгох олимпиад зохион байгуулах. Энэ бүх мөнгөнөөс нь ингээд хасаж байгаа юм байна. Танаж байгаа юм байна, хумьж байгаа юм байна.

Тэгээд одоо 1 хүүхдэд оногдох үдийн цайны нэг мянга таван зуухан төгрөгөөс нь төр нь 150 төгрөгийг нь хумсалж байгаа юм байна. Дотуур байрны хүүхдийнх нь мөнгөнөөс хоолны мөнгөнөөс хумсалж байгаа юм байна. Ингээд хумслахгүй бол болохгүй байгаа юм байна, боловсролын салбараас. Энэ дээр би үнэхээр харамсаж байна. Энийг болиоч ээ гэдгийг л би бүр дахин дахин хэлмээр байна. Гишүүд ч гэсэн энэ дээр дэмжмээр байна. Жишээ нь, ингэж байна шүү дээ. Салбарын багш, ажилтнуудыг чадавхжуулах, мөн сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж гэдэг чинь нөгөө 15 жил ажилласан багш, ажилтны 1 хүүхдийг төрийн өмчийн их дээд сургуульд үнэ төлбөргүй сургана гэсэн энэ сургалтынх нь буцалтгүй тусламжаас хүртэл хумсалж байгаа юм байна.

Тэгэхээр энэ дээр ер нь Их Хурлын гишүүд минь энэ боловсролын салбар дээрээ бүгдээрээ нэг акцлаад, ач холбогдол өгөөд, дэмжээд өгөөч ээ. Миний энэ саналуудыг дэмжээд, энэ зарчмын зөрөөтэй саналыг маань ингээд дэмжээд өгөөч ээ гэдгийг л уриалмаар байна. Хамгийн гол нь сая Ундрам дарга бүгдийг нь уншчихсан. Тийм учраас дахин дахин би уншаад яах вэ. Энийг дэмжиж өгөөч ээ. Бид нар ирээдүйгээсээ харамлаж болохгүй ээ гэдгийг л дахин дахин хэлье. Баярлалаа.

Ч.Ундрам: Энэ дээр ер нь сайдаас нь заавал тайлбар авдаггүй юм. Дэгээр, ер нь бол, тийм. Та хэд бүх асуух юмаа асуучихсан гэж үздэг байхгүй юу. Энэ зүгээр Мөнхтуяа гишүүн ээ. Энэ нөгөө нэг тогтоолын төслийн 1 дүгээр асуудлыг 4.1-ийг бол дэмжээд байгаа юм. 4.2 нь болохоор ажлын байрны эрсдэлд суурилсан үнэлгээ гээд нөгөө түрүүний тохирчихсон тийм ээ. Тэгэхээр энэ 4.1-ээр нь санал хураачих уу. 4.2 нь эндээ байх юм уу. Таны саналд. Хасчих уу? Энийг нь тэгвэл хас, би сая уншчихсан шүү дээ.

Ямар ч л байсан энэ нөгөө Засгийн газарт өгч байгаа тогтоолын төсөлд нь ийм өгүүлбэрийг нэмье ээ. Ийм, зүйл заалтыг нэмье ээ гэдэг саналыг Мөнхтуяа гишүүн өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд гаргасан. Тэгэхээр энэ дээр та бүхэн маань дэмжих эсэх саналаа өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд гаргаж болно.

Мөнхтуяа гишүүний саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Дэг, дэг шүү дээ. Мөнхтуяа дарга аа. Дэгээрээ л явъя.

Энэ дээрээ юу. Тэгвэл тэгье. Найруулгыг нь ингэж өөрчилье тийм ээ. Энэ хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл ахуйн зардлыг холбогдох хуулийн дагуу, хуульд заасны дагуу дараа дараагийн жилийн төсөвт суулгаж өгөх гэдэг ийм томьёоллоор орууллаа шүү. Би яг сая уншчихлаа шүү дээ, протоколд. Тэгэхээр 4.2 чинь ингээд үлдчихэж байгаа юм. Та 2-ын санал ч гэсэн энэ ингээд орчхож байгаа юм байна.

Саяын саналыг дэмжих саналын томьёоллоор санал хураая.

Нийт гишүүдийн хэдэн хувь гэж байна, 69 хувь нь дэмжсэн.

Галбадрах гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглээрэй.

Засгийн газарт чиглэл өгөх тухай Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Сүүлийн асуудал. “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Энэ тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй.

Саяын тогтоолыг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэд. Наадах чинь дахиад нэг юм байгаа юм биш үү. Их Хурлын тогтоолын төсөл дээр 3 санал ирчихсэн байгаа юм биш үү? Хамгийн сүүлийн асуудал дээр нь. Энэ дээр ингээд 3 санал хураалт. Мөнхтуяа гишүүний дахиад нэг санал байгаа юм байна.

Энэ саналын томъёолол нь тогтоолын 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн А заалтаас боловсролын салбарын 1 хүүхдэд ноогдох хувьсах зардлаар санхүүжих арга хэмжээ, сургууль, цэцэрлэг, дотуур байрны хоолны материал худалдан авах гэснийг хасаж, гадаад, дотоодын их, дээд сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургуулийн суралцагчид тэтгэлэг олгох, төрийн өмчийн их, дээд сургуулиудын тогтмол зардлыг төлөх, боловсролын салбарын ажилтнуудыг чадавхжуулах сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж олгох, олимпиад зохион байгуулах гэж өөрчлөх санал гарсан байна.

Саналаа тайлбарлая, Мөнхтуяа гишүүн ээ.

Ц.Мөнхтуяа: Түрүүний нөгөө миний уншсан юун дотор байгаа. Энэ нөгөө түрүүн ч би сая дурдчихсан л даа. Их, дээд сургуульд нөгөө үнэ төлбөргүй сургана гээд Боловсролын ерөнхий хууль дээр орчихсон байгаа шүү дээ. Тэр тэтгэлэг, буцалтгүй тусламжаас хасна гэж би ойлгоод байгаа юм. Зөв үү, буруу юу? Тэгээд энэ хүүхдүүдийн нөгөө хувьсах зардал байгаа шүү дээ. Хоолны мөнгө, дотуур байрны зардал гээд. Ингээд бүх хувьсах зардлуудаас нь 10 хувь танаж байгаа юм байна гэж ойлгож байгаа. Тэр миний ойлголт зөв үү, буруу юу? Энэ хууль хуульдаа болохоор 152 тэрбум гэгчхээд, хууль дагасан тогтоол гэж нэг юм оруулж ирээд, нөгөө гуя дагаж хүзүү гэгчээр, тогтоол дээрээ ийм хуулийн хулгай хийчихсэн байгаа харагдаад байгаа байхгүй юу. Яг би өөрөө энийг хараад байхаар. Тэгэхээр энэ дээр нарийн тайлбар би Боловсролын яамнаас авмаар байна. 152 тэрбум төгрөг дотор чинь саяын миний энэ дурдсан асуудлууд орсон уу?

Ч.Ундрэм: Асуултаа асуухгүй, өөрийнхөө л саналыг.

Ц.Мөнхтуяа: Ер нь тэгж би бодоод, ойлгоод энэ дээр ийм зарчмын зөрөөтэй санал оруулж байгаа юм. Тэгээд энийг гишүүд минь дэмжиж өгөөрэй. Энэ бол ер нь хүүхдээс л хулгай хийсэн, хумсалсан, ийм буруу тогтоол байна гэж би үзсэн учраас энэ дээр зарчмын зөрөөтэй санал оруулж байгаа шүү.

Ч.Ундрэм: Мөнхтуяа гишүүний оруулсан зарчмын зөрөөтэй саналыг дэмжих гэсэн томьёоллоор санал хураая.

Нийт гишүүдийн 46,2 хувь нь дэмжлээ. Тийм учраас саяынх батлагдсангүй.

Дараагийн саналын томьёолол нь энэ. Би гаргасан байна. Улсын Их Хурлын гишүүн Ундрэм. Энэ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн 2024 онд зарцуулаагүй үлдэгдлийг 25 оны төсвийн эх үүсвэрт зарцуулах гэж байгаа юм. Энэ нөгөө өнгөрсөн жил зарцуулаагүй үлдэгдэл байгаа шүү дээ. Тэрийг нь энэ жил, ирэх жил зарцуулчихъя гэдэг ийм асуудал байгаад байгаа юм. Тийм. Тэгэхээр энэ дээр ер нь энэ өнгөрсөн жилийн бас үлдэгдэл чинь зарцуулаагүй ч биш нөгөө буцаж олж авсан мөнгө нь бас байгаа байхгүй юу. Эргэн төлөлт, тийм. Тэгэхээр тэрийг нь нөгөө улс хураагаад авчихна шүү дээ, бид нар, энэ тогтоолыг оруулахгүй бол. Ер нь хуулийнхаа дагуу хууль дээр боломж байгаа. Эргэлтийн сан учраас, тийм. Тэгэхээр тогтоол дээр энийг нь нөгөө зарцуулах эрхийг нь нээгээд өгчихье гээд.

Дахиад санал гаргачих нэг нь. Бум-Очир санал гаргачих.

Саяын энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая.

Гишүүдийн 84,6 хувь нь дэмжсэн учраас саяын санал дэмжигдлээ.

Галбадрах багш дэмжсэнээр протоколд тэмдэглэгдэх юм байна.

Дараа нь Засгийн газрын тусгай сангийн тухай хууль хуулийн хүрээнд Кино урлагийг дэмжих сангийн 2024 онд зарцуулаагүй үлдэгдлийг 2025 оны төсвийн эх үүсвэрт зарцуулах гэсэн энэ саналыг хэн оруулж байгаа юм. Бум-Очир гишүүн оруулж байна.

Бум-Очир гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт 6,2 байгаа. Тийм. Санал хураалтыг эхэлье.

Хамгийн сүүлийн санал нь Үүрийнтуяа гишүүний санал байгаа юм.

Энэ Улсын Их Хурлын тогтоолын 1 дүгээр бүлэг 3 дахь заалтаас сургууль, цэцэрлэг, дотуур байрны хоолны материал худалдаж авах гэснийг хасах гээд. Энэ Мөнхтуяа гишүүний саналтай адилхан санал дахиж орж ирж байна. Мөнхтуяа гишүүнийх чинь сая дэмжигдээгүй. Энэ 3 дахь заалт нь болохоор 3-ын А заалтыг та хэдэд уншиж танилцуулах юм бол энэ 5-ын А гэж байгаа юм байна шүү дээ. Боловсролын салбарын 1 хүүхдэд ноогдох хувьсах зардлаар санхүүжих арга хэмжээ, сургууль, цэцэрлэг, дотуур байрны хоолны материал худалдан авах, гадаад, дотоодын их, дээд сургууль яг таны санал байна. Мэргэжлийн болон техникийн боловсрол олгох, сургуулийн суралцагчдад тэтгэлэг олгох, төрийн өмчийн их, дээд сургуулиудын тогтмол зардлыг төлөх, боловсролын салбарын ажилтнуудыг чадавхжуулах, сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж олгох, олимпиад зохион байгуулах гэдэг ийм зардлуудыг гаргахгүй ээ. 10 хувиар бууруул гэдэг ийм тогтоол гаргаж өгөөч ээ гээд Засгийн газар өргөн барьсан байгаа байхгүй юу.

Энийг Мөнхтуяа гишүүн эсэргүүцээд, бид нар бууруулахгүй ээ ингээд төсвөөрөө явах ёстой гэдгээр санал хураалгаад та бүхэн дэмжээгүй.

Үүрийнтуяа гишүүн энийг дахиад санал оруулсан байна. Тэгэхээр энэ Үүрийнтуяа гишүүний гаргасан зарчмын зөрөөтэй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураая.

Нийт гишүүдийн 69,2 хувь нь зөвшөөрсөн учраас саяынх батлагдлаа.

Саяын Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд болон Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бум-Очир Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

12.57 цаг

Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ